



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

VISION
ZERO
FUND

SCORE

► Жижиг, дунд аж ахуйн нэгжид
хөдөлмөрийн аюулгүй байдал,
эрүүл мэндийг сайжруулах нь

СУРАЛЦАГЧИЙН ГАРЫН АВЛАГА



- ▶ **Жижиг, дунд аж ахуйн нэгжид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг сайжруулах нь**

СУРАЛЦАГЧИЙН ГАРЫН АВЛАГА

▶ ТАЛАРХАЛ

Энэхүү сургалтын багц нь Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын Хөдөлмөрийн удирдлага, хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хэлтэс ХУХ/ХАБЭМХ, ОУХБ-ын Өрсөлдөх чадвартай, хариуцлагатай аж ахуйн нэгжийг дэмжих хөтөлбөр (SCORE) болон Vision Zero буюу “Ослыг тэглэх алсын хараа” сангийн хамтын бүтээл юм. Сургалтын багцыг ХУХ/ХАБЭМХ-ийн Хөдөлмөрийн хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн Эндрю Кристиан, SCORE хөтөлбөрийн техникийн ажилтан Пранати Мехта, Vision Zero сангийн техникийн ажилтан Мария Е. Мунаретто нар тус сангийн Этиоп дахь техникийн ажилтан Эванс Лванга, ОУХБ-ын “Better Work” хөтөлбөрийн техникийн ажилтан Кесава Мурали Канапати нарын дэмжлэгтэйгээр боловсрууллаа.

Хөдөлмөрийн удирдлага, хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хэлтэс (ХУХ/ХАБЭМХ)

Хөдөлмөрийн удирдлага, хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан тус хэлтэс нь төр, ажил олгогчид болон ажиллагчдад тулгамдаж буй нэн тэргүүний асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх цогц стратеги боловсруулахыг зорьж ажилладаг. “Хөдөлмөрийн аюулгүй байдал + Эрүүл мэнд” тэргүүлэх хөтөлбөрийнхөө хүрээнд ОУХБ-ын түншлэгч талуудад мэдлэг бий болгох, үндэсний чадавхыг бэхжүүлэх, эрүүл, аюулгүй ажлын байрыг дэмжих тогтолцоо бүрдүүлэх, эрүүл, аюулгүй ажлын байрны эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх гэсэн стратегийн дөрвөн чиглэлээр дэмжлэг үзүүлдэг.

Өрсөлдөх чадвартай, хариуцлагатай аж ахуйн нэгжийг дэмжих хөтөлбөр (SCORE)

Энэ нь ОУХБ-аас жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн бүтээмж, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах зорилгоор хэрэгжүүлж буй олон улсын хөтөлбөр юм. Хөтөлбөрийн гол зорилго нь танхимын практик сургалтыг үйлдвэр дээр зөвлөн туслах үйлчилгээтэй хослуулсан аргачлал бүхий SCORE сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад оршдог. Дэлгэрэнгүй мэдээлэл: ilo.org/score

Vision Zero буюу “Ослыг тэглэх алсын хараа” сан

Vision Zero сан нь засгийн газрууд, ажил олгогчийн болон ажилтны төлөөллийн байгууллагууд, компаниуд болон бусад оролцогч талуудыг нэгтгэн, олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд ажил, хөдөлмөртэй холбоотой ноцтой болон амь насанд хүрэх осол, гэмтэл, өвчлөлийг тэг болгох алсын харааг хамтран хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Ингэхдээ олон улсын, үндэсний болон ажлын байрны түвшинд хүрч ажиллан эрүүл, аюулгүй ажиллагааг дэмжсэн орчин, нөхцөлийг бүрдүүлэх, үндэсний хууль тогтоомж, бодлогыг боловсронгуй болгох, ханган нийлүүлэлтийн тодорхой сүлжээнд ажиллаж буй эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, нөхөн төлбөр олгуулах илүү үр дүнтэй механизм хэрэгжүүлэхийг зорьж байна. Дэлгэрэнгүй мэдээлэл: ilo.org/vzf

© Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага 2025

Анхны хэвлэл 2025



Attribution 4.0 International (CC BY 4.0)

Энэхүү сургалтын багцыг Creative Commons Attribution 4.0 Олон улсын тусгай зөвшөөрлийн хүрээнд олон нийтэд нээлттэй байршуулсан болно (<https://creativecommons.org/licenses/by/4.0/>). Тусгай зөвшөөрлийн хүрээнд уг гарын авлагыг дахин ашиглах, нийтэд түгээх, нэмж өөрчлөх, хөгжүүлэх боломжтой. Ингэхдээ ОУХБ-ыг хэвлэлийн анхны хувилбарыг эзэмшигч гэдгийг тодорхой тусгаж өгнө. Дахин ашиглах, нийтэд түгээх, нэмж өөрчлөх, хөгжүүлэх тохиолдолд ОУХБ-ын логог ашиглахыг хориглоно.

Зохиогч – Сургалтын багцыг дараах байдлаар эшлэнэ: Жижиг, дунд аж ахуйн нэгжид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг сайжруулах нь, Женев: Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо, 2025. © ILO.

Орчуулга – Сургалтын багцыг орчуулсан тохиолдолд дараах тайлбарыг заавал оруулсан байх ёстой: Энэ нь ОУХБ-ын зохиогчийн эрх бүхий бүтээлийн орчуулга юм. ОУХБ нь энэхүү орчуулгыг бэлтгэж, хянаж, батлаагүй бөгөөд ОУХБ-ын албан ёсны орчуулга биш юм. Тус хувилбарын агуулга, үнэн зөв байдлыг ОУХБ хариуцахгүй бөгөөд орчуулан гаргасан зохиогчид бүрэн хариуцна.

Өөрчлөлт – Сургалтын багцын агуулгыг өөрчлөн гаргасан тохиолдолд дараах тайлбарыг заавал оруулна: Энэхүү бүтээл нь ОУХБ-аас гаргасан зохиогчийн эрх бүхий бүтээлийг өөрчлөн боловсруулсан хувилбар юм. ОУХБ нь энэхүү хувилбарыг бэлтгэж, хянаж, батлаагүй бөгөөд ОУХБ-аас албан ёсоор өөрчлөн боловсруулсан хувилбар биш болно. Тус хувилбарын агуулга, үнэн зөв байдлыг ОУХБ хариуцахгүй бөгөөд өөрчлөн гаргасан зохиогчид бүрэн хариуцна.

Гуравдагч талын материал – Энэхүү тусгай зөвшөөрөл нь гарын авлагад тусгагдсан ОУХБ-ын бус зохиогчийн эрхтэй хэсэгт хамаарахгүй. Хэрэв тус хэвлэлд эшлэгдсэн гуравдагч талын зохиогчийн эрх бүхий материалыг ашиглах бол эзэмших эрх болон аливаа зөрчлийн асуудлаар зөвхөн тухайн зохиогчид хандана.

Тусгай зөвшөөрлийн дагуу үүссэн, эвийн журмаар шийдвэрлэх боломжгүй аливаа маргааныг НҮБ-ын Олон Улсын Худалдааны Эрхийн Комиссын Арбитрын журмын дагуу арбитрын шүүхэд шилжүүлнэ. Маргааныг арбитрын шүүх эцэслэн шийдэх бөгөөд талууд шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй. Зохиогчийн эрх болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой аливаа асуудлаар ОУХБ-ын Хэвлэлийн албанд (Зохиогчийн эрх ба тусгай зөвшөөрөл) rights@ilo.org хаягаар хандана уу. ОУХБ-ын хэвлэл болон дижитал бүтээгдэхүүний талаарх мэдээллийг дараах холбоосоор авах боломжтой: www.ilo.org/publns.

ISBN: 9789220428030 (хэвлэмэл); 9789220428047 (веб PDF)

Энэхүү сургалтын багцын англи хэл дээрх хувилбар: Improving occupational safety and health in small and medium-sized enterprises: Practitioner Handbook, ISBN 9789220339619 (хэвлэмэл), 9789220339626 (веб PDF)

Франц хэл дээрх хувилбар: Améliorer la sécurité et la santé au travail dans les petites et moyennes entreprises: manuel du participant, ISBN 9789220342176 (хэвлэмэл), 9789220342046 (веб PDF)

Испани хэл дээрх хувилбар: Mejora de la seguridad y salud en el trabajo en las pequeñas y medianas empresas: manual du participante, ISBN 9789220342183 (хэвлэмэл), 9789220342039 (веб PDF)

Україн хэл дээрх хувилбар: ISBN: 9789220353103 (хэвлэмэл), 9789220353110 (веб PDF)

ОУХБ-ын мэдээллийн сан, хэвлэлд ашиглагдсан материал нь НҮБ-ын зарчимд нийцсэн бөгөөд ОУХБ-ын аливаа улс орон, нутаг дэвсгэрийн эрх зүйн байдал, эрх мэдэл, эсвэл тэдгээрийн хил хязгаарын талаарх илэрхийлсэн байр суурь, илэрхийлэл биш болно.

Хэвлэлд тусгагдсан үзэл, санаа бодол нь зөвхөн зохиогчийнх бөгөөд ОУХБ-ын үзэл бодол, байр суурь, бодлого биш юм.

Байгууллага, бүтээгдэхүүн, үйл явцыг эш татсан нь ОУХБ тэдгээрийг албан ёсоор хүлээн зөвшөөрснийг илтгэхгүй. Мөн бусад байгууллага, бүтээгдэхүүн, үйл явцыг дурдаагүй нь тэдгээрийг хүлээн зөвшөөрөөгүйн шинж биш болно.

Монгол улсад хэвлэв.

▶ АГУУЛГА

Товчилсон үг	8
Өмнөх үг	9
1. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн нөхцөл байдал: Тойм ба үндэслэл	10
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд: Тодорхойлолт ба үндсэн ойлголтууд	12
3. Эрсдэлийн үнэлгээ	26
Алхам 1: Аюулыг илрүүлж, шалтгааныг тогтоох	28
Алхам 2: Хэн, хэрхэн хохирч болохыг тодорхойлох	38
Алхам 3: Эрсдэлийг үнэлэх: Эрсдэлийг хянах арга хэмжээг тодорхойлж, сонгох	39
Алхам 4: Хяналтын арга хэмжээг хэн, хэзээ хэрэгжүүлэхийг бичиж тэмдэглэх	56
Алхам 5: Эрсдэлийн үнэлгээнд хяналт-шинжилгээ хийх, хянаж нягтлах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх	57
4. ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцоо	60
4.1 ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцоо (ХАБЭМУТ): Тодорхойлолт ба зорилго	60
4.2 Аж ахуйн нэгжийн ХАБЭМ-ийн бодлого	62
4.3 ХАБЭМ-ийг тасралтгүй сайжруулах	67
Сайжруулах санал	69
ААН-ийг сайжруулах төлөвлөгөөний загвар	70
Хэрэгцээт холбоос	71
Хавсралт	72

Энэхүү баримт бичгийг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр боловсруулав. Энд тусгагдсан үзэл бодол, байр суурь нь Европын Холбооны албан ёсны байр суурийг аливаа байдлаар илэрхийлэхгүй болно.

► Товчилсон үгс

- | | |
|--------------|---|
| ► АБМХ | Аюулгүй байдлын мэдээллийн хуудас |
| ► ДОХ | Дархлалын олдмол хомсдол |
| ► ДЭМБ | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага |
| ► ЖДААН | Жижиг, дунд аж ахуйн нэгж |
| ► ОУХБ | Олон улсын хөдөлмөрийн байгууллага |
| ► ХАБЭМ | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд |
| ► ХАБЭМУТ | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын тогтолцоо |
| ► ХДХВ | Хүний дархлал хомсдлын вирус |
| ► ХУХ/ХАБЭМХ | Хөдөлмөрийн удирдлага, хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хэлтэс |
| ► ХХХ | Хувийн хамгаалах хэрэгсэл |

► ӨМНӨХ ҮГ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд (ХАБЭМ)-ийн хамгийн өндөр стандарттай, эрүүл, аюулгүй орчинд ажилладаг урам зоригтой ажиллах хүч бүхий компаниуд хамгийн амжилттай, өрсөлдөх чадвартай байна. Түүнчлэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ зардал багатай, үр ашиг сайтай болох нь харагдаж байна.

Аль ч улс орны эдийн засагт жижиг, дунд аж ахуйн нэгжүүд (ЖДААН) чухал хувь нэмэр оруулдаг. Харин хүний болон санхүүгийн нөөц дутмаг, ХАБЭМ-ийн талаарх ойлголт, мэдлэг тааруу, бусад газрын сургалт, дэмжлэгт хамрагдахад хүндрэлтэй байдлаасаа болоод эдгээр аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдол өндөр байх хандлага ажиглагддаг. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин нь тэдгээрт өртсөн хүмүүсийг зовлон шаналалд унагаад зогсохгүй бүтээмж, эдийн засгийн өсөлтөд ч сөргөөр нөлөөлдөг.

ОУХБ суралцагчийн гарын авлага, сургагч багшид зориулсан удирдамж болон хичээлийн танилцуулгаас бүрдэх энэхүү сургалтын багцыг ХАБЭМ болон аж ахуйн нэгжийн хөгжлийн чиглэлээрх туршлагадаа тулгуурлан гаргасан юм. Сургалтын багцыг ОУХБ-ын, Хөдөлмөрийн удирдлага, хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хэлтэс (ХУХ/ХАБЭМХ), Өрсөлдөх чадвартай, хариуцлагатай аж ахуйн нэгжийг дэмжих хөтөлбөр (SCORE), Vision Zero сан болон Этиоп Улсын “Зохистой хөдөлмөр, хүртээмжтэй үйлдвэржилтийг дэмжих” хөтөлбөр (SIRAYE)-ийн ажилтнууд хамтран боловсрууллаа.

SCORE хөтөлбөрийн “ХАБЭМ – Бүтээмж нэмэгдүүлэх суурь” сэдэвт сургалтын модульд үндэслэсэн энэхүү гарын авлага нь ЖДААН-ийн ажилтнууд, ажил олгогчид, удирдах албан тушаалтнуудад ХАБЭМ-ийн үндсэн зарчим, ойлголт, үйл явц, арга хэрэгслийг танилцуулах зорилготой. Ингэснээр аж ахуйн нэгждээ эрүүл, аюулгүй ажиллагааны соёлыг төлөвшүүлж, ХАБЭМ-ийн нөхцөлийг тасралтгүй сайжруулдаг болоход нь туслах юм.

ЖДААН-ид ХАБЭМ-ийг байнга сайжруулж, үр нөлөөг нь тасралтгүй дээшлүүлэхийн тулд ажил олгогч, ажилтан болон тэдний төлөөлөл хоорондын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай. Өөрөөр хэлбэл “ХАБЭМ бол хүн бүрийн асуудал” юм.

Энэхүү гарын авлага ЖДААН-ийн ажил олгогчид, ажилтнуудын эрэлт хэрэгцээнд нийцнэ гэж найдаж байна.



Жоаким Пинтадо Нунес
ОУХБ-ын ХУХ/ХАБЭМХ-ийн
дарга



Майкл Элкин
SCORE олон улсын
хөтөлбөрийн менежер



Окерт Дюппер
Vision Zero сангийн Ерөнхий
менежер

▶ 1. ЖИЖИГ, ДУНД АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ: ТОЙМ БА ҮНДЭСЛЭЛ

Жил бүр дэлхий даяар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас 2.78 сая хүн амь насаа алдаж, хүний амь нас хохироогүй осолд 374 сая хүн өртөж байна.¹ Өөрөөр хэлбэл, өдөр бүр нэг сая гаруй ажилтан үйлдвэрлэлийн осолд өртөж гэмтдэг байна. Энэхүү цочирдуулам статистик зөвхөн албан ёсоор бүртгэгдсэн ажлын байранд гарсан ослын мэдээлэл болохыг анхаарах нь чухал. Бодит байдалд үүнээс ч олон үйлдвэрлэлийн осол гарч байгааг үгүйсгэх аргагүй юм.

“ЖДААН” гэдэгт 10-250 хүртэл ажилтантай аж ахуйн нэгжийг хамруулдаг бөгөөд улс орнууд харилцан адилгүй тодорхойлсон байдаг.

Статистикийн мэдээллээс үзэхэд жижиг аж ахуйн нэгжийн ажилтнууд том аж ахуйн нэгжид ажиллагчдаас илүү үйлдвэрлэлийн осолд өртөж, өвчилдөг байна. Ослын тоог 100-аас дээш ажилтантай аж ахуйн нэгжтэй харьцуулахад 20 хувиар, 1000-аас дээш ажилтантай аж ахуйн нэгжтэй харьцуулахад 40 хувиар илүү байна.² Аж үйлдвэржилт хурдацтай явагдаж байгаа хөгжиж буй орнуудад энэ зөрүү улам бүр их байна гэж үздэг.

ЖДААН-үүдэд ХАБЭМ-ийн удирдлага ерөнхийдөө тааруу, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байдаг нь дараах шалтгаантай. Үүнд:

- ▶ ХАБЭМ-ийн асуудал хариуцсан ажилтан байхгүй;
- ▶ ХАБЭМ-ийн үйлчилгээг гаднаас авах боломж хязгаарлагдмал;
- ▶ ЖДААН-үүд харьцангуй хурдан хугацаанд үйл ажиллагаа эхлүүлж, хаагдах хандлагатай байдаг тул ажил олгогч болон ажилтнуудын туршлага хомс;
- ▶ машин, тоног төхөөрөмжийн “аюулгүй” байдлыг хангах талаарх мэдлэг дутмаг;
- ▶ үйлдвэрчний эвлэлийн гишүүнчлэл бага. Үйлдвэрчний эвлэлтэй байх нь ХАБЭМ-ийн нөхцөл сайжрахад нөлөөлдөг;
- ▶ сайжруулалт хийхэд шаардагдах зардлын талаарх ойлголт. ЖДААН-ийн ажил олгогчид осол, өвчлөл, тэдгээртэй холбоотой гарах зардал, түүнчлэн ХАБЭМ, бүтээмж ашиг орлого хоорондын уялдааг бүрэн ойлгодоггүй.
- ▶ мэдээлэл авах, сургалтад хамрагдах боломж хязгаарлагдмал.

Барилга, жижиг хэмжээний уурхай зэрэг зарим салбарыг онцгой аюултай гэж үздэг. Эрсдэлийг хянах зохих арга хэмжээ аваагүй нөхцөлд эдгээр салбарын үйл ажиллагаа, үйлдвэрлэл нь өндрөөс унах, нүхэнд дарагдаж гацах зэрэг эрсдэлийг агуулж байдаг онцлогтой.

1 ОУХБ: *Safety and Health at Work* (веб хуудас), <https://www.ilo.org/global/topics/safety-and-health-at-work/lang--en/index.htm>


2 ОУХБ: “Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ ба менежмент” жижиг болон дунд байгууллагуудад зориулсан сургалтын багц (Женев, 2013).

Нэхмэлийн, бэлэн хувцас үйлдвэрлэлийн гэх зэрэг ерөнхийдөө аюул багатай гэж үздэг бусад салбарт ч (гал түймэр гарах, барилга нурах гэх мэт) үйлдвэрлэлийн осол гардаг. Нүүлгэн шилжүүлэх ослын гарц дутагдалтай, ажлын байрны эмх цэгц, цэвэрлэгээ тааруу газарт ийм ослын хор уршиг улам нэмэгдэнэ. Ажил мэргэжлээс шалтгаалсан эрсдэл салбар бүрд өөр байж болох ч ХАБЭМ-ийн нөхцөл байдлыг сайжруулах цогц арга хэмжээ боловсруулаад түүнийгээ тухайн аж ахуйн нэгжийн хэрэгцээнд нийцүүлэн өөрчилж болно. ХАБЭМ-ийн хүрээнд тасралтгүй ахиц дэвшил гаргахын тулд ажил олгогчид, менежерүүд, ажилтнууд болон тэдгээрийн төлөөлөгчид хамтран ажиллах шаардлагатай. Өөрөөр хэлбэл “ХАБЭМ бол хүн бүрийн асуудал” учраас үүнийг сайжруулах нь ёс зүй, бизнес, хууль эрх зүйн бүхий л талаасаа чухал юм. ХАБЭМ-ийг сайжруулах нь:

- ▶ Зөв: Бүхий л соёл иргэншил хүний эрүүл мэнд, сайн сайхан байдлыг үнэ цэнтэй гэж үздэг.
- ▶ Ухаалаг: ХАБЭМ-ийн хамгийн өндөр стандарттай, эрүүл, аюулгүй орчинд ажилладаг, урам зоригтой ажиллах хүч бүхий компаниуд хамгийн амжилттай, өрсөлдөх чадвартай байгааг судалгааны үр дүн харуулж байна. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ зардал багатай, үр ашиг сайтай болох нь харагдаж байна.
- ▶ Хууль ёсны: Ихэнх орны хууль тогтоомжоор ажил олгогчид ажилтнуудынхаа аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах үүрэг хүлээдэг. ХАБЭМ-ийн хууль тогтоомжийг сахин биелүүлснээр ажил олгогч болоод түүний төлөөлөгчид, түүнчлэн зарим тохиолдолд ажилтан ч эдийн засгийн болон бусад төрлийн хариуцлага (торгууль, хорих ял гэх мэт) хүлээхээс сэргийлнэ. Ажиллагчдын дийлэнх олонх нь ногдож байгаа (Зураг 1) албан бус хэвшил, ЖДААН-үүдэд ХАБЭМ-ийг сайжруулах нь нийгмийн, улмаар дэлхий нийтийн эрүүл мэндийг дээшлүүлэхэд нэн чухал нөлөөтэй юм.

▶ Зураг 1. Дэлхийн нийт ажиллагчид, аж ахуйн нэгжийн хэмжээгээр, хувиар

Дэлхийн нийт ажиллагчдын дийлэнх (70 орчим) хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгчид, бичил болон жижиг аж ахуйн нэгжид ажиллагчид эзэлж байгааг энэ зураг тодорхой харуулж байна.



Эх сурвалж: Small matters - Global evidence on contributions to employment by the self-employed, micro enterprises and SMEs, ОУХБ, 2019.

▶ 2. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНД: ТОДОРХОЙЛОЛТ БА ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

▶ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

“Хөдөлмөрийн” гэдэгт хөдөлмөрлөх үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг хамааруулж ойлгоно. “Аюулгүй байдал” гэдэг нь аливаа гэмтэл бэртэл, хохирлоос ангид байх нөхцөлийг илэрхийлнэ.

▶ ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын Дүрмийн оршил хэсэгт “эрүүл мэнд” гэдгийг “хүн өвчин, эмгэггүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байх” хэмээн тодорхойлжээ.

“Хөдөлмөрийн эрүүл мэнд” гэдэг нь ажил, хөдөлмөртэй холбоотой бэртэл гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэхтэй холбоотой анагаах ухааны салбар юм. ДЭМБ энэ салбарыг нийгмийн эрүүл мэнд болон эрүүл мэндийн систем хөгжүүлэлттэй нягт холбоотой гэж үздэг.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд (ХАБЭМ)” нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажиллагчдын аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр ажилладаг салбар юм. Хөдөлмөрийн нөхцөл, орчныг сайжруулахыг зорьдог уг салбарт төрөлжсөн олон чиглэл (хөдөлмөрийн анагаах ухаан, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, хор судлал, боловсрол, үйлдвэрлэлийн аюулгүй байдал, эргономик, сэтгэл зүй), мэргэжилтнүүд (хөдөлмөрийн эрүүл мэндийн эмч, сувилагч, үйлдвэрлэлийн эрүүл ахуйч, байцаагч гэх мэт) хамаардаг.

Аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг бүх ажлын байранд анхаарч авч үзэх ёстой.

АЮУЛ

“Аюул” гэж хүний эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй бүхий л зүйлийг хэлнэ. Аюулын салшгүй үндсэн шинж нь хохирол учруулах юм.

Ямар ч ажлын байранд аюул байж болох бөгөөд олон янзын хэлбэрээр илэрдэг. Тухайлбал:

- ▶ химийн бодис
- ▶ цахилгаан
- ▶ дуу чимээ

- ▶ халуун
- ▶ өндөрт ажиллах /Зураг 3/
- ▶ хамгаалалтгүй машин, тоног төхөөрөмж
- ▶ нян
- ▶ вирус
- ▶ стресстэй ажил
- ▶ хөдөлмөр зохион байгуулалт муу байх.

Аюул, түүний болзошгүй үр дагаврыг илүү сайн ойлгохын тулд аюулыг “аюулгүй байдлын” болон “эрүүл мэндийн” гэж ангилж болно.

Аюулгүй байдлын аюул (түүнээс үүдэх эрсдэл) нь эрүүл мэндийн аюулыг бодвол олж илрүүлэхэд илүү хялбар тул шийдвэрлэхэд ч харьцангуй хялбар байдаг. Даралтаар хэвлэгч машин шиг аюултай төхөөрөмж хаалт хамгаалалтгүй бол эрсдэл ихтэй, бэртэл гэмтэл авах нь илэрхий байдаг бол эрүүл мэндийн аюул, түүнээс үүдэх эрсдэл ихэвчлэн ингэж ил тод анзаарагддаггүй.

Ажил, мэргэжлээс шалтгаалсан эрүүл мэндийн асуудал нь анзаарагдахгүйгээр үүсэх бөгөөд зарим тохиолдолд олон жилийн дараа³ шинж тэмдэг нь илэрнэ. Эрт илрүүлэг, эмчилгээ нь асуудлыг хүндрүүлэхээс сэргийлэх, улмаар ажилтны амь насыг аврах хүртэл ач холбогдолтой. Бага хэмжээтэй ч гэсэн аливаа аюулд долоо хоног, сар, жилээр дахин давтан өртөхийн үр дагаврыг мөн зайлшгүй тооцож үзэх ёстой. Тухайлбал:

- ▶ Хортон шавж устгах зарим химийн бодис (тухайлбал, хортон шавж, мөөгөнцөр, хогийн ургамал устгагч бодис)-т өртөх нь хордлого (эрүүл мэндэд шууд буюу “цочмог” нөлөө үзүүлэх) үүсгэх төдийгүй урт хугацаандаа хорт хавдар үүсгэх аюултай. Энэ нь тухайн бодист бага хэмжээгээр дахин давтан өртөж байснаас үүддэг.
- ▶ Ургамал, амьтны тоосонцорт өртөх нь гуурсан хоолойн багтраа үүсгэх аюултай. Энэ нь мөн л удаан хугацааны өртөлтийн үр дагавар байх бөгөөд улмаар олон жил үргэлжлэх архаг хэлбэрийн гуурсан хоолойн өвчин, хурц бачуурал үүсгэж болзошгүй.
- ▶ Хүнд, хэцүү ачааг тогтмол буюу үе үе өргөж зөөснөөр хожим бие байнга өвддөг болох, эсвэл хөдөлмөрийн чадвараа алдахад хүргэж болзошгүй.

Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдах, архаг хууч өвчтэй болохыг эрүүл мэндийн “архаг” асуудал үүссэнд тооцох бөгөөд энэ тохиолдолд хүн бүрэн эдгэрэх боломжгүй буюу өмнөх төлөвтөө хэзээ ч буцаж орж чадахгүй.

3 Мезотелиома хорт хавдар (мэргэжлээс шалтгаалсан асбестийн хордлогын улмаас голчлон үүсдэг) үүсэх хүртэлх хугацаа хэдэн арван жил байж болдог. (“Malignant Mesothelioma Mortality — United States, 2015–1999”, in Morbidity and Mortality Weekly Report (MMWR), Vol. 3, (8)66 March 2017, pp. 218–214. <https://www.cdc.gov/mmwr/volumes/66/wr/mm6608a3.htm>)

► **Зураг 2. Ажил мэргэжилтэй холбоотой аюул**



Зүүн гар талд: Ажилтан химийн хортой бодисыг саванд юүлж байна.

Баруун дээд талд: Далд уурхайн оператор ажлын талбайн дуу чимээ, халуун, тоосноос хол алсын удирдлагаар ажиллуулдаг өрөмдлөгийн машиныхаа хажууд зогсож байна.

Баруун доод талд: ХДХВ/ДОХ-ын шинжилгээний лабораторид техникч ажиллаж байна.

Химийн бодис, дуу чимээ, халуун, тоос, вирус зэрэг нь бүгд ажил мэргэжилтэй холбоотой аюулын жишээ юм.

Хүн хорт болон аюултай бодист өртөх, өөрөөр хэлбэл тэдгээр нь хүний биед хүрэлцэж, нэвтэрдэг үндсэн зам:

- Амьсгалын замаар: Хий, асбестын ширхэг, модны тоос, хөгц зэрэг нь амьсгалын замаар биед нэвтэрдэг.
- Арьсаар: Уусгагч зэрэг зарим бодис арьсны гадаргаар шимэгдэж болно.
- Амаар: Санамсаргүй тохиолдлоор шошгогүй саванд хадгалсан химийн хортой бодисыг залгих гэх мэт.

► НИЙГЭМ-СЭТГЭЛ ЗҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЮУЛ

Шинэ технологи (жишээ нь, цахимжуулалт) нэвтэрч, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвар нэмэгдэн хүн ам зүйн болон уур амьсгалын өөрчлөлт эрчимжиж, хөдөлмөр эрхлэлтийн шинэ хэлбэрүүд (жишээ нь, зайнаас ажиллах) бий болж байгааг дагаад шинээр үүсэж буй болон цаашид үүсэж болзошгүй ХАБЭМ-ийн эрсдэл, тэдгээртэй холбоотой осол, өвчлөлийг урьдчилан тооцох нь юу юунаас чухал болж байна.

Нийгэм-сэтгэл зүйн эрсдэлд онцгой анхаарал хандуулж, аж ахуйн нэгжийн эрсдэлийн үнэлгээнд заавал багтаавал зохино. Учир нь ажлын шинэ хэв маяг, эдийн засгийн хямрал нь хүн хөдөлмөрлөх явцдаа стресст орох, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Ажлын стресс нь ажлын байрны шаардлага ажилтны чадвар, нөөц боломж, хэрэгцээтэй дүйхгүй, эсвэл мэдлэг, дасан зохицох чадвар нь тухайн байгууллагынхаа соёлд нийцэхгүй байх тохиолдлуудад үүсдэг. Зарим ажилтан (тухайлбал, олон нийттэй харилцаж ажилладаг хүмүүс) бусдаас илүү их стресст орох хандлагатай. Стресс нь өглөө таагүй мэдрэмжтэй сэрэхээс эхлээд зүрх судасны өвчин, сэтгэл гутрал, нойргүйдэл, цаашлаад амиа хорлох хүртэлх ноцтой эрүүл мэндийн асуудлаар илэрч болно. Ажилтнууд архи, мансууруулах бодис хэрэглэх, эрүүл бус хооллох, дасгал хөдөлгөөн хийхгүй байх зэрэг эрүүл бус зан үйлээр стрессийг даван туулах оролдлого гаргаж болдог.

“Хөдөлмөрийн хүрээний хүчирхийлэл, дарамт” гэж нь хүнд бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн болон эдийн засгийн хохирол учруулах зорилготой, хохирол учруулсан, эсвэл учруулж болзошгүй хүлээн зөвшөөрөх боломжгүй зан үйл, үйлдэл, заналхийллийг хэлэх бөгөөд үүнд жендэрт суурилсан хүчирхийлэл, дарамт багтана. Ийм сөрөг зан үйл, зүй бус үйлдэл нь хүний сэтгэл зүй, бие махбод, бэлгийн эрүүл мэнд, нэр хүнд, гэр бүлийн болон нийгмийн байдалд нь шууд нөлөөлдөг.

“Жендэрт суурилсан хүчирхийлэл, дарамт” гэж хүйс, жендэрээс үүдэлтэйгээр бусдын эсрэг үйлдсэн, эсвэл аль нэг хүйсийн хүмүүс харьцангуй их өртөж буй хүчирхийлэл, дарамтыг хэлнэ. Үүнд бэлгийн дарамтыг хамааруулна. Энэ төрлийн хүчирхийлэл, дарамтад эмэгтэйчүүд харьцангуй илүү өртдөг тул аж ахуйн нэгжүүд жендэрийн хэвшмэл үзэл⁴, ялгаварлан гадуурхалт, жендэрээс үүдсэн эрх мэдлийн тэгш бус харилцаа, хандлага болон бусад асуудлыг цогцоор нь авч үзэж, шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийг нь шийдвэрлэх замаар ажлын байран дахь хүчирхийлэл, дарамтыг устгах ёстой.

Эдгээр хүчин зүйл нь ажилтны эрүүл мэндээс гадна аж ахуйн нэгжийн олон зүйлд, тэр дундаа үйлчилгээний чанар, нэр хүнд, ажлын зохион байгуулалт, ажлын байран дахь харилцаа, бүтээмж зэрэгт нөлөөлдөг. Тиймээс тогтвортой хөгжилд тэмүүлж буй аж ахуйн нэгж эдгээр сөрөг хүчин зүйлсийг бүрмөсөн арилгах ёстой.

ОУХБ хүн бүр хүчирхийлэл, дарамтаас ангид нөхцөлд хөдөлмөрлөх эрхтэйг хүлээн зөвшөөрдөг. Хүчирхийлэл, дарамт нь хүний эрхийн зөрчил бөгөөд эрх тэгш боломж олгох зарчим хэрэгжихэд саад тотгор учруулдаг. Зохистой хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд эдгээрийг хүлээн зөвшөөрөх боломжгүй⁵. Аж ахуйн нэгж бүр холбогдох бүх тал (ажил олгогчид, менежерүүд, ажилтнууд төдийгүй гэрээт харилцагчид, үйлчлүүлэгчид)-ын хамтын ажиллагаагаар хүчирхийлэл, дарамтыг үл тэвчих орчин бүрдүүлж, эдгээр зохисгүй зан үйл, үйлдлээс урьдчилан сэргийлэх нь зүйтэй.

4 Эрэгтэй, эмэгтэй хүний шинж, гүйцэтгэх үүргийг зөвхөн хүйсийн шинжээр нь тодорхойлж, ойлгодог уламжлалт хандлага. Жишээ нь: “Эмэгтэй хүн нисгэгч болох ёсгүй”, “Эрэгтэй хүн гэрийн ажил хийдэггүй” гэх мэт.

5 ОУХБ: Хөдөлмөрийн хүрээний хүчирхийлэл, дарамтын тухай 2019 оны 190 дүгээр конвенцын 16 дугаар зүйлийг үзнэ үү.

► ЭРСДЭЛ

“Эрсдэл” бол аюулын улмаас хүн бэртэж гэмтэх, өвчлөх магадлал (их, бага) ба түүнээс учирч болох хохирлын ноцтой байдлыг харгалзан тооцдог үзүүлэлт юм.

Эрсдэл = хохирол учрах магадлал х хохирлын ноцтой байдал

Аюултай хүчин зүйлд өртөх нь ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндэд эрсдэл учруулдаг. Жишээлбэл, химийн хорт бодис болох пестицид аюултай боловч хэрэв энэ бодисыг бүрэн хаалттай системд үйлдвэрлэж байвал хэн ч түүнд өртөхгүй, үйлдвэрлэлийн явцад хүний эрүүл мэндэд эрсдэл учруулахгүй. Харин энэ бодисыг талбайд цацах үед хамгаалалтгүй байгаа ажилтнууд амьсгалах (амьсгалын замаар), арьсанд хүрэх (арьсаар шингэх), эсвэл санамсаргүй залгих (амаар) замаар өртөж болзошгүй.

► Зураг 3. Аюулд өртөх



2017 онд Мадагаскарын Антананариво хотод барилга дээр будагчид хамгаалалтын хашлага бүхий зориулалтын тавцан, бэхэлгээгүйгээр ажиллаж байгааг харуулсан байна. Ийм нөхцөлд тэд өндрөөс унах, улмаар хүнд гэмтэл авах, нас барах ч эрсдэлтэй.

Дээрээс унаж байгаа биет (жишээ нь шат, будгийн сав, багаж хэрэгсэл) тухайн орчинд хамт ажиллаж байгаа болон хажуугаар өнгөрч яваа гадны хүмүүсийг гэмтээж болзошгүй.

Өндөрт ажиллах үед цаг агаарын байдлыг анхаарч үзэх хэрэгтэй. Учир нь хэт халуун, чийгшил зэрэг нь ажлын нөхцөлийг илүү аюултай (жишээ нь нойтон, гөлгөр гадаргуу) болгодог.

► ЭРСДЭЛИЙН МАТРИЦ

Эрсдэлийн матриц нь эрсдэлийг тохиолдох магадлал (боломж) ба үр дагаврынх (аюулгүй байдал, эрүүл мэндэд учруулах хохирлын) нь ноцтой байдлыг харгалзан үнэлэхэд ашигладаг хүснэгт юм.

► ЭРСДЭЛИЙН МАТРИЦЫГ АШИГЛАХ ЗААВАР

Эрсдэлийн түвшинг тодорхойлохын тулд дараах хүснэгтээс түүний тохиолдох магадлал (босоо багана) ба үр дагаврын ноцтой байдал (хэвтээ мөр)-ыг сонгоно. Эрсдэлийн түвшин нь эдгээр хоёр хүчин зүйлийн огтлолцол юм: $\text{Эрсдэл} = \text{Магадлал} \times \text{Ноцтой байдал}$

Жишээлбэл, аж ахуйн нэгж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авалгүйгээр шатамхай материалыг хадгалж, ашиглаж байгаа бол гал гарах “магадлалтай”, үр дагавар нь “хохирол ихтэй” гэж тооцогдоно.

► ЭРСДЭЛИЙН МАТРИЦЫН ЗАГВАР

Тохиолдох магадлал	Учирч болох үр дагавар буюу хохирлын ноцтой байдал		
	Хохирол багатай	Хохирол дунд зэрэг	Хохирол ихтэй
Магадлал багатай	Бага эрсдэлтэй	Бага эрсдэлтэй	Дундаж эрсдэлтэй
Магадлалтай	Бага эрсдэлтэй	Дундаж эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй
Өндөр магадлалтай	Дундаж эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй

Эрсдэлийн матрицыг үлдэгдэл эрсдэлийг (хяналтын арга хэмжээ хэрэгжүүлсэн ч үлдсэн эрсдэл) үнэлэхэд бас ашиглаж болно.

Улаан бүсэд хамаарах эрсдэлийг нэн түрүүнд авч үзнэ. Тохиолдох магадлал хамгийн өндөр, аюулгүй байдал, эрүүл мэндэд маш ноцтой хохирол учруулж болзошгүй эдгээр эрсдэлийг хамгийн эхлээд шийдвэрлэх ёстой. Ноцтой байдал, тохиолдох магадлал, эрсдэл гэсэн гурван үзүүлэлтийн түвшин бүр ямар утга илэрхийлж байгааг авч үзэх нь зүйтэй.

Бүтцийн хувьд 3х3 матриц бөгөөд гурван хүчин зүйл тус бүрдээ гурван түвшинтэй.

Үйл явдал тохиолдох магадлалын хувьд:

- **1. Магадлал багатай:** одоо байгаа нөхцөлд хэн нэгэн гэмтэх магадлал маш бага.
- **2. Магадлалтай:** одоо байгаа нөхцөлд хэн нэгэн гэмтэх, өвчлөх магадлалтай.

- ▶ **3. Өндөр магадлалтай:** одоо байгаа нөхцөлд хэн нэгэн өвчлөх, гэмтэх нь тодорхой.

Хохирлын ноцтой байдлаар нь:

- ▶ **1. Хохирол багатай:** Үүнд анхны тусламж, бага зэргийн эмчилгээ үзүүлэх шаардлагатай гэмтэл, өвчлөлийг хамруулж ойлгоно. Энэ тохиолдолд тухайн хүн ажлаасаа чөлөөлөгдөх шаардлага гарвал нэг, хоёр өдрөөс хэтрэхгүй.
- ▶ **2. Хохирол дунд зэрэг:** Хөдөлмөрийн чадвараа түр хугацаанд алдахад хүргэхээр бүрэн эдгэх боломжтой арай хүнд гэмтэл, өвчлөл (Жишээ нь: гар хугарах, яс бага зэрэг цуурах). Энэхүү гэмтэл, өвчлөлийн улмаас тухайн хүн нэлээд удаан хугацаанд ажиллах боломжгүй болдог.
- ▶ **3. Хохирол ихтэй:** Амь насаа алдах, маш хүнд гэмтэх, өвчлөх. Гэмтэл, өвчлөл нь урт хугацааны, эсвэл насан туршид үргэлжлэх үр дагавартай (хиймэл эрхтэн хийлгэх, дуу шуугианаас болж сонсголоо алдах гэх мэт). Энэ түвшинд амьдралыг огцом өөрчлөх хэмжээний үйл явдлыг ойлгоно.

Золгүй үйл явдал тохиолдох магадлал болон түүнээс учирч болзошгүй хохирлын огтлолцол бүрээр эрсдэлийн гурван түвшинг матриц харуулдаг:

- ▶ **1. Бага эрсдэлтэй:** Бага зэрэг гэмтэх, хөнгөн хэлбэрээр өвчлөх эрсдэл.
- ▶ **2. Дундаж эрсдэлтэй:** Хүнд ноцтой гэмтэж, өвчлөх. Хохирлын зэрэг арай бага түвшинд ч тохиолдох магадлал нэмэгдэж байна.
- ▶ **3. Өндөр эрсдэлтэй:** Дунд зэргийн буюу ноцтой гэмтэл, өвчлөл, эсвэл амь насаа алдахад хүргэх магадлалтай буюу өндөр магадлалтай.

Ерөнхийдөө өндөр, дундаж эрсдэлийг хүлээн зөвшөөрч болохгүй бөгөөд мэдээлэл өгөх, сургалт явуулах болон засаж залруулах бусад арга хэмжээг аль болох богино хугацаанд авах шаардлагатай.

Бага эрсдэлтэй нөхцөлд авах арга хэмжээ нь яаралтай биш боловч илүү өндөр эрсдэлтэй нөхцөлийг хянах арга хэмжээтэй зэрэгцүүлээд аль болох хурдан эхлүүлж байсан ч болох юм.

Эрсдэлийн матрицыг олон янзын зорилгоор (тухайлбал, аж ахуйн нэгж, уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, аюулгүй байдлын судалгаанд) өргөн хэрэглэдэг ч учир дутагдалтай талыг нь анхаарах шаардлагатай. Эрсдэл тохиолдох магадлал, түүнээс учрах хохирлын ноцтой эсэхийг хүн бүр нэгэн адил ойлгодоггүйгээс яг нэг ижил эрсдэлийг үнэлээд харилцан адилгүй үр дүн гарч болзошгүй. Тиймээс хүчин зүйл (магадлал, ноцтой байдал, эрсдэлийн түвшин) бүрийг тодорхой тайлбарлах нь туйлын чухал юм.


Зөв ашиглавал эрсдэлийн матриц нь практикт хэрэглэхэд тохиромжтой, хялбар аргачлал юм. Энэ үйл явцын бусад алхмын адилаар эрсдэлийн үнэлгээг нэг, хоёр хүн биш багаар хийвэл маргаантай асуудлуудаа ярилцаж хэлэлцэн илүү тэнцвэртэй үр дүн гаргах боломжтой.

► АЮУЛ БА ЭРСДЭЛ

Аюул, эрсдэл хоёр нь өөр ойлголт. Ялгааг нь тодорхой гаргахгүй бол төөрөгдөл үүсгэж болзошгүй. Аюул нь тодорхой бодис, үйл явцтай холбоотой байдаг бол эрсдэл нь гэмтэл бэртэл учруулах магадлал, түүний болзошгүй үр дагаврын ноцтой байдлаас үүсдэг гэдгийг санах нь чухал. Эрсдэлийг хянах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс хамаараад түвшин нь харилцан адилгүй байна.

Жишээлбэл, хортон шавж устгагч нь хортой бодис учраас аюултай. Тиймээс ч түүнийг цацах нь фермер болон фермерийн аж ахуйд ажиллагчдын эрүүл мэндэд ноцтой эрсдэл учруулж болно. Харин хэрэглээг нь зохистойгоор хянахад эрсдэлийг хүлээн зөвшөөрөх боломжтой түвшинд хүргэн бууруулж болно. Өөрөөр хэлбэл, аюул нь ижил ч үүсэж буй эрсдэлийн түвшин өөр байж болно.

► Зураг 4. Нэг ажлын байранд буй ижил аюул (хамгаалалтгүй сэнс) байршлаасаа хамаараад эрсдэлийн түвшин нь өөр байна.



Зүүн гар талд: Ширээн дээрх хамгаалалтгүй сэнс эрсдэлтэй нь илэрхий харагдаж байна.

Баруун гар талд: Сэнсийг номын тавиур дээр байрлуулснаар эрсдэлийг бууруулж байна.

“Хүлээн зөвшөөрөгдөх эрсдэл” гэдэг нь хүний бие махбод, сэтгэл зүйд гэмтэл учруулах, өвчлүүлэх боломжтой хүчин зүйлийг хувь хүн, байгууллага, нийгмийн зүгээс тэсвэрлэх түвшинг хэлнэ. Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх нь нарийн төвөгтэй асуудал бөгөөд хүмүүс, нийгэм юуг хүлцэж болох вэ гэдэг дээр харилцан адилгүй ойлголттой байдаг. Ингэхдээ техникийн, ёс зүйн, улс төр, эдийн засгийн (хүний амь нас, эрүүл мэндийн үнэ цэн?), бүр нийгэм-сэтгэлзүйн асуудлуудыг ч харгалзан үздэг.

Эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх түвшинг тогтоохдоо үнэлгээ хийж буй газарт ажиллагчдын хүйс, нас, эрүүл мэндийн байдлыг харгалзан үзэж, тэдний санал бодлыг авах нь чухал.

► ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ

“Үйлдвэрлэлийн осол” гэж ажил, хөдөлмөрөөс үүдэлтэй, эсвэл ажил үүргээ гүйцэтгэх явцад тохиолдсон хүний амь нас хохирсон болон хохироогүй ослыг хэлнэ.

Ажлын байран дахь бусад хүсээгүй тохиолдлын нэгэн адил үйлдвэрлэлийн осол нь олон хүчин зүйлээс шалтгаалдаг бөгөөд зарим нь илүү тодорхой ажиглагддаг. Эдгээр хүчин зүйлс нийлснээр осол гарахад хүргэдэг учир шалтгааны гинжин хэлхээ бүрддэг.


► Зураг 5. Үйлдвэрлэлийн осол

Тавцант дугуй хөрөө:

Завсар гаргагч **3**

Ажлын бэлдцэд бараг тултал доошлуулж болох дээд хаалт **4** Энэ нь мод эргэж ойх, үсрэхээс болон гар хөрөөний ирэнд хүрэхээс сэргийлдэг.

5 - Хөрөө ашиглахдаа гараа зүсэхээс хамгаалж, хөрөөний ирнээс хол байлгах ёстой. Хэрэв хөрөөний ирэнд 30 см-ээс илүү дөхөх хэрэг гарвал 45 см-ээс багагүй урттай шувуун хошуутай түлхэгч иш ашиглана. **6** - Энэ нь таны гарыг эргэлдэж буй хөрөөний ирнээс хол байлгана.



Залуу ажилтан тавцант дугуй хөрөө ажиллуулж байх үедээ хөрөөний хаалтгүй ирэнд гар хүрч гэмтжээ.

Үйлдвэрлэлийн осол гарахад олон хүчин зүйлс нөлөөлдөг. Үүнд нас, ажлын туршлага, сургалт, ажлын байрны стресс, ядаргаа, бүтээмжийн хэмнэл, хамгаалалтгүй машин тоног төхөөрөмж, ажлын аюултай арга барил, хяналт, ХАБЭМ-ийн удирдлага зэрэг ордог.

Ажилдаа ирэх, буцах замд осолд орвол үйлдвэрлэлийн осол гэж тооцож болно.

Ажилдаа ирэх, буцах боломжтой байх нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг. Дарамт, халдлагад өртөх гэх зэрэг аюулгүй байдлын асуудлаас болоод эмэгтэйчүүд нийтийн тээврээр зорчихоос зайлсхийдэг байж магадгүйг судалгааны үр дүн харуулж байна. Шөнийн ээлжинд ажиллах нь эрэгтэй, эмэгтэй ялгаагүй бүх л ажилтанд эрсдэлтэй байж болох тул тэдний эрэлт хэрэгцээ, санаа бодлыг байгууллагын удирдлага зайлшгүй харгалзан үзэх ёстой. Хэрэв нийтийн тээвэр аюулгүй байдлыг хангаж чадахгүй нөхцөлд байгаа бол байгууллага өөрөө унаагаар хангах, эсвэл ажилтнууд ажилдаа ирэх, буцахдаа аюулгүй байдлын эрсдэлд орохоос сэргийлэх зохицуулалт хийх шаардлагатай.

► МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧИН

“Мэргэжлээс шалтгаалсан өвчин” гэдэг нь хөдөлмөрлөх үйл ажиллагаанаас үүдэлтэй эрсдэлт хүчин зүйлд өртсөний улмаас үүссэн аливаа өвчнийг хэлнэ. Жишээ нь: дуу чимээний улмаас сонсгол алдагдах, силикоз (цахиурын чөлөөт талст агуулсан тоосоор амьсгалснаас үүсдэг уушгины өвчин), гуурсан хоолойн багтраа (модны тоос, химийн бодист өртсөнөөс үүсдэг) болон яс, булчингийн өвчин (хүч шаардсан ажил байнга хийснээс үүсдэг).

Ажил, хөдөлмөр нь мэргэжлээс шалтгаалаагүй өвчний нөхцөл байдалд ч нөлөөлж болохыг энд тэмдэглэх нь чухал. Тухайлбал, цусны даралт ихсэлт ажлын стрессээс болоод хүндэрч болно.

► Зураг 6. Мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн ослоос үүдсэн нас баралт (дэлхийн хэмжээнд, нэг өдөрт)



Аюултай, эрүүл бус хөдөлмөрийн нөхцөлөөс үүдэлтэй нас баралтын дийлэнх нь мэргэжлээс шалтгаалсан өвчний үр дагавар юм. Аюулгүй, эрүүл ажлын байр бий болгож мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх боломжтой.

► АЮУЛТАЙ ТОХИОЛДОЛ

“Аюултай тохиолдол” гэж ажил, хөдөлмөр эрхэлж буй хүмүүс, олон нийтэд гэмтэл бэртэл, өвчин үүсгэж болзошгүй, хялбар илрүүлэх боломжтой, үндэсний хууль тогтоомжид тодорхойлсон үйл явдлыг хэлнэ.


► ОСОЛД ДӨХСӨН ТОХИОЛДОЛ

“Осолд дөхсөн тохиолдол” гэж бэртэл гэмтэл, эд хөрөнгийн хохирол учруулаагүй ч бэртэл гэмтэл учруулж болох байсан, үндэсний хууль тогтоомжид тодорхойлоогүй тохиолдлыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, энэ нь ажилтнууд болон олон нийтэд хохирол учруулж болох байсан тохиолдол (жишээлбэл, барилгын түр шатан дээрээс тоосго унахдаа хэнийг ч цохиогүй) юм.

Дараах зорилгоор осол, өвчин болон осолд дөхсөн тохиолдлыг судалж, дүн шинжилгээ хийх шаардлагатай. Үүнд:

- яагаад гарсан шалтгааныг тодорхойлох;
- цаашид дахин давтагдахаас сэргийлэхийн тулд хяналтын ямар арга хэмжээ шаардлагатайг тогтоох;
- цаашид гэмтэл бэртэл гарч, бүтээмж алдагдахаас сэргийлэх;
- нэхэмжлэл, нөхөн төлбөрт шаардагдах нотлох баримтыг цуглуулах, хадгалах.

► Зураг 7. Осолд дөхсөн тохиолдол



Хүний аминд хүрсэн, хүнд гэмтэл учруулсан ноцтой осол бүрийн цаана сургамж авч, цаашид давтагдахаас сэргийлж болох байсан осолд дөхсөн тохиолдол 400 гарчээ.

Осолд дөхсөн болон аюултай тохиолдлын талаар мэдээлэл цуглуулах нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой. Тиймээс эдгээр тохиолдлыг дараах асуултуудын дагуу мөшгөж судлах нь зүйтэй.

- ▶ Судалж буй тохиолдлын улмаас хэн гэмтэж, өвчилсөн буюу өртсөн бэ?
- ▶ Уг тохиолдол хаана болсон бэ?
- ▶ Уг тохиолдол хэзээ болсон бэ?
- ▶ Уг тохиолдол болоход яг юу юу болсон бэ?
- ▶ Уг тохиолдол хэрхэн болсон бэ?
- ▶ Уг тохиолдол яагаад болсон бэ?

Ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин төдийгүй аюултай болон осолд дөхсөн тохиолдлыг ч бүртгэх шаардлагатай. Эдгээр тохиолдлыг эрх бүхий байгууллагад мэдээлэхийг ихэнхдээ хуулиар шаарддаг. Ийнхүү мэдээлэхдээ тухайн хүн хэрхэн гэмтэж, өвчилсөн талаарх нэн чухал мэдээллийг тусгах нь зүйтэй.

Ингэснээр тухайн тохиолдол буюу нөхцөл байдлыг судалж учир шалтгааныг нь ойлгон, дахин давтагдахаас сэргийлэх арга хэмжээ авах боломж бүрдэнэ.

Ажил олгогч ажилтандаа ажлын байранд ажиглагдсан аливаа аюултай нөхцөл байдал, хэвийн бус зүйлийг дээд удирдлагадаа мэдээлэх үүрэгтэйг нь ойлгуулах ёстой.

Ажилтнууд болон тэдний төлөөлөгчид ийнхүү мэдэгдсэн аливаа тохиолдол, ямар нөхцөлд болсныг нь мэдэж байвал зохино.

Энэ нь тэдэнд хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахад хувь нэмэр оруулах боломж олгодог. Ийм мэдээлэл нь зөвхөн урьдчилан сэргийлэх ажилд бус, мөн статистик судалгаа, шинжилгээ хийхэд чухал ач холбогдолтой байдаг.

Аж ахуйн нэгжүүд аливаа тохиолдлыг мэдээлснийх нь төлөө хэн нэгнийг “буруутгахгүй байх соёл” төлөвшүүлэх нь чухал. Хэрэв аюул, эрсдэлийг мэдээлэхгүй бол осолд хүргэж болзошгүй. Ийм тохиолдлыг бүртгэх тусгай маягт ашигласнаар нөхцөл байдлыг засаж залруулах арга хэмжээ авахад илүү хялбар болно. Ажлын байранд болсон тохиолдлыг мэдээлэх маягтын загварыг энэхүү гарын авлагын Хавсралт I-д оруулав.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин болон бусад хүсээгүй үйл явдлаас урьдчилан сэргийлэх боломжтой гэдгийг санаж яваарай!

▶ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СОЁЛ

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэл ажилтан бүрд адилгүй байдгийг санах нь зүйтэй.

Залуучууд (15-24 насны), эмэгтэйчүүд, шилжин суурьшсан ажилтнууд, ялангуяа барилга, хөдөө аж ахуй зэрэг аюултай салбарт, эсвэл албан бус эдийн засаг гэх мэт тогтсон баталгаагүй нөхцөлд ажилладаг бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс

шалтгаалсан өвчинд онцгой өртөмхий байдаг. Бүх хүн аюулгүй, эрүүл байх нөхцөлийг хангахын тулд ажиллах хүчний харилцан адилгүй эрэлт хэрэгцээг анхаарч үзэх шаардлагатай.

► Зураг 8. Өртөмхий бүлгийн ажиллагчдын мэдээлэл

ХАМГИЙН ӨРТӨМХИЙ АЖИЛЛАГЧДЫГ АНХААРАХ

Бүхнийтийн аюулгүй байдал, эрүүл мэнд" хөтөлбөрийн хүрээнд ХАБЭМ-ийн нэн тулгамдсан хэрэгцээ бүхий дараах бүлгийн ажиллагчдад чиглэсэн арга хэмжээг боловсруулж байна:

- Барилга, хөдөө аж ахуй зэрэг аюултай салбарт ажиллагчид
- ЖДААН-ийн ажилтнууд
- Албан бус хөдөлмөр эрхлэгчид, шилжин суурьшсан ажилтнууд, эмэгтэй болон (15-24 насны) залуу ажилтнууд гэх зэрэг гэмтэл, өвчинд илүү их өртөмхий бүлгийнхэн

Барилга, хөдөө аж ахуйн салбар

Барилга, хөдөө аж ахуй нь дэлхийн хамгийн том бөгөөд аюултай салбарын тоонд ордог. Жил бүр 60,000 барилгын ажилтан, 170,000 хөдөө аж ахуйн ажилтан нас бардаг. Хөдөө аж ахуй, барилгын салбарт ажиллагчид цаг уурын өөрчлөлт, түүнээс үүдсэн хэт халалтын стресст хамгийн ихээр өртдөг ажээ.

2030 онд хэт халалтын стрессийн улмаас алдагдах ажлын цаг, ажил мэргэжлээр:



Залуу ажилтнууд

24-15 насны ажилтнууд хөдөлмөрлөх явцдаа хамгийн их бэртэж гэмтсэн байна.

40%

Европын Холбоонд энэ насны ажилтнуудын дундаж амь нас хохироогүй гэмтлийн тохиолдол ахмад ажилтнуудынхаас 40%-иар илүү байна.

Шилжин суурьшсан ажилтнууд

164

2013-2017 оны хооронд 164 сая хүн ажил хайж гадаадад шилжин суурьшжээ.

Ихэнх шилжин суурьшигч хөдөө аж ахуй, барилга, гэрийн үйлчилгээ зэрэг албан бус, зохицуулалтгүй салбарт "бохир, аюултай, дорд" гэж тооцогддог ажлыг хийж байна. Эдгээр салбарт хөдөлмөрлөх эрх болон бусад баталгаа бараг хэрэгждэггүй.

Эмэгтэйчүүд

26%

Эрэгтэйчүүдтэй харьцуулахад хөдөлмөр эрхлэлт нь 26%-иар бага.

Эмэгтэйчүүд ихэвчлэн хамгийн бага цалинтай, түр буюу улирлын чанартай ажилд ажилладаг. Тогтсон баталгаагүй ажил нь олон эмэгтэйг бэлгийн дарамт, хүчирхийлэлд өртөмхий болгодог.

Дэлхий даяар үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд болон бичил аж

ахуйн нэгжүүдийн ердөө 9% нь албан ёсны эдийн засагт байна.

Албан бус эдийн засагт ажиллагчид

>60%

Дэлхийн нийт ажиллагчдын 60 гаруй хувь нь албан бус эдийн засагт байна.

Тэд эдийн засгийн бүх л салбарын, тэр дундаа барилга, хөдөө аж ахуйн хамгийн аюултай ажлуудыг хийж, аюултай нөхцөлд ажилладаг.

Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй ажилтан

Олон улс орон жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдийг ажилтай холбоотой эрсдэлээс хамгаалах арга хэмжээг хуульчилсан байдаг. Тухайлбал, эдгээр эмэгтэйчүүдэд аюултай бодисуудыг тухайлан зааж, харьцаж ажиллахыг нь хориглодог. Мөн ажлын байранд эрсдэл өндөр байгаа тохиолдолд тухайн эмэгтэйг өөр ажилд шилжүүлэх, эсвэл жирэмсний амралтыг нь эрт олгох замаар эрсдэлийг бууруулахыг ажил олгогчоос шаарддаг.

Жирэмсэн болон хөхүүл ажилтныг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг хориглох ёстой.

Эхийн эрүүл мэндийг хамгаалах асуудал Тогтвортой хөгжлийн 3 дахь зорилт (Бүх насны хүмүүс эрүүл амьдрах нөхцөлийг хангаж, сайн сайхан байдлыг нь дэмжих)-д тусгагдсан байна.



► УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ ⁶

“Урьдчилан сэргийлэлт” гэдэг ямар нэг зүйлийг тохиолдохоос өмнө нь зогсоох тухай ойлголт юм.

ХАБЭМ-ийн асуудалд олон улс орон илүү ач холбогдол өгч, осол, өвчлөл гарсны дараа хариу арга хэмжээ авахын оронд урьдчилан сэргийлэхэд анхаарч эхэлж байна. Үүнээс хамгийн чухал нь засгийн газар, ажил олгогчид, ажилтнууд болон бусад оролцогч талууд үйлдвэрлэлийн осол, өвчлөлөөс үүдэлтэй ачаалал өмнө нь тооцоолж байснаас хавьгүй их гэдгийг хүлээн зөвшөөрсөн явдал байх. Цаашлаад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин нь аж ахуйн нэгжийн бүтээмж, өрсөлдөх чадвар, нэр хүнд, түүнчлэн хувь хүн, тэдний гэр бүлийн амьжиргаанд ихээхэн нөлөө үзүүлдэг болохыг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрдөг боллоо. Түүнчлэн үйлдвэрлэлийн осол, өвчлөл нь улс орны хувьд хүмүүнлэгийн болон эдийн засгийн тэсвэрлэхийн аргагүй дарамт учруулдаг. Энэ нь тухайн улсын бизнесийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж, тогтвортой эдийн засгийн өсөлтийг сааруулдаг. Товчхондоо урьдчилан сэргийлэх нь ашигтай.

ОУХБ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дэмжих тогтолцооны тухай 2006 оны 187 дугаар конвенцод⁷ аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үндэсний соёлыг “эрүүл, аюулгүй орчинд ажиллах эрх бүх түвшинд хэрэгждэг, засгийн газар, ажил олгогчид болон ажиллагчид эрх, үүрэг, хариуцлага нь тодорхой тогтоогдсон тогтолцоогоор дамжуулан эрүүл, аюулгүй ажлын орчинг бүрдүүлэхэд идэвхтэй оролцдог, урьдчилан сэргийлэх зарчмыг эн тэргүүнд тавьдаг байх” хэмээн тодорхойлжээ.

Дүгнэж хэлэхэд, ажлын байрандаа аюулд өртөх нь үйлдвэрлэлийн осол, өвчлөл, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан болж болно. ХАБЭМ гэдэг нь ажиллагчдын

⁶ Урьдчилан сэргийлэх нь зардлын хувьд үр ашигтайг хэд хэдэн судалгаагаар харуулсан байна. Тухайлбал, Lahiri S et al., “The Cost Effectiveness of Occupational Health Interventions: Prevention of Silicosis”, in *American Journal of Industrial Medicine*, Vol. 48(6), December 2005, pp. 503–514, урьдчилсан хэвлэлийг дараах холбоосоор үзнэ үү: https://www.who.int/quantifying_ehimpacts/global/8silicosis.pdf

⁷ ОУХБ: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дэмжих тогтолцооны тухай 2006 оны 187 дугаар конвенц, 1 дүгээр зүйлийн (d), https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:12100:0::NO::P12100_ILO_CODE:C187

аюулгүй байдал, эрүүл мэндийг болон эрүүл, аюулгүй ажиллах орчныг хамгаалан дэмжих замаар ажлын байрны эрсдэл, түүний дотор нийгэм-сэтгэл зүйн эрсдэлийг урьдчилан таамаглах, түүнээс сэргийлэх, хянах, бууруулах чиглэлээр ажилладаг мэргэжлийн салбар юм.

► 3. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

ЖДААН-ийн эзэд/менежерүүд болон ажилтнууд хамтран ажилласнаар ажлын байранд ХАБЭМ-ийг сайжруулах боломжтой. Ажил, хөдөлмөртэй холбоотой гэмтэл, өвчлөл хүний амьдралыг сүйрүүлж, бүтээмжид сөргөөр нөлөөлж болзошгүй. Түүнчлэн жижиг бизнесүүд үйлдвэрлэлийн осол, ажил хөдөлмөртэй холбоотой өвчлөлөөс үүдэх нөлөөнд илүү эмзэг байдаг.

Ажлын байранд эрүүл, аюулгүй байдлыг хангаж, бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд аж ахуйн нэгжүүд хэд хэдэн арга хэмжээ авч болно. Тухайлбал, ХАБЭМ-ийн бодлого гаргах, уг асуудлыг хариуцсан хороодыг байгуулж ажиллуулах, сургалтын хөтөлбөртэй болох, түүнчлэн аж ахуйн нэгжийн түвшинд эрсдэлийг удирдах гол түлхүүр болсон эрсдэлийн үнэлгээ хийх.

“Эрсдэлийн үнэлгээ” гэдэг нь ажил, хөдөлмөртэй холбоотой гэмтэл, өвчлөл үүсгэж болзошгүй хүчин зүйлсийг нарийвчлан шалгахыг хэлнэ. Энэ нь ажил олгогч эрсдэлийг хянах тохирох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн эсэх, эсвэл эрсдэлийг ажилтнууд, олон нийт хүлээн зөвшөөрөх түвшинд⁸ хүргэж бууруулахад нэмэлт арга хэмжээ шаардлагатай эсэхийг тодорхойлох боломжийг олгодог. Эцсийн зорилго нь хэн ч гэмтэж бэртэхгүй, өвдөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Эрсдэлийн үнэлгээний үр дүн нь ажил олгогчдод эрсдэлийг хянах ямар арга хэмжээг сонговол хамгийн тохиромжтой вэ гэдгийг шийдэхэд нь туслах ёстой. Ажилтнууд болон бусад (гадны) хүмүүс ажил олгогчийн үйл ажиллагаанаас үүдсэн аюулаас хамгаалагдах эрхтэй.

Хууль ажил олгогчоос эрсдэлийг бүрэн устгахыг шаардахгүй байж болох ч, ажлын байранд аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалахын тулд эрсдэлийг боломжийн хэмжээнд⁸ хүртэл бууруулахыг шаарддаг.

Эрсдэлийн үнэлгээ нь ажил олгогчид, бизнесүүд санаачилгатай байж, осол, өвчлөл гарахаас өмнө аюулыг олж илрүүлэн засаж залруулах арга хэмжээ авах боломж олгодог чухал хэрэгсэл юм. Өөрөөр хэлбэл, эрсдэлийн үнэлгээ нь ажлын байрыг илүү аюулгүй, эрүүл, бүтээмжтэй болгоход тусалдаг.

Ажил олгогч, ажилтнууд ажлын байраа сайн мэддэг тул эрсдэлийг үнэлэх ажиллагаа нарийн төвөгтэй байх албагүй бөгөөд эрсдэлийг хянах хэмнэлттэй, практик аргуудыг олоход нь туслах ач холбогдолтой. Өөр нэг давуу тал нь эрсдэлийн үнэлгээг ямар ч төрлийн эрсдэлд, түүний дотор нийгэм-сэтгэл зүйн эрсдэл (ажлын байрны стресс)-д ч хэрэглэж болдог.

Ихэнх орны хууль тогтоомжийн дагуу эрсдэлийн үнэлгээ хийх үүргийг ажил олгогчид

8 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 1981 оны 155 дугаар конвенцын 16 дугаар зүйлийг үзнэ үү.
https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=ORMLEXPUB:12100:0::NO::P12100_ILO_CODE:C155

хүлээлгэдэг (харин ажил олгогч энэхүү үүргийг гүйцэтгүүлэхээр зохих чадамж бүхий нэг буюу хэд хэдэн хүнийг томилж болно). Томилогдсон хүмүүс нь ажлын байр, ажил, үйлдвэрлэлийн явцын талаар мэдлэг сайтай, сайн туршлагыг хаанаас олж, хэрхэн ашиглах талаар мэддэг, мөн ажил олгогчоос зохих эрх мэдэл авсан байх ёстой. Тэд мөн аюулыг илрүүлэх, эрсдэлийн түвшинг тодорхойлох чадвартай, эрсдэлийг хянах шаардлагатай арга хэмжээг ойлгож, хэрэгжүүлэх мэдлэг, эрх мэдэлтэй байх ёстой.

Аж ахуйн нэгжид энэ чиглэлийн мэргэжилтэн байхгүй бол гадны мэргэжилтнээр хийлгэж болно. Энэ тохиолдолд ажил олгогч тухайн мэргэжилтэн тодорхой ажил, үйлдвэрлэлийн талаар мэдлэгтэй, үнэлгээ хийх чадвартай эсэхийг шалгах нь зүйтэй.

ЖДААН-д эрсдэлийн үнэлгээг заавал ХАБЭМ-ийн мэргэжилтэн хийх шаардлагагүй. Гэхдээ сонгосон хүн нь дараах мэдлэг, чадварыг эзэмшсэн байх ёстой. Үүнд:

- ▶ Эрсдэлийн үнэлгээний ерөнхий арга барилыг ойлгосон байх;
- ▶ Түүнийгээ тухайн ажлын байр, үүрэг даалгаварт ашиглаж чаддаг байх. Үүний тулд:
 - ▶ аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлуудыг тодорхойлох;
 - ▶ арга хэмжээ авах хэрэгцээг үнэлж, эрэмбэлэх;
 - ▶ эрсдэлийг арилгах буюу бууруулах хувилбаруудыг санал болгож, тэдгээрийн давуу талыг тайлбарлаж, үр нөлөөг нь үнэлэх;
 - ▶ аюулгүй байдал, эрүүл мэндийг сайжруулах хүрээнд гарсан ахиц, сайн туршлагыг сурталчлан таниулах;
- ▶ Эрсдэлийг зохих ёсоор үнэлэх боломжгүй нөхцөл байдлыг тодорхойлж, туслалцаа дэмжлэг хүсэх чадвартай байх.

Ажилтнууд өөрт тохиолдсон, ажигласан зүйлээ хуваалцдаг тул тэдэнтэй хамтран ажиллах нь амин чухал. Ажилтнуудыг анхан шатны сургалтад хамруулж, холбогдох ойлголт, үнэлгээ хийх үе шатыг танилцуулах хэрэгтэй.

Ажлын байрны үзлэг шалгалтыг нөхцөл байдлын тухайн агшинг буулгасан “гэрэл зураг”-тай зүйрлэж болох бол эрсдэлийн үнэлгээ нь тасралтгүй (үргэлжилсэн) үйл явц бөгөөд дараах түвшинд хийж болно:

- ▶ Аж ахуйн нэгжийн түвшинд (бүх үйл ажиллагаа, үйл явц, нийт ажилтныг хамруулна);
- ▶ Ажлын байрны тодорхой хэсэгт (жишээ нь, машин засварын цех);
- ▶ Аюултай үйл ажиллагаа, үйл явц (жишээ нь, хүнд ачаа өргөж зөөхөд тулгардаг асуудлууд).

► 3.1 ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ 5 АЛХАМ

Эрсдэлийн үнэлгээг доорх таван алхмын дагуу хийвэл үр дүнтэй:

Алхам 1: Аюулыг илрүүлж, шалтгааныг тогтоох

Алхам 2: Хэн, хэрхэн хохирч болохыг тодорхойлох

Алхам 3 : Эрсдэлийг үнэлэх: Эрсдэлийг хянах арга хэмжээг тодорхойлж, сонгох

Алхам 4: Хяналтын арга хэмжээг хэн, хэзээ хэрэгжүүлэхийг бичиж тэмдэглэх

Алхам 5: Эрсдэлийн үнэлгээнд хяналт-шинжилгээ хийх, хянаж нягтлах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх

Эрсдэлийн үнэлгээний тайлангийн маягтыг хавсралт II-т оруулав.

АЛХАМ 1: АЮУЛЫГ ИЛРҮҮЛЖ, ШАЛТГААНЫГ ТОГТООХ

Эрсдэлийн үнэлгээ нь ажлын байрны (зөвхөн ажил, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас төдийгүй барилга байгууламжийн зохион байгуулалт зэрэг бусад хүчин зүйлсээс үүдэлтэй) аюулыг олж илрүүлэхээс эхэлдэг. Энэ үе шатанд хүнд хохирол учруулж болох бүх зүйлийг илрүүлэхийг зорино. Илрүүлээгүй аюулыг хянах боломжгүй учраас энэ ажиллагааг аль болох өргөн хүрээнд явуулах нь чухал.

Өдөр бүр нэг л газраа ажилладаг хүмүүсийн хувьд аюулыг анзаарахгүй байх боломжтой. Ийм аюулыг илрүүлэхэд дараах зөвлөмж тус болно. Ажил олгогч, түүний томилсон ажилтан, эсвэл үнэлгээ хийх гадны мэргэжилтэн нь дараах зүйлсийг гүйцэтгэх ёстой:

- ▶ Ажлын байрны эргэн тойронд явж, хохирол учруулж болзошгүй зүйл байгаа эсэхийг анхааралтай ажиглах;
- ▶ Ямар үйл ажиллагаа, үйл явц хамгийн аюултай байгааг болон тэдгээрийн байршлыг тодорхойлох. Бэлэн хянах хуудас ашиглавал үр дүнтэй байж болох юм. Ямар ч тохиолдолд эрсдэлийн үнэлгээний тайлан бэлтгэхэд ашиглах зорилгоор тэмдэглэл хөтлөх нь чухал;
- ▶ Ажилтнууд, тэдний төлөөлөгчдөөс ажил үүргээ гүйцэтгэх явцад тулгардаг аюулынх нь талаар, мөн ажлын байрны осол, өвчлөлөөс хэрхэн сэргийлж болох талаар асуух. Эрсдэлийн үнэлгээ хийж байгаа хүнд шууд анзаарагдахааргүй зүйлсийг тэд мэдэж байж болох юм;
- ▶ Тэр бүр ил анзаарагдаад байдаггүй аюулыг илрүүлэхэд тустай байдаг тул өмнө гарч байсан осол болон ажлаас үүдсэн өвчлөлийн түүхийг судлах;
- ▶ Аюулгүй байдал, эрүүл мэндэд шууд нөлөөлөх болон эрүүл мэндэд урт хугацаанд (тухайлбал, чанга дуу чимээ, хортой бодист өртөх) хохирол учруулж болох аюулын аль алиныг хамруулах шаардлагатайг санах;
- ▶ Мэргэжлийн холбоод хэрэгтэй зөвлөгөө өгөх боломжтой учраас тэдний харьяалагддаг холбоодтой холбоо барих;
- ▶ Үйлдвэрлэгчийн заавар, техникийн үзүүлэлт бүхий мэдээллийн хуудсыг шалгах нь химийн бодис, тоног төхөөрөмжтэй холбоотой аюулыг тодорхойлох, зөв ойлгож, үнэлэхэд тусалдаг;
- ▶ Илрүүлээгүй үлдсэн ямар нэгэн аюул, эрсдэлд өртөж болзошгүй хэн нэг ажилтан үлдсэн эсэхийг хамт ажиллагчдаасаа асуух.

ХАБЭМ-ийн хяналтын хуудас нь аюулыг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, хянах үйл явцыг зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэхэд ашиглагддаг бас нэгэн чухал хэрэгсэл юм. Энэ нь (ТИЙМ, ҮГҮЙ гэсэн хариулт бүхий) хаалттай асуултуудын жагсаалт бөгөөд эрсдэлийн үнэлгээ, ажлын байрны үзлэг шалгалт хийх бүрд бөглөнө. Хяналтын хуудсыг тодорхой асуудлаар (тухайлбал, машин механизмын аюулгүй байдал, өндөрт ажиллах, хаягдал устгах гэх мэт) боловсруулсан хяналтын хуудсыг бөглөсний дараа тухайн ажлын байрны, эсвэл түүний тодорхой хэсгийн “дүр зураг” харагдах бөгөөд цаашид засаж залруулах арга хэмжээг төлөвлөхөд хэрэглэнэ.

Хяналтын хуудасны загвар	Тийм	Үгүй
Ажлын байр ерөнхийдөө цэвэр, эмх цэгцтэй байна уу?		
Шороо, хог, хаягдлыг тогтмол цэвэрлэж, зайлуулдаг уу?		
Шалыг тогтмол шүүрдэж, угаадаг уу?		
Таазыг цэвэр байлгадаг уу?		
Ажлын ширээ, тавцанг шаардлагагүй зүйлсээр дүүргэлгүй цэвэр байлгадаг уу?		
(1) Аюулгүй ажиллагааны дадал, ажлын байрны эмх цэгцийг дэмжсэн (2) Ажлын орчинд буй аюулыг хүмүүст сэрэмжлүүлсэн тэмдэг тэмдэглэгээ хангалттай байрлуулсан байна уу?		
Бүх материал, нөөц, барааг аюулгүй байдлыг хангаж, зөв хураасан уу?		
Агуулах, хадгалалтын бүсийг зохих ёсоор хаяглаж тэмдэглэсэн үү?		
Бүх хонгил, шат, гарцыг бараа материал, хог хаягдал, хуучин эд зүйлсээс цэвэрлэж чөлөөлсөн байна уу?		
Бараа материал, хогийг тусад нь ялгаж хураах сав байна уу?		
Шалны гадаргуу тэгш, хальтиргаагүй (жишээ нь, ус, тос, бусад төрлийн шингэн асгараагүй), ашиглалтын нөхцөл сайн байна уу?		
Бараа материал зөөх, ажиллагчид явах зориулалтын налуу зам хангалттай байна уу?		
Гарц, хонгилын өргөн шаардлага хангасан байна уу? Будсан шугамаар тодорхой тэмдэглэсэн үү?		
Хүн зорчих, ачаа зөөх хөдөлгөөнд саад учруулах зүйлсийг гарц, хонгилын замаас цэвэрлэсэн байна уу?		
Явган хүний замыг тээврийн хэрэгслийн замаас тусгаарлаж, тодорхой тэмдэглэсэн байна уу (жишээ нь, агуулахад)?		
Гал түймрийн үеийн нүүлгэн шилжүүлэх журмыг шууд харагдахуйцаар байрлуулсан байна уу? Нүүлгэн шилжүүлэлтийн дадлага сургууль хийгдсэн байна уу?		
Галын аюулын үед ашиглах тоног төхөөрөмж, гарц зэргийг тогтмол хугацаанд шалгаж, засвар үйлчилгээ хийдэг үү?		

Хяналтын хуудас нь аж ахуйн нэгжийн ХАБЭМ-ийн амин чухал асуудлуудад анхаарал хандуулах энгийн арга юм.

Эрсдэлийн үнэлгээ хийж буй хүн шалгах хүрээгээ эхэлж тогтоох ёстой. Үүнд аж ахуйн нэгжийг бүхэлд нь, эсвэл тодорхой хэсгийг нь хамруулж болно.

Хяналтын хуудсыг бөглөхөөс өмнө ажлын байрны эргэн тойронд явж, анхааралтай ажиглах шаардлагатай.

Хяналтын хуудаст тусгагдсан шалгах зүйл (доорх жишээг үзнэ үү) бүрийг уншиж, ажилтнуудтай ярилцсаны дараа “Та арга хэмжээ авахыг санал болгох уу?” гэсэн нүдийг хэрхэн бөглөхөө шийднэ.

Арга хэмжээ авах шаардлагатай бол «ТИЙМ», одоо хэрэгжиж буй арга хэмжээ хангалттай байгаа бол «ҮГҮЙ» гэсэн нүдийг бөглөнө.

“Тайлбар” хэсэгт саналаа, эсвэл байршлыг нь бичнэ. Дараа нь сайжруулалт хийснээр хамгийн их үр дүн гарах зүйлсийг сонгон “НЭН ТҮРҮҮНД” гэж тэмдэглэнэ.

Үүний дараа нэн даруй сайжруулах шаардлагатай зүйлсийг тохирохын тулд жижиг бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулах нь зүйтэй.

Хяналтын хуудаст тусгагдсан шалгах зүйлсийн жишээ:

Ажлын талбар ба багаж хэрэгсэл

Байнга хэрэглэгддэг багаж, унраалга, материалыг хялбархан хүрэх газар байрлуулах. Та арга хэмжээ авахыг санал болгож байна уу?

☐ Үгүй ☐ Тийм ☐ Нэн түрүүнд

Тайлбар _____



Хяналтын хуудас нь олон давуу талтай. Аюулгүй байдал, эрүүл мэндийн томоохон асуудлуудад анхаарлыг хандуулж, шалгасан зүйл бүрийг илэрсэн асуудлуудын хамт бичгээр баримтжуулдаг, мөн аюулын талаарх тайлан, хэлэлцүүлгийн үндэс болж болохоос гадна ажлын байр бүрд тохируулан (шаардлагатай тохиолдолд шалгах зүйлүүдээ нэмж тусган) ашиглаж болдог.

Түүнчлэн хяналтын хуудас ашигласнаар сайн туршлагыг системтэй нэвтрүүлэхэд түлхэц болж, хамтач сэтгэлгээг бэхжүүлдэг. Гэхдээ хяналтын хуудаст дутагдалтай тал бас бий. Байж болох бүх асуудлыг хамруулах боломжгүй учраас хяналтын хуудаст ороогүй зүйлс орхигдож болзошгүй.

Ашигласан аргачлалаас үл хамааран ажлын байрны аюулыг илрүүлэх ажиллагаа юу хохирол учруулж болох вэ гэдгээс эхлэх ёстой. Дараах хүснэгтийн эхний баганад мод боловсруулах үйлдвэрт ажиглагддаг гурван аюулыг жишээ болгон оруулав:

Алхам 1	Алхам 2	Алхам 3		Алхам 4		
Ямар аюул байна вэ?	Хэн, хэрхэн хохирч болох вэ?	Одоо ямар арга хэмжээ авч байгаа вэ?	Цаашид ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?	Хариуцаж хэрэгжүүлэх хүн	Хэрэгжүүлсэн байх хугацаа	Хэрэгжүүлсэн хугацаа
Модны тоосонд өртөх						
Машин механизм						
Гар ажиллагаа						
Алхам 5. Эрсдэлийн үнэлгээнд хяналт-шинжилгээ хийх, хянаж нягтлах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх						

Холбогдох бүх үйл ажиллагаа (тухайлбал, үйлдвэрлэл, төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээ, гэнэтийн эвдрэл гэмтлийн засвар гэх мэт), газрыг хамруулна.

Ажилтнууд энэ үйл явцад идэвхтэй оролцож, ажлынхаа аюултай талууд, бэртэж гэмтэх магадлалын талаар болон өмнө нь осолд орох дөхсөн тохиолдол гарч байсан эсэхийг өөрсдөө, эсвэл төлөөлөгчдөөрөө дамжуулан тайлбарлах хэрэгтэй. Ажлын байрны талаарх тэдний мэдлэг чухал хэрэг болно. Учир нь бусад хүмүүс болзошгүй аюулыг үл тоох буюу анзаарахгүй байж магадгүй.

Аюулыг илрүүлэхэд туслах хэрэгслүүд:

- Өмнө нь хийгдсэн ажлын байрны хяналт шалгалт, судалгаа
- Аюул/ ослын тухай бичгээр үйлдсэн болон аман тайлан
- Хувийн ажиглалт
- ХАБЭМ-ийн хороо
- Анхааруулах шошго, тэмдэг тэмдэглэгээ
- Үйлдвэрлэгчээс гаргасан аюулгүй байдлын мэдээлэл, заавар

ХИМИЙН БОДИСЫН АНГИЛАЛ, ХАЯГЖУУЛАЛТЫН НЭГДСЭН СИСТЕМ

Химийн бодисын ангилал, хаягжуулалтын нэгдсэн систем (англиар GHS, цаашид “нэгдсэн систем” гэх) нь Нэгдсэн Үндэстний Байгууллагаас химийн бодис үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах ажиллагаанд оролцдог хүмүүсийг мэдээллээр хангах, хамгаалах зорилгоор боловсруулан гаргасан олон улсын нэгдсэн (нэг) систем юм. Үүнд байгаль орчны эрсдэл мөн ордог.

Нэгдсэн системийг нэвтрүүлсэн орнууд химийн бодисыг ангилахдаа “нэг хэлээр ярьж байгаа” гэж хэлж болно. Учир нь химийн бодисын шошго болон аюулгүй байдлын мэдээллийн хуудас (АБМХ)-т тусгагдаж буй шинж чанар, шаардлага нь яг ижил байх юм. Нэгдсэн системийн шошго болон АБМХ-т тусгагдсан аюулын талаарх мэдээлэл нь тээврийн болон бусад ажилтнууд, онцгой байдлын болон яаралтай тусламжийн ажилтнууд, хэрэглэгчдэд тун хэрэгцээтэй. Нэгдсэн системийн АБМХ-т дараах мэдээллийг⁹ уг дарааллынх нь дагуу заавал тусгах ёстой:

1. Тодорхойлолт;
2. Хор аюулын тодорхойлолт;
3. Найрлага, бүрдэл хэсгийн талаарх мэдээлэл;
4. Анхны тусламжийн арга хэмжээ;
5. Гал унтраах арга хэмжээ;
6. Химийн бодис алдагдах үед авах арга хэмжээ;
7. Харьцах, хадгалах;
8. Өртөлтийг хянах/хувийн хамгаалалт;
9. Физик, химийн шинж чанар ба аюулгүй байдлын үзүүлэлтүүд;
10. Тогтвортой байдал ба урвалын идэвх;
11. Хоруу чанарын мэдээлэл;
12. Экологийн мэдээлэл;
13. Устгах арга хэмжээ;
14. Тээвэрлэлтийн мэдээлэл;
15. Хууль эрх зүйн мэдээлэл;
16. Бусад мэдээлэл

9 Нэгдсэн системд заасны дагуу 2-пропанолын АБМХ-ны загвар:

<https://www.fishersci.ca/shop/msdsproxy?productName=A426P4&productDescription=2-propanol-histological-fisher-chemical 5#page=1&zoom=auto,-99,798>

Нэгдсэн системийн шошгод заавал тусгах ёстой 6 төрлийн мэдээллийг доор оруулав:

► **Зураг 9. Химийн бодисын ангилал, хаягжуулалтын нэгдсэн системийн ангилалд нийцсэн шошгоны 6 элемент**

1 — **2-Пропанол**

2 — **АЮУЛТАЙ**

3 —

- Маш шатамхай шингэн ба уур
- Арьсыг бага зэрэг цочрооно
- Нүдийг хүчтэй цочрооно
- Толгой эргэх, нойрмоглох шинж тэмдэг үүсгэнэ

4 —

Халалт, оч үүсгэх, ил гал, халуун гадаргуугаас хол байлга. Тамхи татахыг хориглоно. Тоос, уур, хий, манан, мананцар, аэрозолиор амьсгалахаас зайлсхий. Нүдэнд орсон тохиолдолд усаар болгоомжтой зайл. Линзтэй бол авах боломжтой бол авч хаян, үргэлжлүүлэн усаар зайлна. Арьсанд хүрсэн бол хортой нөлөө үзүүлж болзошгүй. Арьсыг цочрооно. Нүдийг цочрооно. Залгихад хортой нөлөө үзүүлнэ.

5 — Acme Chemical-101 Main Street, Anywhere, USA




6 —

1 Бүтээгдэхүүний нэр/ найрлагын мэдээлэл

2 Дохио үг

3 Аюулын тэмдэглэгээ

4 Урьдчилан авах арга хэмжээний мэдээлэл

5 Үйлдвэрлэгчийн мэдээлэл

6 Анхааруулах тэмдэг

Бүтээгдэхүүний нэр: бодисын химийн нэршил ба тээвэрлэлтийн тодорхой нэр

Дохио үг: аюулын ноцтой байдлын түвшинг заана. «Аюултай» (илүү ноцтой аюул), «Анхаар» (харьцангуй бага) гэх мэт.

Аюулын тэмдэглэгээ аюулын шинж чанар, (шаардлагатай тохиолдолд) аюулын зэрэглэлийг илэрхийлсэн хэллэг (ба код). Жишээ нь «Арьс цочрооно» гэх мэт.

Урьдчилан авах арга хэмжээний мэдээлэл: аюултай бүтээгдэхүүний нөлөөлөлд өртөх, буруу хадгалах болон түүнтэй буруу харьцсанаас үүсэж болох сөрөг үр дагаврыг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээг заасан хэллэг, график дүрслэл. Сэрэмжлүүлэх тэмдэглэгээ нь ерөнхий, урьдчилан сэргийлэх (жишээ нь «ил гал, бусад шаталтын эх үүсвэр лүү шүршиж болохгүй»), (асгарч алдагдсан үед) хариу арга хэмжээ авах, хадгалах, устгах гэсэн 5 төрөлтэй байдаг.

Үйлдвэрлэгчийн мэдээлэл: үйлдвэрлэгч, эсвэл нийлүүлэгчийн холбоо барих дэлгэрэнгүй мэдээлэл (нэр, хаяг ба утасны дугаар)

Анхааруулах тэмдэг: тодорхой мэдээллийг дамжуулах зорилготой тэмдэг, хэлбэр дүрс, хүрээ, дэвсгэр ба өнгө зэргийг багтаасан график дүрслэл

► **Зураг 10. Нэгдсэн системийн анхааруулах тэмдэг (пиктограм)**



ТЭСРЭМТГИЙ



ШАТАМХАЙ



ИСЭЛДҮҮЛЭГЧ



ШАТСАН ХИЙ



ХОРТОЙ/ЦОЧРООГЧ



БАЙГАЛЬ ОРЧИНД
ХОРТОЙ



ЭРҮҮЛ МЭНДЭД
ХОРТОЙ



ИДЭМХИЙ



ХОРТОЙ

Ажлын байранд ашиглаж буй бүтээгдэхүүн, бодисын аюулгүй байдал, эрүүл мэндэд учруулах хор нөлөө, аюул, тэдгээрээс үүдэх эрсдэлийн тухай мэдээллийг шошго болон АБМХ-аас авах ёстой.

“Шошго” нь тухайн бодисын нэр, түүнтэй аюулгүй харьцах, ашиглахтай холбоотой үндсэн мэдээллийг агуулдаг. Шошгыг бодисын сав баглаан дээр байрлуулна. Шошго нь ажилтанд өртөж болох аюулынх нь талаар шууд анхааруулдаг. Ажлын байранд ашиглаж буй химийн аюултай бүх бодис шошготой саванд байх ёстой.

Ажил олгогчид, ажилтнууд ажлын байранд ашиглаж байгаа химийн бодисын аюул, түүнээс хамгаалах арга хэмжээний талаар мэдлэгтэй байх ёстой. Хадгалалтын үеийн аюулыг сав, баглаа боодол багасгадаг боловч бодис асгарч алдагдах буюу өөр осол гарвал ажилтнууд, онцгой байдлын болон яаралтай тусламжийн ажилтнууд ямар арга хэмжээ тохирохыг мэддэг байх шаардлагатай.

Олон орон мэргэжил, үйлдвэрлэлийн хэрэгцээнд химийн бодис хэрэглэгчдэд зориулж бодисын шинж чанар, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хор аюул, түүнчлэн бодисын шинж чанараас болон түүнийг ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах үед үүсэх аюулын талаарх мэдээлэл, ажиллагчдыг хамгаалах (тухайлбал, гал унтраах болон бодис санамсаргүй алдагдах үед авах бусад арга хэмжээ, шаардлагатай тохиолдолд анхны тусламжийн арга хэмжээ) зааварчилгаа зэргийг багтаасан АБМХ өгөхийг үйлдвэрлэгчид, ханган нийлүүлэгчдээс шаарддаг.

Товчхондоо АБМХ-т химийн бодисын аюул, түүнтэй хэрхэн аюулгүй харьцах, ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах талаар тайлбарласан байдаг. АБМХ-ыг шошго, аюулгүй ажиллагааны товхимол, сургалт, сурталчилгааны бусад материалтай хамт ашиглаж болно.

Ажилтнууд, тэдний төлөөлөгчид АБМХ болон түүнтэй төстэй мэдээллийг өөрсдийн мэддэг хэлээр, ойлгоход хялбар хэлбэрээр хүлээн авах эрхтэй.

АЮУЛЫГ ДҮРСЛЭЛЭЭР ИЛЭРХИЙЛЭХ

Ажлын байрны аюулыг илрүүлж тодорхойлоход туслах хялбар арга бол ажлын байрны зохион байгуулалтын бүдүүвч зургийг зурж, аюулыг аюулыг тэмдэглэх (аюулын зураглал) юм.


Ажлын байрны бүдүүвч зургийг зурж, хаалга, цонх, шат, хонгил зэрэг үндсэн хэсгүүдийг зөв тэмдэглэнэ. Дараа нь болзошгүй аюул, эрсдэлийг байршлаар нь нэг бүрчлэн тэмдэглэнэ. Ингэхдээ аж ахуйн нэгжийг бүхэлд нь, эсвэл тодорхой газар, хэсгийг сонгон хамруулж болно. Аюулыг ихэвчлэн өнгөөр будсан дугуй буюу бусад дүрсээр тэмдэглэдэг. Харин эрсдэлийг өнгө ялган тэмдэглэж болно.

Аюулыг байршлаар нь тодорхойлсноор арилгахад илүү хялбар болно. Ажилтнууд ажлын байраа сайн мэддэг, туршлагатай учраас аливаа аюулыг энэхүү энгийн, зардал багатай аргаар нарийн тодорхойлж, байршлыг нь тогтооход тус дөхөм болно. Тиймээс тэдэнтэй хамтран ажиллах нь чухал.

Ийм зураглал нь аж ахуйн нэгжийн ХАБЭМ-ийн ерөнхий төлвийг харуулж, эрсдэлийг хянах тохирох арга хэмжээг тодорхойлоход хялбар болгодог. Аюулын зураглалыг байнга бэлэн байлгаж, ажлын байранд томоохон өөрчлөлт (тухайлбал, одоо ашиглаж байгаа машинуудад шинэ хамгаалалт суурилуулах) хийгдсэн тохиолдолд шинэчилж байх хэрэгтэй.

Доор өгөгдсөн жишээнд бүх бүртгэгдсэн хальтирч, бүдэрсэн тохиолдлыг тэмдэглэж, шалтгааныг (тухайлбал, шалан дээрх ус, мөс гэх мэт) нь дурдсан байна. Үүн дээр мөн гол үүрэг хүлээсэн ажилтнуудын (тухайлбал, анхны тусламжийн ажилтан, гал унтраах багийн гишүүд гэх мэт) ердийн байршлыг нэмж оруулж болно.

► Зураг 11



Эх сурвалж: Их Британийн ХАБЭМ-ийн алба, *Slips and trips mapping tool: An aid for safety representatives* <https://www.hse.gov.uk/slips/mappingtool.pdf>

10 Их Британийн ХАБЭМ-ийн алба, *Slips and trips mapping tool: An aid for safety representatives* <https://www.hse.gov.uk/slips/mappingtool.pdf>

БУСАД ЭХ СУРВАЛЖ

Ажлын байрны аюулын талаарх мэдээллийг ханган нийлүүлэгчид, мэргэжлийн холбоод, ХАБЭМ-ийн чиглэлээр ажилладаг байгууллагууд, шинжлэх ухааны сэтгүүл, хоруу чанар ба эрүүл мэндэд үзүүлэх нөлөөний талаарх мэдээллийн сан, мэдээллийн олон улсын эх сурвалжуудаас авах боломжтой.

Өмнө гарч байсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл нь бас нэг чухал эх сурвалж болно. Олон оронд аж ахуйн нэгжид гарсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний статистикийн мэдээллийг ажилтнууд, тэдний төлөөлөгчидтэй хуваалцах үүрэгтэй байдаг.

Дээр дурдсанчлан эрүүл мэндэд нөлөөлөх аюул нь аюулгүй байдлынхтай харьцуулахад далд хэлбэртэй байдаг. Тиймээс ийм төрлийн аюулыг (тухайлбал, дуу чимээ их, хэвлэлийн үйлдвэрт хортой уусгагчид өртөх, хөдөө аж ахуйд пестицидэд өртөх гэх мэт) зөв тодорхойлохын тулд илүү чамбай хандах хэрэгтэй. Нийгэм-сэтгэл зүйн аюулыг (тухайлбал, ажил дээрх харилцааны доголдол, ажлын стресс) ч мөн илрүүлж, үнэлэх нь зүйтэй.

АЛХАМ 2: ХЭН, ХЭРХЭН ХОХИРЧ БОЛОХЫГ ТОДОРХОЙЛОХ

Аюулыг олж илрүүлсний дараа үнэлгээ хийж байгаа хүн эрсдэлтэй хүмүүсийг тодорхойлж, эдгээр аюултай хүчин зүйлс ажилтнууд болон бусад хүмүүст хэзээ, хаана, хэрхэн хохирол учруулж болохыг тогтоох ёстой.

Алхам 1-д тодорхойлсон аюул бүрээр хэнд, хэрхэн хохирол учруулж болохыг тодорхойлж, бичих хэрэгтэй. Аюул бүрд харилцан адилгүй хяналтын арга хэмжээ шаардагдаж болох тул энэхүү ажиллагаа чухал юм. Энэ явцад аюулд өртөж болзошгүй хувь хүнийг бус, харин ажилтны (засварын цехийн болон цэвэрлэгээний ажилтнууд гэх мэт) болон бусад хүмүүсийн (ачааны машины жолооч нар, үйлчлүүлэгчид, зочид гэх мэт) бүлгүүдийг тэдэнд тохиолдож болох өвчин, гэмтлийн (жишээ нь, бараа өрөгчид байнга хайрцаг өргөсний улмаас нурууны гэмтэл авах) хамт тодорхойлно.

Үүсэж болзошгүй аюултай нөхцөл байдал бүрийг үнэлэх нь чухал. Жишээлбэл, баригдаж буй барилгын хажуугаар өнгөрч яваа гадны хүмүүс дээрээс унасан биетэд цохиулах эрсдэлтэй. Харин тэд барилгын талбайд зөвшөөрөлгүй орвол (ухсан нүхэнд унах, өлгөөтэй ачаанд цохиулах, тээврийн хэрэгсэлд дайруулах гэх мэт) өөр эрсдэлтэй тулгарч болзошгүй. Тодорхойлсон бүлэг бүрээр учирч болзошгүй хохирлыг (ямар гэмтэл, өвчлөл үүсэж болохыг) тодорхойлох шаардлагатай. Хэрэв эрсдэлд өртөж байгаа хүмүүсийн тоо мэдэгдэж байгаа бол зааж өгөх хэрэгтэй (доорх хүснэгтийг үзнэ үү).

Энэ жишээ хүснэгтэд модны тоосонд өртөх аюулын эрсдэлийг үнэлэх Алхам 2-ыг харуулав.¹¹

¹¹ Дээр дурдсан эрсдэлийн үнэлгээний жишээний Алхам 1-д модны тоосонд өртөх, машин механизм болон гар ажиллагаа гурван аюулыг тодорхойлсон гэдгийг сануулъя. Эдгээр аюул тус бүрийн эрсдэлийн үнэлгээг загварын дагуу хийж, бусад алхмуудыг гүйцээх ёстой.

Алхам 1	Алхам 2	Алхам 3		Алхам 4		
Ямар аюул байна вэ?	Хэн, хэрхэн хохирч болох вэ?	Одоо ямар арга хэмжээ авч байгаа вэ?	Цаашид ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?	Хариуцан хэрэгжүүлэх хүн	Хэрэгжүүлсэн байх хугацаа	Хэрэгжүүлсэн хугацаа
Модны тоосонд өртөх	Бүх ажилтан (35 хүн) модны тоосоор амьсгалснаас гуурсан хоолойн багтраа зэрэг амьсгалын замын өвчнөөр өвчлөх эрсдэлтэй. Машины операторууд (15 хүн) өртөх эрсдэл илүү өндөр. Хатуу модны тоосонд өртөх нь хорт хавдар, ялангуяа хамрын хөндийн (хамар орчмын) хорт хавдар үүсгэдэг.					
Алхам 5. Эрсдэлийн үнэлгээний үр дүнг бичиж тэмдэглэх, хяналт-шинжилгээ хийх, хянаж нягтлах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх						

Дээр дурдсанчлан зарим ажилтан аюулгүй байдал, эрүүл мэндийн хувьд илүү эмзэг байдаг. Ялангуяа шинэ, залуу ажилтнууд, жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрсдэлд харьцангуй өртөмхий. Үүнээс гадна химийн аюултай бодист өртөх нь бүх ажилтанд эрсдэлтэй боловч эрэгтэй, эмэгтэй хүнд өөр өөрөөр нөлөөлж болзошгүй. Энэ нь дан ганц биологийн/нөхөн үржихүйн шалтгаантай бус, гэрт болон бусад орчинд химийн бодист өртөх хэв маяг (жишээ нь, толбо арилгахад уусгагч хэрэглэх, гоо сайхны бүтээгдэхүүн байнга хэрэглэх), эмэгтэйчүүд эдийн засгийн тодорхой салбарт (хөдөө аж ахуй, үйлчилгээ, албан бус хөдөлмөр) төвлөрсөн байдагтай холбоотой байж болно. Жирэмсэн болон хөхүүл ажилтнуудыг хар тугалга, мөнгөн ус зэрэг хорт бодисын аюулаас хамгаалж, эх, хүүхдийн эрүүл мэндийг сахин хамгаалахад онцгой анхаарах шаардлагатай.

АЛХАМ 3: ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ: ЭРСДЭЛИЙГ ХЯНАХ АРГА ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛЖ, СОНГОХ


Алхам 1, 2-т аюулыг илрүүлж, эрсдэлд өртөж болзошгүй хүмүүсийг тодорхойлсон билээ. Тэгвэл Алхам 3-т одоо хэрэгжиж байгаа хяналтын арга хэмжээнд тулгуурлаад эрсдэлийн түвшинг матриц ашиглан үнэлнэ. Хэрэв эрсдэлийн түвшин дунд буюу өндөр гарвал хүлээн зөвшөөрөх боломжгүй учраас хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хүртэл бууруулахын тулд нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай болно.

Магадлал	Хохирлын ноцтой байдал		
	Хохирол багатай	Хохирол дунд зэрэг	Хохирол ихтэй
Магадлал багатай	Бага эрсдэлтэй	Бага эрсдэлтэй	Дундаж эрсдэлтэй
Магадлалтай	Бага эрсдэлтэй	Дундаж эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй
Өндөр магадлалтай	Дундаж эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй

Олон орны хууль тогтоомжоор ажил олгогчоос ажилтнууд болон бусад хүмүүсийг хохирлоос хамгаалах боломжтой бүх арга хэмжээг авахыг шаарддаг. Энэ үүргээ биелүүлэхийн тулд тухайн аж ахуйн нэгжид хэрэгжүүлж буй арга хэмжээг сайн туршлагатай харьцуулан үнэлэх нь үр дүнтэй.

Эрсдэлийн түвшинг бууруулах үр дүнтэй, логик арга нь «эрсдэлийг хянах арга хэмжээний шатлал» юм. Ажил олгогч, ажилтны аль алинд нь удирдамж болдог уг шатлалын зарчмыг доор дүрслэн харуулав. Гурвалжны дээд хэсэгт байрлах арга хэмжээнүүд нь доод хэсгийнхээс илүү үр дүнтэй тул боломжтой тохиолдолд тэргүүн ээлжинд хэрэгжүүлэхийг зөвлөдөг.

► Зураг 12. Эрсдэлийг хянах арга хэмжээний шатлал



Эрсдэлийг хянахад доорх дарааллыг мөрдөнө:

- 1: аюулыг бүрэн арилгах;
- 2: аюулыг орлуулах;
- 3: инженерчлэл, технологи, тоног төхөөрөмж, багаж хэрэглэл;
- 4: аюулгүй ажиллах арга барил, дадал, зохион байгуулалт, мэдээлэл сургалт, эрүүл ахуй, ахуй хангамж;
- 5: Хувийн хамгаалах хэрэгсэл (XXX).

Эрсдэлийг хянах арга хэмжээг дээрх шатлалд заасан дарааллаар сонгож, хэрэгжүүлэх шалтгаан нь зөвхөн өмсөж, хэрэглэж буй хүнийг л хамгаалдаг хувь хүнд чиглэсэн аргаас түрүүнд нийт ажлын орчин болон бүх ажилтныг хамарсан *хамтын* арга хэмжээг чухалчилдагтай холбоотой.¹²

Эрсдэлийг хянах шатлал уруудах тусам арга хэмжээний үр нөлөө, тогтвортой байдал буурч, оролцоо, хяналт, сургалт, тандалтын хэрэгцээ нэмэгддэг.

Ажлын байруудад өргөнөөр хэрэглэгддэг ХХХ нь хамгийн үр нөлөө багатай (гурвалжны хамгийн доод хэсэгт улаанаар тэмдэглэсэн) учраас аюул, эрсдэлийн эсрэг сүүлчийн хамгаалалт болох ёстой.

Доорх хүснэгтэд эрсдэлийг хянах шатлалын дагуу одоо хэрэгжүүлж байгаа болон санал болгож буй арга хэмжээг тусган Алхам 3-ыг гүйцээсэн эрсдэлийн үнэлгээний маягтыг харуулав.

Алхам 1	Алхам 2	Алхам 3		Алхам 4		
Ямар аюул байна вэ?	Хэн, хэрхэн хохирч болох вэ?	Одоо ямар арга хэмжээ авч байгаа вэ?	Цаашид ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?	Хариуцан хэрэгжүүлэх хүн	Хэрэгжүүлсэн байх хугацаа	Хэрэгжүүлсэн хугацаа
Модны тоосонд өртөх	Бүх ажилтан (35 хүн) модны тоосоор амьсгалснаас гуурсан хоолойн багтраа зэрэг амьсгалын замын өвчнөөр өвчлөх эрсдэлтэй. Машины операторууд (15 хүн) өртөх эрсдэл илүү өндөр. Хатуу модны тоосонд өртөх нь хорт хавдар, ялангуяа хамрын хөндийн (хамар орчмын) хорт хавдар үүсгэдэг.	-Тоосыг тогтмол соруулдаг - Угаалгын өрөө, шүршүүр сайтай -Нэг удаагийн тоосны маск өгч, тогтмол сольдог.	-Тоос үүсгэгч машин бүрд тоос сорогч төхөөрөмж (хэсэгчилсэн агааржуулалтын систем) суурилуулна. • Ажилтнуудад модны хуурай үртсийг шүүрдэхгүй, тоос сорогчоор цэвэрлэхийг сануулна. • Машины операторуудыг тоос сорогч төхөөрөмжийг зөв ашиглаж, анхан шатны засвар үйлчилгээ хийхэд сургана.			

Алхам 5. Эрсдэлийн үнэлгээний үр дүнг бичиж тэмдэглэх, хяналт-шинжилгээ хийх, нягтлаж шалгах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх

12 Аюулыг бүрэн арилгах, эсвэл орлуулах зарчмыг баримтлаад хэрэгжүүлсэн арга хэмжээ нь тухайн нөхцөлд тохирохгүй, эсвэл хангалтгүй байх тохиолдолд л ажлын байрыг хамгаалах эцсийн арга болгон хувь хүнд чиглэсэн хамгаалалтад шилжих хэрэгтэй. Энэ зарчим нь практикт хэрэглэгддэг эрсдэлийн хяналтын бүхий л шатлалд нийтлэг байдаг.

Бид одоо эрсдэлийг хянах арга хэмжээний шатлал бүртэй нарийвчлан танилцаж, аж ахуйн нэгжийн түвшинд хэрэгжүүлэх практик жишээгээр баяжуулан авч үзэх болно.

ЭРСДЭЛИЙГ ХЯНАХ АРГА ХЭМЖЭЭ

Аюулыг арилгах, эсвэл орлуулах

Аюулыг арилгах нь эрсдэлийг хянах хамгийн үр нөлөөтэй арга гэдэг нь хэнд ч ойлгомжтой. Аюулыг арилгах, ийм боломжгүй тохиолдолд орлуулах нь аюулд өртөх эрсдэлийг бууруулж, улмаар ноцтой хохирол учрахаас бүрэн сэргийлэх буюу хохирлыг аль болох багасгах боломж бүрдүүлдэг. Жишээ нь:

- ▶ Хортой пестицид хэрэглэхгүй хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх;
- ▶ Хор багатай пестицид сонгох, шүршихийн оронд үрэл хэлбэрийн пестицид хэрэглэх;
- ▶ Эрсдэл багатай бодис, эсвэл ажиллагааг сонгох. Жишээ нь: уусгагч биш усан суурьтай будаг хэрэглэх;
- ▶ Машин, тоног төхөөрөмжийг илүү аюулгүй хувилбараар солих. Жишээ нь: цахилгаан багажны оронд хийн (пневматик) багаж ашиглах;
- ▶ Асбестийг илүү аюулгүй орлуулагчаар (олон хувилбар байдаг) солих;
- ▶ Чанга дуутай машиныг чимээ багатайгаар солих;
- ▶ Өндөр барилгын цонхыг дотроос нь цэвэрлэх боломжтойгоор өөрчлөх, гаднаас цэвэрлэх шаардлагагүй болгох.

Хэрэв эхний шатлалын тодорхойлсон арга хэмжээгээр аюулыг устгаж чадвал тухайн аюулын хувьд эрсдэлийн үнэлгээ үүгээр дуусна. Эрсдэл тэг буюу тэг рүү ихээхэн дөхсөн гэсэн үг. Иймд тухайн аюултай холбоотой нэмэлт арга хэмжээг тодорхойлох, сонгох, хэрэгжүүлэх шаардлагагүй болно.

Гэхдээ эрсдэлийн үнэлгээний явцад аюулыг бүрэн арилгах боломжгүй гэж тогтоогдсон бол шатлалын дараагийн түвшний арга хэмжээг (орлуулах/инженерийн арга хэмжээ) авч үзэх хэрэгтэй гэсэн үг юм.

Инженерийн хяналт

Эдгээр арга хэмжээ нь аюулын төрлөөс хамааран олон янз байх бөгөөд зөвхөн хувь хүнийг бус ажлын бүсэд байгаа бүх хүнийг нийтэд нь хамгаалдаг давуу талтай.

Эрүүл мэндэд хортой бодисын нөлөөллийг хянахын тулд жижиг оврын гагнуурын утаа сорогчоос эхлээд тоос, утаа шүүгч, хамгаалалтын бээлийтэй хайрцаг, будаг шүршигч кабин, үйлдвэрлэлийн зориулалттай том оврын байгууламж хүртэл инженерийн шийдэлтэй олон төрлийн арга хэрэглэж болно.

Энэ бүх арга хэмжээнд дараах нийтлэг шаардлага тавигддаг:


- ▶ Аюулд өртөхөөс сэргийлэх, өртөх боломжийг хязгаарлах;
- ▶ Аюулыг ажилтнуудаас найдвартай холдуулах;
- ▶ ртөлтийг зөвшөөрөгдсөн хэмжээнээс доогуур байлгах.

Энэ төрлийн хяналтын арга хэмжээний зарим жишээ:

- ▶ Машин, тоног төхөөрөмийн хамгаалалт (хэрэв үйлдвэрлэгчийн тавьсан хамгаалалт хангалтгүй, эсвэл хуучин стандартаар хийгдсэн бол хамгаалалтыг сайжруулах хэрэгтэй);
- ▶ Эрсдэлийг бүрэн устгаж чадахгүй байсан ч бууруулах зорилгоор дуу чимээ ихтэй машинд дуу тусгаарлагч бүрхүүл суурилуулах;
- ▶ Рентген тоног төхөөрөмж, цехийн уусгагчтай цавуу ашигладаг хэсэг зэрэг аюултай үйл ажиллагааг бүрэн тусгаарлах/битүүмжлэлтэй болгох;
- ▶ Өндөрт байрлах ажлын тавцанг тойруулаад хашлага суурилуулах;
- ▶ Хүнд ачааг зөөхөд ядаж л түрдэг буюу гар тэрэг ашиглах;
- ▶ Ажлын тавцан, ширээг ажилтны биеийн өндөрт тохируулж байрлуулах, тохиромжтой суудлаар хангах;
- ▶ Хүн хэт тонгойхгүйгээр ажиллахад тохирсон урттай хүрз, шүүр зэрэг багаж хэрэгслийг ашиглах.

Эдгээр арга хэмжээний заримыг аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн үйл явцыг төлөвлөх шатанд нэвтрүүлбэл илүү хялбар байдаг. Эдгээр нь санхүүгийн хувьд өртөг өндөртэй байж болох ч ХАБЭМ-д хийсэн хөрөнгө оруулалт гэж үзэх нь зүйтэй.

► Зураг 13. Инженерийн хяналтын арга хэмжээ



Эдгээр нь зүүн гар талд байгаа тавцант дугуй хөрөөнд суурилуулсан хамгаалалтын хаалт шиг энгийн, хямд төсөр зүйлээс эхлээд баруун гар талд байгаа агаарт цацагдсан будгийг усан хөшгөөр шингээдэг үнэтэй будаг шүршигч кабин хүртэл олон янз байна.

“Машин, тоног төхөөрөмжийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны бусад онцлог” сэдэвт видеонд инженерийн хяналтын янз бүрийн аргуудыг үзүүлсэн байна.¹³

Удирдлага, зохион байгуулалтын хяналт

Аюулд өртөх эрсдэлийг бууруулах зорилгоор удирдлага, зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээг хэрэгжүүлж болно.

Аюулгүй ажиллах арга барил, дадал зуршил нь ажлын байрны эрсдэлийг хянах энгийн, зардал багатай арга зам юм. Ажил олгогч аюулгүй ажиллах арга барил, дадал зуршил, зохион байгуулалтын асуудлыг сайтар төлөвлөж хэрэгжүүлээгүй, мөн менежер, ахлагч, ажилтан ялгалгүй аюулгүй байдал, эрүүл мэндийн зохих горимыг сайн мэдэхгүй, сургалтад хамрагдаагүйгээс үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний олон тохиолдол үүдсэн байдаг. Ажил олгогч, менежер, ахлагч нар ажилтнуудтайгаа хамтран ажлаа аюулгүй зохион байгуулах үүрэгтэй. *Эрсдэлийг хянах ийм төрлийн арга хэмжээ нь ихэвчлэн энгийн, хэрэгжүүлэхэд хялбар байхаас гадна бизнесийн үр ашгийг дээшлүүлдэг.*

Жишээ нь:

► Зохион байгуулалтын арга хэмжээ

Хөдөлмөр зохион байгуулалтын дараах арга хэмжээ байж болно:

- Амрах завсарлагын хугацааг уртасгах;
- Туслах ажилтан нэмж ажиллуулах;

¹³ ОУХБ: Машин механизм, үйлдвэрлэлийн бараг хэрэгсэл (веб хуудас), <https://www.ilo.org/global/topics/labour-administration-inspection/resources-library/publications/guide-for-labour-inspectors/machinery-plant-equipment/lang-en/index.htm>

- ▶ Хөдөлгөөнийг дэмжих зорилгоор дасгал хийх завсарлага гаргах;
- ▶ Ажилтнуудыг өөр өөр ажлын байранд сэлгэж ажиллуулах;
- ▶ Ажлын хуваарьт өөрчлөлт оруулах, нэг ажилтны ажиллах хугацааг бууруулах, эсвэл бусад журам нэвтрүүлэх замаар аюултай үйл ажиллагаанд өртөлтийг хязгаарлах;
- ▶ Үр дүнтэй сургалтын хөтөлбөрүүд хэрэгжүүлэх.

▶ Аюулгүй ажиллагааны журам, дүрэм

Ажил гүйцэтгэх журам, дүрэм, заавар нь үндэсний хууль тогтоомжид заасан шаардлагыг хангахын зэрэгцээ хамгийн энгийн ажил үүргээс бусад тохиолдолд бичгээр боловсруулагдсан байх ёстой. Энэ нь үйлдвэр, тоног төхөөрөмжийн арчилгаа, үйлчилгээ, туршилт, шалгалт, засвар, мөн химийн бодисыг шилжүүлэх (түүний дотор ачих, буулгах үйл ажиллагаа), сав, баглаа боодолд агуулагдаж буй бодис, тэдгээрийн аюул, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зэргийг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Эрсдэлийн үнэлгээгээр илрүүлсэн аюулаас ажилтнуудыг хамгаалах үүднээс ажлын байрны бүх төрлийн аюулд (тухайлбал, машин механизм, тээврийн хэрэгсэл ажиллуулах, өндөрт ажиллахтай холбоотой) хамаарах журам, дүрэм, зааврыг боловсруулж, мөрдүүлэх ёстой. Эрсдэлийг арилгах, бууруулахад чиглэсэн тохирох арга хэмжээг (тухайлбал, тохирох химийн бодис, технологи ашиглах, инженерийн хяналтын тохирох арга хэмжээг хэрэгжүүлэх) сонгосны дараа ийм журам, дүрэм, зааврыг боловсруулж, сонгосон арга хэмжээг хамгийн үр дүнтэй хэрэгжүүлэхээр тусгавал зохино.

Тухайн ажлыг хэн хариуцах, ямар тодорхой үүрэг даалгавар гүйцэтгэхийг (түүнчлэн давхардал үүсэж болзошгүй үед оролцогч бүрийн үүрэг хариуцлагыг) тодорхой заахын зэрэгцээ ээлж солигдох үед шаардлагатай мэдээллийг солилцох зохицуулалтыг тусгасан байна.

Аюулын эрсдэл маш өндөр байгаа тохиолдолд (тухайлбал, хязгаарлагдмал орчинд тоног төхөөрөмжийн засвар хийх үед) «ажил гүйцэтгэх зөвшөөрөл»-ийн тогтолцоо¹⁴ гэж нэрлэдэг бичгээр гаргасан албан ёсны журам шаардлагатай.¹⁴ *Ажил гүйцэтгэх зөвшөөрлийн маягтад* ямар ажлыг хэн, хэзээ, хэрхэн хийж гүйцэтгэхийг нарийвчлан заасан байх ёстой. Хариуцсан хүн нь ажлын үе шат бүрд болон ажил дууссаны дараа ажлын гүйцэтгэлийг үнэлж, аюулгүй байдлыг шалгах ёстой. Харин ажилтнууд тухайн ажилтай холбоотой аюул, шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг ойлгосон гэдгээ баталгаажуулж, зөвшөөрлийн хуудаст гарын үсэг зурна.

Ганцаараа ажиллаж буй хүний хувьд ажлын горим, ялангуяа онцгой байдлын үед мөрдөх зохицуулалтад онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Шаардлагатай тохиолдолд тусгай зохицуулалт хийж, онцгой байдлын үед химийн процессыг яаралтай зогсоох журам боловсруулсан байх ёстой.

¹⁴ Ийм журам ихэвчлэн засвар үйлчилгээний ажилд шаардагддаг. Заримдаа «Цоожлох, пайзлах журам», эсвэл «Цоожлох, пайзлах, туршиж шалгах журам» гэж нэрлэдэг. “Цоожлох, пайзлах” гэдэг нь үйлдвэрлэл, судалгаа шинжилгээнд ашиглагддаг аюултай машин механизмыг зөв унтрааж, арчлалт үйлчилгээ, засварын ажил дуустал асаахаас сэргийлэх зорилгоор мөрддөг аюулгүй ажиллагааны журам юм.

Мэдээлэл, сургалтын үйл ажиллагааг хянаж үнэлэхийн зэрэгцээ ажил гүйцэтгэх журам, дүрэм, зааврыг тогтмол хянан үзэж байх шаардлагатай. Эрсдэлийг хянах арга хэмжээнүүдийг дахин үнэлэхдээ эдгээрийг хамтатган хийж, зохих арга арга хэмжээг авбал зохино. Үнэлгээнд дараах зүйлсийг хамруулна:

- ▶ Ажиллагчид, материал, тоног төхөөрөмж, байршил, үйл ажиллагааны журам, горимд гарсан өөрчлөлт;
- ▶ Ердийн ажлын цагаас гадуур ажиллахад мөрдөх журам, дүрэм, заавар;
- ▶ Удирдлага, хяналт хангалттай эсэх;
- ▶ Систем, үйл ажиллагаа зориулалтын дагуу хэрэгжиж байгаа эсэх;
- ▶ Дуусгах боломжгүй ажлыг орхих үеийн зохицуулалт.

Эрсдэлийг хянах зохион байгуулалтын шинжтэй бусад арга хэмжээний хүрээнд ажил олгогч нь ажилтныг тамхи татахыг хориглох, согтууруулах, мансууруулах бодис хэрэглэсэн үед ажиллуулахгүй байх арга хэмжээ авна.

Осол, гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал хангах, хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг боловсруулж, тогтмол шинэчилж байх шаардлагатай. Ийм төлөвлөгөөнд осол, онцгой байдал үүсэх магадлалыг тодорхойлж, холбогдох ХАБЭМ-ийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгасан байх ёстой. Ингэхдээ аж ахуйн нэгжийн хэмжээ, үйл ажиллагааны онцлогт нийцсэн зохицуулалт хийж, дараах зүйлсийг тусгана:

- ▶ Ажлын талбайд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд хүн бүрийг хамгаалахад хэрэгтэй бүх мэдээлэл, дотоод харилцаа холбоо, зохицуулалт;
- ▶ Эрх бүхий байгууллага, орон нутгийн яаралтай тусламжийн болон онцгой байдлыналбадад мэдэгдэх, харилцах зохицуулалт;
- ▶ Анхны тусламж, эмнэлгийн тусламж, гал унтраах ажиллагаа, ажлын талбайгаас бүх хүнийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ;
- ▶ Бүх түвшний ажилтнуудад зориулсан мэдээлэл, сургалт, түүний дотор онцгой нөхцөлд урьдчилан сэргийлэх, бэлэн байдал хангах, хариу арга хэмжээ авах дадлага сургуулилтыг тогтмол зохион байгуулах асуудал.

Жишээ нь далд уурхайд ажиллагчид онцгой байдлын үед ашиглах аврах гарцыг ашиглах биеийн чадамжтай, шаардлагатай сургалтад хамрагдсан байх ёстой. Аврах хонгилын төмөр шат усанд норсноос хальтирах, гэрэлтүүлэг муутай байх зэргийн улмаас хүндрэл үүсэж болзошгүй бөгөөд ийнхүү зугтахад маш их ядардаг. Бие бялдрын хувьд ийм аврах системийг ашиглах чадваргүй уурхайчдад газар доор ажиллахыг зөвшөөрөх ёсгүй.

Осол, гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах зохицуулалтыг онцгой байдлын мэргэжлийн байгууллага, шаардлагатай тохиолдолд бусад байгууллагатай хамтран боловсруулах хэрэгтэй.

Бүх ажилтан болон гадны хүмүүс тухайн бүсээс хэрхэн гарах, аврах гарц, зам хаана байгааг мэддэг байх нь чухал. Мөн сургалтад хамрагдсан ажилтнууд онцгой байдал

үүссэн үед үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийг аюулгүй зогсооход баримтлах журам, дүрэм, зааврыг мэдэж байх нь нэн чухал юм.

Засвар үйлчилгээ

Ажлын байр, тоног төхөөрөмж, машин техник, багаж хэрэгсэл, байгууламжийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хангахын тулд засвар үйлчилгээг тогтмол хийж байх шаардлагатай. Засвар үйлчилгээг зохих ёсоор хийгээд явбал хөдөлмөрийн аюулгүй байдалд чухал хувь нэмэр оруулдаг. Тогтмол (төлөвлөгөөт) засвар үйлчилгээ нь гэнэтийн эвдрэл, саатлаас (тухайлбал, гал унтраагуурыг тогтмол шалгаж засаж байвал хэрэгцээ гарсан үед ашиглах боломжтой, харин ингэж чадаагүй нөхцөлд багахан хэмжээний гал гарсан ч унтрааж чадахгүй даамжирч, хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учруулж болзошгүй) урьдчилан сэргийлнэ.

Засвар үйлчилгээ нь дараах үндсэн хоёр төрөлтэй:

- ▶ Төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээ (тогтмол үзлэг шалгалт хийж, засвар, тохируулга хийх);
- ▶ Гэнэтийн засвар үйлчилгээ: Ажлын байрны байгууламж, тоног төхөөрөмжид гэнэтийн эвдрэл, саатал гарсан үед хийгддэг төлөвлөгөөт бус засвар. Саатсан ажлыг хэвийн үргэлжлүүлэхийн тулд энэ төрлийн засварыг аль болох хурдан дуусгах шаардлагатай болдог учраас ихэвчлэн төлөвлөгөөт засвараас илүү аюултай.

Эрсдэлийн үнэлгээ нь ихэвчлэн ажлын ердийн нөхцөлийг харгалзан үздэг. Гэхдээ засвар үйлчилгээний, ялангуяа төлөвлөгөөт бус засварын үед аюултай нөхцөл байдал үүсэж, ноцтой хохирол учрах, бүр хүний амь нас эрсдэх ч явдал тохиолдож болзошгүй. Иймд засвар үйлчилгээний ажлын эрсдэлийг ч мөн үнэлж, хянах арга хэмжээг тохируулан сонгох шаардлагатай.

- ▶ Засвар үйлчилгээний ажлын явцад ажилтнууд бүх төрлийн аюулд өртөх магадлалтай тул тэдгээрээс урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарах шаардлагатай. Жишээлбэл:
- ▶ Өндрөөс унах (дээвэр дээр болон машин механизмын өргөгдсөн хэсэгт засвар хийх үед);
- ▶ Хүнд биет унах (цагт хавчигдаад хүнд ачааг буруу өргөх үед);
- ▶ Хөдөлгөөнт эд анги, эсвэл машин механизмд хавчигдах, дарагдах (гэмтэлтэй роботын ажиллах бүсэд орох үед);

Асбестод өртөх (асбестон хавтан салгаж зайлуулах үед). Тоног төхөөрөмжийн гэмтэл, саатлын үед ажиллах нь тухайн тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг урьдчилан таамаглах боломжгүй болгодог. Тиймээс ийм нөхцөлд ажиллах үед учирч болох эрсдлийг нарийн үнэлж, хянах ёстой. Засварын ажлын явцад тохиолдсон ослын үр дагавар ямар ноцтойг дараах статистик илтгэнэ. Их Британид сүүлийн жилүүдэд боловсруулах үйлдвэрлэлийн салбарт нас барсан нийт тохиолдлын 25-30 хувийг

засвар үйлчилгээний үеийн осол эзэлж байна.¹⁵ Тоног төхөөрөмж суурилуулж, засвар үйлчилгээ хийдэг ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчдийн хувьд сургалт, ажлын туршлага нэн чухал учраас ажил гүйцэтгүүлэхийн өмнө гэрчилгээ, зөвшөөрлийг нь шалгаж баталгаажуулах ёстой.

Анхны тусламж ба эмнэлгийн тусламж үйлчилгээ

ХАБЭМ-ийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа ч осол гарч болдог. «Анхны тусламж» гэдэг нь эрүүл мэндийн ажилтан ирэхээс өмнө осолд өртсөн, эсвэл эрүүл мэндийн яаралтай тусламж шаардлагатай (жишээ нь, зүрхний шигдээс) болсон хүнд үзүүлэх шууд тусламж юм.

Үйлдвэр бүрд сайн тоноглогдсон анхны тусламжийн хэрэгсэл, ажлын цагаар анхны тусламж үзүүлэх үүрэгтэй, сургаж бэлдсэн ядаж нэг хүн байх ёстой (Үндэсний хууль тогтоомжоор аж ахуйн нэгжийн түвшинд үзүүлэх анхны тусламжид тавигдах шаардлагыг тогтооно.). Анхны тусламж үзүүлэх журам боловсруулахад тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлог, аюултай хүчин зүйлс, ажиллагчдын тоо, үйлдвэрийн байрны дотоод зохион байгуулалт, эрүүл мэндийн бусад нөөц / үйлчилгээний хүртээмж зэргийг харгалзах хэрэгтэй. Боломжтой бол ажлын байранд гэмтэж бэртсэн болон өвчтэй ажилтныг хэвтүүлж, тайван, аюулгүй орчинд эмчлэх эмнэлгийн өрөө байлгах нь зүйтэй. Энэ өрөөг мөн эмч, сувилагчийн үзлэгт ашиглаж болно.

Жижиг хэмжээний зүсэгдэлт, түлэгдэл, хөхрөлт, шөрмөсний суналт зэрэг энгийн гэмтлийг газар дээр нь эмчлэх боломжтой. Харин илүү ноцтой бэртэл гэмтлийн үед авах арга хэмжээний төлөвлөгөөг хөдөлмөрийн эрүүл мэндийн мэргэшсэн эмч, мэргэжилтнүүд боловсруулах шаардлагатай. Эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай тохиолдлын жишээнд:

- ▶ Нүдний гэмтэл: Нүдэнд орсон гадны биет (металл, модны үртэс гэх мэт)-ийг мэргэжлийн бус хүн авах оролдлого нь ноцтой хохирол учруулж, хараагаа алдахад ч хүргэж болзошгүй тул эмнэлгийн нарийн мэргэжлийн тусалцаа шаардлагатай;
- ▶ Их хэмжээний/гүн түлэгдэлт;
- ▶ Гүн зүсэгдэлт.

Зүрхний шигдээс, хордлого, цахилгаанд цохиулах зэрэг нь шууд хэвтүүлэн эмнэлгийн тусламж үйлчилгээг яаралтай үзүүлэх шаардлагатай тохиолдол юм.¹⁶

Томоохон аж ахуйн нэгжүүд өөрсдийн түргэн тусламжийн автомашинтай байдаг бол жижиг аж ахуйн нэгжүүд гэмтэж, өвдсөн ажилтныг эмнэлэг, бусад эрүүл мэндийн байгууллагад аюулгүй тээвэрлэн хүргэх зохицуулалтыг хийх ёстой.

¹⁵ The United Kingdom Health and Safety Executive (HSE) guidelines on hazards during maintenance: <https://www.hse.gov.uk/safemaintenance/hazards.htm>

¹⁶ Зүрх зогссон тохиолдолд (зүрх зогсоход хүргэдэг зүрхний шигдээс) дөрвөн минутын дотор эмчилгээ (дефибрилляци) хийснээр амьд үлдэх боломж (эмчилгээгүй) 5 хувиас 40-50 хувь хүртэл нэмэгддэг. ("First Aid", in ILO: Encyclopaedia of Occupational Health and Safety, 26 January 2011. <https://www.iloencyclopaedia.org/part-ii-44366/first-aid-a-tacili-medical-services/item/118-firaid>)

Ажилтнуудыг анхны тусламжийн болон амилуулах суурь тусламжийн сургалтад хамруулахыг зөвлөж байна. Ингэснээр тэд шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн ажилтнуудад туслах боломжтой. Нөгөө талаар зохих ур чадвар эзэмшээгүй ажилтны сайн санааны үүднээс хийсэн үйлдэл ноцтой үр дагавар дагуулж, хүний амь нас хохироохоос сэргийлнэ (тухайлбал, өндрөөс унасан хүнийг зөвшөөрөлгүй хөдөлгөх нь нурууны гэмтлийг хүндрүүлж, улмаар саажилт, үхэлд ч хүргэх аюултай). Мөн ухаан алдсан хүний хэл амьсгалын замыг боосноос амьсгалын дутагдалд орж үхэх эрсдэлтэй.

Олон аж ахуйн нэгж анхны тусламжийг зохих ёсоор үзүүлэх чадвартай ажилтны тоог хангалттай байлгах зорилгоор ийм сургалтыг тогтмол зохион байгуулдаг.¹⁷ Мөн газар хөдөлж, гал түймэр гарсан үед хариу арга хэмжээг шуурхай авах зорилгоор онцгой байдлын бэлтгэл сургуулилтыг төлөвлөх нь зүйтэй.

Эмх цэгц, зохион байгуулалт

Ажлын байрны эмх цэгц, зохион байгуулалтыг сайжруулахад ажлын байрыг цэвэр цэмцгэр байлгах, явган хүний зам, гарцыг саадгүй, чөлөөтэй байлгах, тоос шороог шүүрдэхийн өмнө чийглэх зэрэг олон зүйл багтана.

► Зураг 14. Ажлын байрны эмх цэгц зохион байгуулалтын жишээ



Эмх цэгцгүй байдал-эмх замбараагүй ажлын байр нь үр ашиггүй бизнесийн илрэл юм.



Цэвэрхэн, эмх цэгцтэй ажлын байр нь үр ашигтай бизнесийн илрэл юм.



Машиныг цэвэрлэхдээ шүүрдэж, хийгээр үлээлгэлгүй үйлдвэрийн зориулалттай тоос сорогч ашиглаарай.

¹⁷ Улаан загалмай нийгэмлэг анхны тусламжийн үнэгүй програмууд санал болгодог: <https://www.redcross.org.uk/first-aid/first-aid-apps#app>

Ажлын байр нь ажилтнууд өдөрт дор хаяж 8 цаг байдаг “гэр” нь билээ. Иймд бүгд хамтдаа ажлын байраа цэвэр цэмцгэр байлгах ёстой. Ажлын байр нь эмх замбараагүй, ажлын ширээ нь тоос шороотой, явган хүний зам, хаалга, цонхыг хайрцаг овоолж тагласан байгааг хяналтын байцаагч нар байнга шүүмжилдэг. Эдгээр нь эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй (материал овоорсон газраар хортон шавж үржих боломжтой) төдийгүй үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг саатуулж, гал түймэр гарах, онцгой байдлын үед барилга дотор гацах, агаарын урсгал хязгаарлагдах зэрэг ноцтой эрсдэлийг үүсгэнэ. Харин эсрэгээрээ үйлдвэрийн зориулалттай тоос соруулагч ашиглан тогтмол цэвэрлэгээ хийдэг ажлын байранд тоос, бохирдол буураад зогсохгүй, ажлын ерөнхий орчин сайжирч, ажиллагчдын эрүүл мэндэд тустай. Мөн дараах давуу тал үүснэ:

- ▶ Машин механизм урт хугацаанд цэвэр байх нь засвар үйлчилгээний зардлыг бууруулдаг;
- ▶ Өвчний улмаас ажилдаа ирэхгүй байх тохиолдлыг багасгадаг;
- ▶ Бүтээмжийг нэмэгдүүлснээр үйлдвэрт өрсөлдөх давуу талыг бий болгодог.

Товч дасгал: Аж ахуйн нэгжээрээ тойрон явж, зохих ёсоор аюулгүй хадгалах ёстой материалуудыг бичиж тэмдэглэ. Тоос, хог хаягдлыг нь цэвэрлэх шаардлагатай газар, гадаргуу байгаа эсэхийг тэмдэглэ. Үйлдвэрээ өдөр бүр эмх цэгцтэй байлгахын зэрэгцээ шинэ ажилтнаа мөн ингэж сургаарай.

ХУВИЙН АРИУН ЦЭВРИЙН ДАДАЛ ЗУРШИЛ, БАЙГУУЛАМЖ

Ажилтнууд хувийн ариун цэврээ сахих, гар угаах боломжийг бүрдүүлэхийн тулд угаалгын өрөө, байгууламжийг хүртээмжтэй байлгах шаардлагатай. Хувийн ариун цэврийг сайн сахих нь ажлын байрны аюултай хүчин зүйлд өртөх, химийн хорт бодис, халдварт өвчин үүсгэгч тарахаас сэргийлдэг.

Угаалгын өрөө нь хүрэхэд ойр дөт, үйлвэрлэлийн ажиллагаанаас бохирдохгүй байхаар тусгаарлагдсан, ажилтнуудын хэрэгцээнд тохирсон байх ёстой. Угаалтуур нь ажилтан гараа тохой хүртлээ угаахад хангалттай том хэмжээтэй, цоргыг нэг хөдөлгөөнөөр нээх, хаах боломжтой байх ёстой.

Хамгаалах хувцас хэрэглэдэг, эсвэл гадуур хувцас хортой бодисоор бохирдох эрсдэлтэй тохиолдолд хувцас солих өрөө байх ёстой (өмнө нь асбест олборлогчдын гэр бүл эдгээр ажиллагчдын хувцаст наалдсан бодист өртсөнөөр асбесттой холбоотой өвчин, тэр дундаа хорт хавдар тусдаг байсан). Хувцас солих хэсэг нь бохирдол хамгаалалтын хувцсаас өөрийн хувцас руу, нэг байгууламжаас нөгөөд тархахаас сэргийлсэн байршил, зохион байгуулалттай байх ёстой. Эрэгтэй, эмэгтэйчүүдэд зориулсан тусдаа өрөө байх шаардлагатай.

Хортой бодис залгих эрсдэлийг бууруулахын тулд ажилтан зөвхөн тусгай зориулалтын хэсэгт (жишээ нь, хоолны газар/тамхины цэг) л хооллох, уух болон тамхи татах ёстой. Хоол хүнс, усны бохирдлоос сэргийлэхийн тулд хоолны газар болон амрах байрыг цехийн ойролцоо байрлуулах ёсгүй. Эдгээр хэсгийг цэвэр байлгах бөгөөд хоол хүнсний үлдэгдэлд шавж, хулгана цуглахаас сэргийлж, шавж хортонтой тэмцэх ажилд онцгой анхаарал хандуулах ёстой. Бохирдлоос сэргийлж хоол бэлтгэхэд ашигласан бүх материалыг хэрэглэсний дараа битүү шүүгээнд хадгална.

Ус, ариун цэвэр, эрүүл ахуй нь хүний аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалахад чухал үүрэгтэй. Ялангуяа Ковид- 19 цар тахал шиг халдварт өвчний үед эдгээр нь онцгой чухал ач холбогдолтой. Дэлхийн хэмжээнд ундны аюулгүй ус болон зохих шаардлага хангасан ариун цэврийн үйлчилгээний хангамж, хүртээмж тэгш бус хэвээр байна.¹⁸ Зарим ажилтны хувьд зөвхөн ажлын байр нь л ундны аюулгүй ус болоод төвлөрсөн усан хангамжтай байх аж.

Бие засах газрыг цэвэр байлгаж сайн арчлахын зэрэгцээ төвлөрсөн хангамжийн халуун/бүлээн, хүйтэн устай, саван, гар ариутгах бодис, цаасан алчуураар байнга хангах хэрэгтэй. Дундын хэрэглээний даавуун алчуур нь халдварыг тараах эрсдэлтэй тул боломжтой нөхцөлд гар хатаагч, эсвэл цаасан алчууртай байх нь зүйтэй. Жорлонгийн тоо нь ажилтны тоотой шууд хамааралтай, бүх ажилтан, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байх шаардлагатай. Боломжтой бол эрэгтэй, эмэгтэй хүмүүст зориулсан тусдаа байгууламжтай байна. Харин ямар ч тохиолдолд нууцлалыг баталгаатай хангах (тухайлбал, түгжээтэй хаалгатай байх) ёстой. Бие засах газрын агааржуулалт, гэрэлтүүлэг шаардлага хангасан бөгөөд бохирдох эх үүсвэрээс хол байрлах ёстой. Бие засах газрыг тухайн байгууллага дээр байгаа бүх хүн, тэр дундаа хоол хүнс хүргэлтийн ажилтнууд, зочид, ачааны машины жолооч нар ч хэрэглэх боломжтой байхаар зохицуулна. Барилгын талбай, эсвэл хөдөөгийн нөхцөлд зөөврийн жорлонг бэлэн байлгах нь зүйтэй.

Ажлын байр нь аюулгүй, эрүүл орчин байх ёстой бөгөөд температур, чийгшил, агааржуулалт, гэрэлтүүлэг зэрэг хүчин зүйлс чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр хүчин зүйлс зохих шаардлага хангаагүй орчинд ажиллагчдын өртөх эрсдэл нэмэгдэж, осолд хүргэх магадлалтай. Ажил олгогч нь байгалийн гэрэл, агааржуулалтыг ашиглах зэрэг аргаар аюулгүй, эрүүл ажиллах орчныг бүрдүүлэх үүрэгтэй. Байгалийн агааржуулалт хангалтгүй тохиолдолд агааржуулалтын нэмэлт тоног төхөөрөмж, жишээ нь сэнс, агааржуулагч суурилуулж, засвар үйлчилгээ хийх (шүүлтүүрийг нь солих, агаарын урсгалыг шалгах зэргээр) шаардлагатай. Тоос, утаа ялгаруулдаг байгууламжид яндангийн агааржуулалт, эсвэл усан систем гэх мэт инженерийн хяналтын арга хэрэглэнэ. Ажил олгогч нь дуу чимээ, чичиргээ, аюултай хүчин зүйлсийг тогтмол шалгуулах (химийн бодис гэх мэт илэрхий хүчин зүйлсээс гадна цацраг гэх мэт далд хүчин зүйлсийг ч хамруулах) хэрэгтэй.

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭ

Ажил, үйлдвэрлэлийн аюулгүй систем, эсвэл өөр аргаар бүрэн арилгаж, хянах боломжгүй эрсдэлтэй тохиолдолд ажил олгогч аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ байрлуулна. Тэмдэг, тэмдэглэгээ нь үндэсний дүрэм, журамд нийцсэн байх бөгөөд машин механизм дээр болон бусад шаардлагатай газарт харагдахуйцаар байрлуулсан байх ёстой. Бүх хүнд ойлгомжтой байхын тулд тэмдэг, тэмдэглэгээний бичвэрийг албан ёсны хэлээр үйлдэж, шаардлагатай тохиолдолд орон нутгийн хэл рүү орчуулах хэрэгтэй. Тухайн байгууллагад нэвтрэх эрхтэй зочид, гадны хүмүүст аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээний утга, тэдгээрийг дагаж мөрдөх шаардлагыг тайлбарлаж өгөх ёстой.

18 ОУХБ: Employment-Intensive Investment Programme (EIIP) Guidance: Technical note on water, sanitation and hygiene (WASH) interventions in response to COVID-19, 14 May 2020. Available at: https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/documents/publication/wcms_744731.pdf

Ийнхүү тайлбарласан хуудас тараах нь үр дүнтэй байж болно. Зураг нь тод, бичвэр болон зураг нь хол зайнаас харагдаж, уншигдахуйц байх ёстой. Учир нь тэдгээрийг унших гэж машин механизмд хэт ойртох нь мөргүүлж, дарагдах аюултай. Хүн ажиллаж байгаа бүх л газарт аюулгүй байдлын тэмдэг, тэмдэглэгээг байрлуулна. Шаардлагатай үед ажил олгогчид дараах арга хэмжээ авна:

- ▶ Ажлын байрны дотоод зорчих хөдөлгөөнийг зохицуулахад тэмдэг, тэмдэглэгээ ашиглах;
- ▶ Байрлуулсан тэмдэг, тэмдэглэгээ арчилж тордох;
- ▶ Байрлуулсан бүх тэмдэг, тэмдэглэгээний талаар сургалт явуулах, ажилтнуудад шинэ, танил бус тэмдэг, тэмдэглэгээг тайлбарлаж, тэдгээрийг харвал юу хийхийг зааж өгөх ёстой.

Ажилтнууд аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээнд заасан зааврыг дагаж мөрдөх бөгөөд тэдгээрийг авч хаях, зайлуулах, үл тоомсорлох, эсвэл халхлах үйлдэл гаргаж болохгүй.

Аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээнд заасан заавар нь гадны хүмүүст (жишээ нь, хүргэлтийн ажилтан, үйлчлүүлэгч) тодорхой анхааруулга болдог. Ажлын байраа тойрч байрлуулсан тэмдэг, тэмдэглэгээ, зурагт хуудас, зураас, пайзыг нэг бүрчлэн тэмдэглэх замаар тэдгээрийн хэрэглээ, байршлыг үнэлэх хэрэгтэй. Бүрэн арилгасан аюулын талаарх тэмдэг, тэмдэглэгээг авч хаях нь зүйтэй. Учир нь шаардлагагүй тэмдэг, тэмдэглэгээ анхаарал сарниулж болзошгүй.

Тэдгээрийн хэмжээ, өнгө, дүрс, бичвэр (ихэвчлэн АЮУЛТАЙ, АНХААР, БОЛГООМЖИЛ) нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй үндэсний дүрэм, журамд нийцсэн байх ёстой. Ингэснээр зөв байрлуулсан үед (ерөнхий тэмдэг, тэмдэглэгээний хувьд ихэвчлэн 1.5-2 метрээс доошгүй) зайнаас тод харагдаж, ойлгогдохуйц байна.

▶ **Зураг 15. Аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээний жишээ**



БОЛОВСРОЛ, СУРГАЛТ

ОУХБ нь ХАБЭМ-ийнн боловсрол, сургалтыг^{19,20} зөвхөн аж ахуйн нэгжийн түвшнээр хязгаарлалгүй ерөнхий боловсролын тогтолцоонд нэвтрүүлэхийг дэмждэг.

Энэ нь ажиллагчид, ажил олгогчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөрийн илүү өргөн хүрээнд аюулгүй байдал, эрүүл мэндийн ач холбогдлыг таниулахад өндөр үр нөлөөтэй хандлага юм.

ОУХБ-ын хэм хэмжээг хэрэгжүүлэхээр нэгдсэн олон оронд ажил олгогч ХАБЭМ-ийн сургалт явуулах үүрэг хүлээдэг бөгөөд үүний үр дүнд ажиллагчдын хувьд бодит, хэмжигдэхүйц ахиц гарсан байна.

ХАБЭМ-ийн боловсрол, сургалт нь хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн аюулгүй байдал, эрүүл мэндийг сайжруулдаг. Өмнөд Африкт ойн аж ахуйн 300 ажилтанд хийсэн судалгаагаар 2005 онд ХАБЭМ-ийн боловсрол, сургалтын хөтөлбөр нэвтрүүлсний дараа үйлдвэрлэлийн ослын улмаас гэмтэж бэртсэн тохиолдлын тоо мэдэгдэхүйц буурчээ. Графикт нил ягаан өнгийн баганаар жил бүрийн гэмтэл бэртийн тоог харуулж байна.

► **Зураг 16. Ойн аж ахуйн компанид 2005 онд аюулгүй ажиллагааны сургалт нэвтрүүлсний өмнөх ба дараах үеийн ажлын байранд гэмтсэн тохиолдлын тоо (2013-2003)**



Эх сурвалж: Хлони Нкомо ба бусад. *Effectiveness of Health and Safety Training in Reducing Occupational Injuries Among Harvesting Forestry Contractors in KwaZulu-Natal*. Continuing education. Workplace Health & Safety, vol. 66, №10.

19 155 дугаар конвенцоор боловсрол, сургалтын бүх түвшинд ХАБЭМ-ийн боловсрол олгохыг дэмжих арга хэмжээ авахыг гишүүн орнуудад даалгасан.

20 ОУХБ-ын Ирээдүйн хөдөлмөрийн тухай дэлхийн комисс “бүх хүний насан туршдаа сурч боловсрох эрхийг албан ёсоор хүлээн зөвшөөрч, насан туршийн боловсролын үр дүнтэй тогтолцоог бий болгох”-ыг уриалсан юм (*Гэрэлт ирээдүйн төлөө ажиллацгаая* (Женев, 2019), хуудас 34: https://www.ilo.org/sites/default/files/wcmsp5/groups/public/%40asia/%40ro-bangkok/%40ilo-beijing/documents/publication/wcms_703151.pdf).

Боловсрол, сургалтын давуу талд урам зориг, ХАБЭМ-ийн үйл ажиллагаанд оролцох эрмэлзэл, аюулгүй, эрүүл зан үйл, ажлын зохион байгуулалт зэрэг нийгэм-сэтгэл зүйн эерэг хүчин зүйлс багтана.

Сургалтыг үр дүнд хүргэхийн тулд ажил олгогч, удирдлагын баг түүнийг дэмжиж, бизнесийн үйл ажиллагаанд нэгтгэх шаардлагатай. Ажилтнууд болон үйлдвэрчний эвлэлийг идэвхтэй оролцуулах хэрэгтэй. Ментор, сургагч багшийн үүрэг гүйцэтгэх чадвартай ахмад ажилтнууд туршлагаасаа хуваалцах болон бусад байдлаар хувь нэмэр оруулах боломжтой. Сургалтын агуулга, материал нь тухайн үйлдвэрлэлийн салбарын онцлог, эрсдэлд тохирсон, онолын болон практикийн хэсгүүд тэнцвэртэй, оролцооны арга барилаар зохион байгуулагдах нь чухал.

Сургалтыг бүх оролцогчид ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар явуулбал зохино (шаардлагатай тохиолдолд орон нутгийн хэлээр, алслагдсан хөдөө нутагт явуулын баг зохион байгуулж болно).

Сургалтын хөтөлбөрт дараах шаардлагыг тавих нь зүйтэй. Үүнд:

- ▶ Аж ахуйн нэгжийн бүх гишүүдийг хамарсан байх;
- ▶ Чадварлаг хүмүүсээр удирдуулах;
- ▶ Анхны болон давтан сургалтыг цаг алдалгүй, үр дүнтэй байдлаар тохиромжтой хугацаанд зохион байгуулах;
- ▶ Оролцогчид сургалтын агуулгыг хэр сайн ойлгож, эзэмшсэнийг үнэлэх;
- ▶ Тогтмол хугацаанд хянан үзэх. Энэхүү ажиллагаанд ХАБЭМ-ийн хорооны төлөөлөгчдийг оролцуулж, сургалтын хөтөлбөрийн үр нөлөө, ач холбогдлыг нь алдагдуулахгүйн үүднээс шаардлагатай гэж үзвэл шинэчилж байх
- ▶ Аж ахуйн нэгжийн хэмжээ, үйл ажиллагааны онцлогийг харгалзан шаардлагатай тохиолдолд баримтжуулж байх

Сургалтыг бүх оролцогчид ажлын цагаар, үнэ төлбөргүй явуулж байх ёстой. Ингэснээр ажил олгогч ажилтнуудад цаг хугацааны болон санхүүгийн дарамт үүсгэхгүйгээр сургалт зохион байгуулах үүргээ биелүүлэх боломж бүрдэнэ.

АЖИЛ ОЛГОГЧИЙН ДОТООД ХЯНАЛТ

Ажил олгогч нь ажилтнуудыг зохих удирдлагаар хангаж, хяналт тавих ёстой.

Ахлагч нар аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлаар ямар үүрэгтэйгээ мэддэг байх ёстой. Тэд аж ахуйн нэгжийнхээ ХАБЭМ-ийн бодлого, тэр дундаа өөрсдийн хүлээх үүрэг, хариуцлага, мөн ажил олгогч уг тогтолцоог хэрхэн удирдах хүсэлтэйг ойлгож мэдсэн байх шаардлагатай. Иймд тэднийг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой аюул, эрсдэлийг хэрхэн хянах талаар сургах хэрэгтэй. Удирдлагад нь ажиллаж буй ажилтнууд ажлын байрны эрсдэл, тэдгээрийг хянах арга хэмжээг ойлгож мэдсэн байхад ахлагч нар анхаарал тавина. Шинэ, туршлагагүй, эсвэл залуу ажилтнууд, түүнчлэн тухайн улсын хэл эх хэл нь биш хүмүүст бусад

ажилтнаасилүү чиглүүлэг, хяналт хэрэгтэй байх магадлалтай.

Ажил олгогч нь ажилтнууд санаа зовниж байгаа асуудлаа хэрхэн мэдээлэхийг мэддэг байхад анхаарах ёстой. Харин ахлагч нар мэдлэг, туршлага дутмаг байдал болон харилцааны бэрхшээлээс үүдэж болох таагүй асуудлуудыг мэддэг байх шаардлагатай. Тэд мөн эрсдэлийг хянах арга хэмжээ нь ач холбогдлоо алдаагүй, тохирсон байхын зэрэгцээ тэдгээрийг тухай бүр шинэчилж, хэрэгжилтэд нь хяналт тавьж байгаа эсэхийг шалгаж нягтална. Гэрээгээр ажил гүйцэтгэгчдийн үйл ажиллагаа нь аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах зохицуулалтыг ажил олгогч бүрдүүлэх шаардлагатай.

Үр дүнтэй хяналт нь ажил олгогч зохион байгуулдаг сургалтынхаа үр нөлөөг үнэлэх, ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, чадамжтай байгаа эсэхийг тодорхойлоход тусалдаг. Ахлагч нар ХАБЭМ-ийн талаарх аливаа зохицуулалт хэрэгжихгүй байгааг ажиглавал нөхцөл байдлыг засаж залруулах арга хэмжээ авах ёстой. Жишээлбэл, хамгаалалтын баггүй ажиллаж буй гагнуурчин дан ганц өөрийнхөө аюулгүй байдал, эрүүл мэндийг төдийгүй ажил олгогчийг ч эрсдэлд оруулж болзошгүй. Үүний улмаас ажил олгогч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал төлж, даатгалын зардал нь нэмэгдэхээс гадна компанийн нэр хүндэд ч нөлөөлж болох юм.

ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ

Эрсдэлийг хянах хамгийн сүүлчийн түвшин бол хувийн хамгаалах хэрэгсэл (XXX) юм. XXX нь ажлын байрны аюулаас хамгаалж, хохирол учрах эрсдэлийг бууруулдаг. Хүний биеийн янз бүрийн хэсгийг хамгаалах зорилгоор эдгээр хэрэгслийг бүтээсэн байдаг. Жишээ нь, хамгаалалтын дуулга, хамгаалалтын нүдний шил, амны хаалт, хорт хий, утааны баг, чихний хамгаалалт, хормогч, өндрийн бүс, бээлий, хамгаалалтын түрийтэй болон түрийгүй гутал гэх мэт.

Эрсдэлийг хянах арга хэмжээний шатлалын тухай өмнөх хэсэгт дурдсанчлан илүү үр нөлөөтэй бусад арга хэмжээ хангалтгүй байгаа тохиолдолд л XXX-ийг хэрэглэх ёстой. Ийм тохиолдолд ажил олгогч ажилтныг (дуу чимээ, тоос, химийн бодис гэх мэт) тодорхой аюулаас хамгаалах хэрэгслээр хангах үүрэг хүлээдэг.

XXX нь үндэсний хууль тогтоомж, хамаарах тохиолдолд олон улсын стандартад нийцсэн байх ёстой. Мөн нөхцөл байдалд тохирсон, үр дүнтэй хамгаалдаг (жишээлбэл, хоол үйлдвэрлэлийн ажилтнуудыг том металл сав, цахилгаан хэрэгсэл зэрэг унаж болзошгүй зүйлээс хамгаалах, мөн халуун шингэн асгарах үед хальтарч, түлэгдэхээс сэргийлэх зориулалттай хамгаалалтын гутал) байх ёстой. Хэрэглэж байгаа хүндээ тохирох хэмжээтэй (жишээлбэл, хамгаалалтын бээлий нь бүх ажилтан, тэр дундаа эмэгтэйчүүдэд таарах сонголттой байх) байхын зэрэгцээ эдгээрийг үнэгүй олгож, шаардлагатай үед засварлаж, сольдог байх шаардлагатай.

Ажилтнуудыг XXX-ийг зөв хэрэглэх, цэвэрлэж арчлах, засварлах, устгах, хадгалах сургалтад хамруулна. XXX-ийн бүрэн бүтэн байдал алдагдсан аливаа тохиолдлыг (цахилгаан тусгаарлагч бээлий цоорсон гэх мэт) ажил олгогч, эсвэл ахлагчдаа нэн даруй мэдэгдэх ёстой. Учир нь ийм тохиолдлыг анзаараагүй, эсвэл үл тоомсорлосны улмаас ноцтой хохирол учирч болзошгүй.

XXX-ийг аюулын эсрэг хамгийн сүүлчийн хамгаалалт гэж үздэгийг санаарай.

► **Зураг 17. Янз бүрийн ХХХ өмссөн ажилтнууд**



АЛХАМ 4: ЭРСДЭЛИЙГ ХЯНАХ ЯМАР АРГА ХЭМЖЭЭГ ХЭН ХАРИУЦАЖ, ХЭЗЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХИЙГ ТЭМДЭГЛЭХ

Энэ үе шатанд Алхам 3-т сонгосон ХАБЭМ-ийн эрсдэлийг хянах арга хэмжээг ажил олгогч хэрэгжүүлнэ. Эдгээр арга хэмжээг ихэвчлэн ахлагч, менежер, эсвэл аж ахуйн нэгжийн ХАБЭМ-ийн хороонд хариуцуулдаг. Мөн арга хэмжээг хэрэгжүүлэх боломжит хугацааг тодорхойлно. Хяналтын арга хэмжээг хэрэгжүүлсэн огноог тэмдэглэх нь чухал. Энэхүү мэдээлэл нь хяналтын байцаагч нар холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг шалгахад болон бусад зүйлд хэрэг болж магадгүй.

Дүгнэж хэлэхэд дараах зүйлсийг тодорхой шийдэж, тэмдэглэх ёстой:

- Аж ахуйн нэгжийн түвшинд хариуцаж арга хэмжээ авах хүн.²¹ Тухайн хүний бүтэн нэр, албан тушаалыг эрсдэлийн үнэлгээний хүснэгтэд бичнэ (жишээ нь, Менежер: Маргарет Чанг; Ахлагч: Роберт Ачебе);

21 Ажил олгогч эдгээр ажлыг ихэвчлэн ХАБЭМ-ийн талаар зохих мэдлэг, ур чадвар эзэмшсэн менежер, эсвэл нэгжийн удирдлага, ахлагч нарт даалгадаг.

- ▶ Арга хэмжээг хэрэгжүүлсэн байх огноо (жишээ нь: 20/12/2020);
- ▶ Эрсдэлийг хянах арга хэмжээг хэрэгжүүлсэн огноо (жишээ нь: 01/11/2020).

Алхам 1	Алхам 2	Алхам 3		Алхам 4		
Ямар аюул байна вэ?	Хэн, хэрхэн хохирч болох вэ?	Одоо ямар арга хэмжээ авч байгаа вэ?	Цаашид ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?	Хариуцаж хэрэгжүүлэх хүн	Хэрэгжүүлсэн байх хугацаа	Хэрэгжүүлсэн хугацаа
Модны тоосонд өртөх	Бүх ажилтан (35 хүн) модны тоосоор амьсгалснаас гуурсан хоолойн багтраа зэрэг амьсгалын замын өвчнөөр өвчлөх эрсдэлтэй. Машины операторууд (15 хүн) өртөх эрсдэл илүү өндөр. Хатуу модны тоосонд өртөх нь хорт хавдар, ялангуяа хамрын хөндийн (хамар орчмын) хорт хавдар үүсгэдэг.	-Тоосыг тогтмол соруулдаг - Угаалгын өрөө, шүршүүр сайтай -Нэг удаагийн тоосны маск өгч, тогтмол сольдог.	-Тоосыг тогтмол соруулдаг - Угаалгын өрөө, шүршүүр сайтай -Нэг удаагийн тоосны маск өгч, тогтмол сольдог.	Менежер М.Чанг Ахлагч Р. Ачебе Менежер М. Чанг	20/11/2020 01/10/2020 (яаралтай) 31/12/2020	10/09/2020 01/10/2020 30/09/2020
Алхам 5. Эрсдэлийн үнэлгээний үр дүнг бичиж тэмдэглэх, хяналт-шинжилгээ хийх, хянаж нягтлах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх						

АЛХАМ 5: ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ХЯНАЖ НЯГТЛАХ, ШААРДЛАГАТАЙ ТОХИОЛДОЛД ШИНЭЧЛЭХ

Эрсдэлийн үнэлгээний алхам бүрийг холбогдох мэдээллийн хамт бичиж тэмдэглэн, нийт ажилтнууд, ахлагч нар болон ХАБЭМ-ийн байцаагчдад нээлттэй байлгах ёстой. Үүнийг хялбар хэрэгжүүлэхэд дээр үзүүлсэн жишээ хүснэгтийг ашиглаж болно.

Практикт эрсдэлийн үнэлгээгээр арга хэмжээ авах шаардлагатай олон төрлийн аюулыг тодорхойлдог. Аж ахуйн нэгжүүдэд химийн бодист өртөх, дуу чимээ, хальтирах, бүдрэх, унах, тээврийн хэрэгсэл, цахилгааны асуудал, гал зэрэг зарим аюул нийтлэг тохиолддог. Өмнө дурдсанчлан эрсдэлийн үнэлгээг тухайн аж ахуйн нэгжийн хэрэгцээнд тохируулан хийх ёстой.

Эрсдэлийн үнэлгээг бичгээр баримтжуулж хадгалах нь бүх томоохон аюулыг олж илрүүлэн тэдгээрт өртөж буй хүмүүсийн тоо, эмзэг байдлыг харгалзан арга хэмжээ авсныг харуулдаг. Үүнээс мөн хяналтын арга хэмжээнүүд хангалттай, үлдэгдэл эрсдэл бага байгааг харж болно. Бичгээр үйлдсэн ийм баримт ажил олгогч, ахлагч

нар, ажилтнууд болон байцаагчдад хэрэгцээтэй. Энэ нь аж ахуйн нэгжийн бүх хүн хууль тогтоомжийн дагуу эрүүл, аюулгүй ажиллах орчин бүрдүүлэх хүсэл эрмэлзэлтэй байгааг илтгэнэ.

ХЯНАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Эрсдэлийг хянах арга хэмжээний үр дүнд тогтмол хяналт-шинжилгээ хийж, үр нөлөө нь тогтвортой хадгалагдах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал. Эрсдэлийн үнэлгээний явцад тодорхойлсон арга хэмжээнүүд амжилттай хэрэгжсэн үү? Өөрөөр хэлбэл илрүүлсэн аюул бүрийн эрсдэл буурч, зорилтот бүлэг хамгаалагдаж чадсан уу? Ажлын байрны үзлэг шалгалт хийх ажилтан эрсдэлийн үнэлгээний явцад тодорхойлсон (өмнө байсан болон шинээр нэмсэн) хяналтын арга хэмжээг ажилтнууд хэрэгжүүлж байгаа эсэхийг шалгаж нягтлах ёстой. Ийм явцын хяналт-шинжилгээг ажилтнууд, ХАБЭМ-ийн хорооны гишүүд төдийгүй менежер, ахлагч нар ч хийж байх ёстой. Хяналт-шинжилгээний үр дүнгээс хийх давтамж нь хамаардаг. Хяналтын арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, ажилтнууд аюул, эрсдэлийн талаар хангалттай ойлголтой байгаа тохиолдолд хяналт-шинжилгээ хийх давтамжийг багасгаж болно. Харин ямар ч хяналтын арга хэмжээг хэрэглээгүй, ажилтнуудаа сургаагүй байх тохиолдолд хяналт-шинжилгээг илүү олон удаа хийх шаардлагатай.

Эрсдэлийг хянах арга хэмжээний үр нөлөөг тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжих нь зүйтэй. Үүнийг тодорхой шалгуур үзүүлэлтүүд ашиглан хийж болно.

“Шалгуур үзүүлэлт” гэдэг нь аж ахуйн нэгжийн ХАБЭМ-ийн бодлогын үр дүн, түүнд тодорхойлсон зорилгын хэрэгжилтийг дүгнэж цэгнэх боломж олгодог хэмжиж, үнэлж болохуйц өгөгдөл юм. Эдгээрийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, дууссан болон шинэчилсэн эрсдэлийн үнэлгээний тоо, ажлын байрны хяналт шалгалт, нийтэд нээлттэй статистикийн мэдээлэл зэрэг олон эх сурвалжаас авч болно. Шалгуур үзүүлэлтүүдийг анхны хяналт-шинжилгээний шатанд тодорхойлж, хэмжих шаардлагатай бөгөөд дараа нь тодорхой хугацааны давтамжтайгаар хэмжиж, цаг хугацааны явцад гарах өөрчлөлтийг хянах боломжтой болно (жишээлбэл, ажилтнуудад зориулан ХАБЭМ-ийн сургалт тогтмол явуулдаг болсны дараах үйлдвэрлэлийн ослын чиг хандлага). Хяналт-шинжилгээг үр дүнтэй хийхийн тулд шалгуур үзүүлэлт нь тухайн асуудалтайгаа шууд холбоотой, тоо болон чанарыг хэмждэг, салбар, чиглэл бүрийн гүйцэтгэлийг хамарч, сайн, найдвартай өгөгдөлд үндэслэх ёстой. Жишээлбэл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүрэн бүртгээгүй бол өгөгдөл нь бодит байдлыг илэрхийлэхгүй, асуудлын цар хүрээг дутуу үнэлэх болно.

Тодорхой хугацааны өгөгдлийг харьцуулж үзсэнээр эрсдэлийн үнэлгээний баг тухайн аж ахуйн нэгж эрсдэлээ хэрхэн хянаж байгааг ойлгох боломжтой болно. Үнэлгээ хийж байгаа баг “өгөгдсөн хугацаанд бүх шинэ ажилтныг сургалтад хамруулах” гэх мэтээр бодитой, хэрэгжихүйц зорилтууд тодорхойлох нь зүйтэй. Ингэснээр тэдгээрийн үр дүнг хэмжих холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг (жишээ нь, тухайн аж ахуйн нэгжид буй эрсдэл, түүний дотор нийгэм-сэтгэл зүйн болон яс-булчингийн өвчин үүсгэж болзошгүй эрсдэлийн талаарх тестэд хамгийн өндөр оноо авсан шинэ ажилтны тоо) боловсруулахад дөхөм болно. Ажилтнууд, ажлын байр, машин механизм, ажил гүйцэтгэх дүрэм, журам, заавар, ажлын байрны үзлэг шалгалт, эрсдэлийг хянах аргахэмжээ, хуулийн хэрэгжилт, зочдод өгсөн аюулгүй байдлын талаарх мэдээлэл, сайн дураар хэрэгжүүлэх стандарт зэрэг олон асуудалтай холбоотой шалгуур үзүүлэлт боловсруулж болно.

Мөн дараах гол үзүүлэлтүүдийг хянаж байх хэрэгтэй. Үүнд: ажилтан-удирдлагын хамтарсан ХАБЭМ-ийн хороо, эрсдэлийн үнэлгээний тоо, ажлын байрны үзлэг шалгалтын тоо, аюулгүй ажиллагааны журам зөрчсөн үйлдлүүд, аврах гарцын нөхцөл

байдал, ХХХ-ийн хэрэглээ, осол, осолд дөхсөн тохиолдлын тоо, тэдгээрийг судалж шалгасан байдал.

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ ХЯНАЖ НЯГТЛАХ, ШИНЭЧЛЭХ

Эрсдэлийн үнэлгээ нь нэг удаагийн үйл ажиллагаа биш юм. Үнэлгээг дор хаяж жилд нэг удаа, шаардлагатай тохиолдолд (тухайлбал, шинэ тоног төхөөрөмж, бодис, арга барил нэвтрүүлсэн үед) түүнээс ч ойр ойрхон хянан үзэж, нэмэлт, өөрчлөлт оруулж байх ёстой.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАНДАЛТ СУДАЛГАА

Хөдөлмөрийн анагаах ухааны эмч, сувилагч болон ажлын байранд эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн бусад ажилтнууд нийт ажиллагчдын эрүүл мэндийг дэмжих, ажил, хөдөлмөртэй холбоотой бэртэл гэмтэл, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг илрүүлж оношлох, эмчлэх ажилд идэвхтэй оролцох ёстой. Эрүүл мэндийг тандах үйл ажиллагаанд эрүүл мэндийн үзлэг (ажилд орохоос өмнөх үзлэг, тогтмол үзлэг, шаардлагатай үеийн үзлэг, эрүүл мэндийн шалтгаантай урт хугацааны чөлөөний дараа ажилдаа эргэж ирэхэд хийх үзлэг, ажлаас халагдсаны дараах үзлэг), шаардлагатай тохиолдолд хийх нарийн шинжилгээ, аппаратын оношилгоо орно. Ажил олгогч нь ажилтан хуульд заасан эрүүл мэндийн үйлчилгээг цаг тухайд нь авах боломжоор хангах үүрэгтэй.

Эмнэлгийн үзлэгийн үр дүн, эрүүл мэндийн бусад мэдээллийн нууцлалыг чанд хадгалах бөгөөд ажилтныг ялгаварлан гадуурхахад ашиглах ёсгүй. Гэхдээ жилд тохиолдсон үйлдвэрлэлийн ослын тоо, төрөл гэх мэт мэдээллийг нэгдсэн, нэр усгүй хэлбэрээр ажилтнууд болон тэдний төлөөлөгчдөд мэдээлэх боломжтой. Эрүүл мэндийн бүртгэлийг найдвартай газар хадгалж, хамгаалах ёстой. Үүнд мэдээллийг компьютерээр буюу цахим хэлбэрээр боловсруулж, хадгалахыг хамааруулна. Эдгээр бүртгэлийг ирээдүйд ашиглах зорилгоор хадгалах бөгөөд ажилтан өөрийн эрүүл мэндийн бүртгэлд нэвтрэх, авах эрхтэй. Хөдөлмөрийн эрүүл мэндийн бүртгэл нь эрүүл мэндийн судалгаа, шинжилгээнд чухал ач холбогдолтой мэдээллийн эх сурвалж болдог.

Алхам 5-д зориулсан тусгай маягт байхгүй ч үнэлгээний энэ таван алхмыг бичиж тэмдэглэн, шинэчилж байх нь аж ахуйн нэгж ХАБЭМ-ийг сайжруулах хүсэл эрмэлзэлтэй байгаагийн нотолгоо болдог.

Алхам 1	Алхам 2	Алхам 3		Алхам 4		
Ямар аюул байна вэ?	Хэн, хэрхэн хохирч болох вэ?	Одоо ямар арга хэмжээ авч байгаа вэ?	Цаашид ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?	Хариуцаж хэрэгжүүлэх хүн	Хэрэгжүүлсэн байх хугацаа	Хэрэгжүүлсэн хугацаа
Алхам 5.	Эрсдэлийн үнэлгээнд хяналт-шинжилгээ хийх, хянаж нягтлах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх					

► 4. ХАБЭМ-ИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Эрсдэлийн үнэлгээ нь аж ахуйн нэгжийн ХАБЭМ-ийн нэг тулгуур багана юм. Ажил олгогч, менежерүүд болон ажилтнууд нь хүсэл эрмэлзэлгүй, аюул, эрсдэл болон тэдгээрийг хянах арга хэмжээний үр нөлөөг тодорхой ойлгоогүй нөхцөлд энэ чиглэлд жигд ахиц дэвшил гарч, үр дүн нь тогтвортой хадгалагдах боломжгүй. Эрсдэлийн үнэлгээ нь аюулгүй байдал, эрүүл мэнд төдийгүй бүтээмжид эерэг нөлөө үзүүлдэг, хэмжигдэхүйц үр дүнтэй үйл ажиллагаанд суурилсан системтэй хандлагыг нэвтрүүлдэг.

ОУХБ үндэсний болон аж ахуйн нэгжийн түвшинд ХАБЭМ-ийг дэмжихэд чиглэсэн удирдамжийг гаргасан байна. ЖДААН-үүдэд шууд хамааралтай тус удирдамж нь дараах зорилготой:

- (a) ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүдийг [аж ахуйн нэгжийн] бодлого, удирдлагын зохион байгуулалтын хүрээнд нэгтгэн хэрэгжүүлэхэд зөвлөмж өгөх;
- (б) [аж ахуйн нэгжийн] бүх гишүүд, ялангуяа ажил олгогч, эзэд, удирдах ажилтнууд, ажилтнууд болон тэдний төлөөлөгчдөд ХАБЭМ-ийн удирдлагын зарчим, аргуудыг зохистой хэрэгжүүлж, байгууллагынхаа ХАБЭМ-ийн нөхцөлийг тасралтгүй сайжруулах урам өгөх.²²

► 4.1 ХАБЭМ-ИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО (ХАБЭМУТ): ТОДОРХОЙЛОЛТ БА ЗОРИЛГО

ХАБЭМУТ ГЭЖ ЮУ ВЭ?


Удирдлагын тогтолцоо нь тоног төхөөрөмж худалдан авах, бизнесээ өргөжүүлэх, шинэ тавилга сонгох гэх мэтээр бизнесийн болон өдөр тутмын амьдралын шийдвэр гаргах явцад өргөн хэрэглэгддэг. ХАБЭМУТ нь ХАБЭМ-ийн шалгуур, стандарт, гүйцэтгэл дээр суурилдаг бөгөөд ажлын байрны аюул, эрсдэлийг үр дүнтэй удирдах замаар осол, бусад таагүй тохиолдлоос урьдчилан сэргийлэх чиглэлээр тухайн байгууллагын гүйцэтгэлийг үнэлэх, сайжруулах логик, шаталсан аргачлалыг нэвтрүүлэхийг зорьдог. Энэ хүрээнд юуг хэрхэн хамгийн үр дүнтэй хийх шаардлагатай байгааг тодорхойлж, тодорхойлсон зорилгодоо хүрэх ажлын явцыг хянах, авсан арга хэмжээний үр дүнг үнэлэх, цаашид сайжруулах хэрэгцээг тодорхойлох алхмууд хийгдэнэ. Уг тогтолцоог аж ахуйн нэгжид гарсан аливаа өөрчлөлт, хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн өөрчлөх боломжтой.

ХАБЭМ-ийн асуудал, үүнд үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах нь ажил олгогчийн үүрэг, хариуцлага юм.²³ Ажил олгогч нь аж ахуйн нэгжийн түвшинд ХАБЭМ-ийн үйл ажиллагааг тууштай хэрэгжүүлэхээ харуулж, ХАБЭМУТ-г бүрдүүлэх арга хэмжээг авах ёстой. Энэхүү тогтолцооны үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг доор үзүүлэв.

²² ОУХБ: *Guidelines on occupational safety and health management systems, ILO-OSH 2001* (web page), 1-р хэсэг: “Зорилт”.
https://www.ilo.org/global/topics/safety-and-health-at-work/normative-instruments/WCMS_107727/lang-en/index.htm

²³ 155 дугаар конвенцын 19 дүгээр зүйлийн а-д “Ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэх явцдаа ажил олгогч хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь хамтран ажиллана” гэж засны дагуу ажилтнууд бас үүрэг хүлээнэ.

► **Зураг 18. ОУХБ-ын ХАБЭМУТ-г тасралтгүй сайжруулах мөчлөг**



ХАБЭМУТ нь аж ахуйн нэгжийн хэмжээ, үйл ажиллагааны онцлогт тохируулан уян хатан байдлаар хэрэгжүүлэх боломжтой логик арга хэрэгслийн багц бөгөөд тухайн үйлдвэрлэл, үйл ажиллагаатай холбоотой бүх аюул, эрсдэлийг хамруулан авч үздэг. ХАБЭМУТ нэвтрүүлснээр дараах нөхцөл хангагдана. Үүнд:

- урьдчилан сэргийлэх болон хамгаалах арга хэмжээ үр дүнтэй, тууштай хэрэгждэг болсон;
- бодлого боловсруулж батлагдсан;
- үүрэг амлалт авч, итгэл үнэмшилтэй болсон;
- аюул, эрсдэлийг үнэлэхдээ ажлын байрны бүх хүчин зүйлийг харгалзан үзсэн;
- удирдлага, ажилтнууд өөрсдийн хариуцлагын түвшинд болж буй үйл явцад оролцдог болсон.

► 4.2 АЖ АХУЙН НЭГЖИЙН ХАБЭМ-ИЙН БОДЛОГО

ХАБЭМ-ийн бодлогын зорилтуудыг хүлээн зөвшөөрүүлэх үүднээс ажил олгогч уг бодлогыг ажилтнуудтай мэдээлэл солилцож, хэлэлцсэний үндсэн дээр боловсруулах ёстой. Бодлого нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- (а) [тухайн аж ахуйн нэгжид] тусгайлан зориулагдсан, түүний хэмжээ болон үйл ажиллагааны онцлогт нийцсэн байх;
- (б) товч, ойлгомжтой бичигдсэн, огноо тавьсан, ажил олгогч, эсвэл [тухайн аж ахуйн нэгжийн] энэ асуудлыг хариуцсан хамгийн өндөр албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулсан байх;
- (в) бүх ажилтанд мэдэгдсэн, үзэж танилцахад нээлттэй байх;
- (г) ач холбогдол нь алдагдаагүй байгаа эсэхийг тогтмол хянаж нягталдаг байх;
- (д) шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн сонирхсон этгээдэд танилцуулдаг байх.²⁴

Бодлогод дараах үндсэн зарчим, зорилтуудыг тусгах ёстой:

- (а) ажил, хөдөлмөртэй холбоотой бэртэл гэмтэл, өвчлөл, холбогдох бусад тохиолдлоос урьдчилан сэргийлж, [аж ахуйн нэгжийн] бүх гишүүдийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах;
- (б) ХАБЭМ-ийн хууль тогтоомж, сайн дурын хөтөлбөр, ХАБЭМ-ийн асуудлаар байгуулсан хамтын гэрээ, түүнчлэн [аж ахуйн нэгж] хэрэгжүүлэхээр амлалт үүрэг авсан бусад шаардлагын хэрэгжилтийг хангах;
- (в) ажилтнууд болон тэдний төлөөлөгчидтэй тогтмол зөвлөлдөж, ХАБЭМУТ-ны бүх хэсэгт идэвхтэй оролцуулах нөхцөлийг бүрдүүлэх;
- (г) ХАБЭМУТ-ны гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулах.

ХАБЭМУТ нь [аж ахуйн нэгжийн] удирдлагын бусад системтэй нийцтэй, эсвэл нэгдсэн байх ёстой.²⁵

ХАБЭМ-ийн бодлого нь ойлгомжтой бичигдсэн, тухайн аж ахуйн нэгжийнхээ онцлогт тохирсон байх ёстой. Бодлогын баримт бичигтэй танилцах боломжийг ажилтан бүрд олгох ёстой.²⁶ Ажилтнуудын бичиг үсгийн мэдлэг, харааны чадварын онцлогийг харгалзан шаардлагатай тохиолдолд мэдээллийг амаар хүргэх нь зүйтэй. Мөн бодлогын баримт бичгийг бүх хүнд сануулж байх зорилгоор ажлын байрны бүх хэсэгт тод харагдахуйцаар байршуулах нь зүйтэй.

24 ОУХБ: *Guidelines on occupational safety and health management systems*, 3.1 дэх хэсэг: "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн бодлого". https://www.ilo.org/global/topics/safety-and-health-at-work/normative-instruments/WCMS_107727/lang-en/index.htm

25 Өмнөхтэй адил

26 Их Британийн ХАБЭМ-ийн албаны бодлогын жишээг дараах холбоосоор үзнэ үү: <https://www.hse.gov.uk/simple-health-safety/policy/example-policy-statement.pdf> хаягаар авах боломжтой.

ЖЕНДЕРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХАНДЛАГА

Ажиллах хүчний олон янз байдал, түүний дотор хүйсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх нь эрэгтэй, эмэгтэй ажиллагчдын аюулгүй байдал, эрүүл мэндийг нэгэн адил хамгаалахад чухал ач холбогдолтой. Энэ чиглэлд тодорхой ахиц гарсан хэдий ч цаашид илүү их зүйл хийх боломж, шаардлага байгаа гэж ОУХБ үздэг. ХАБЭМ-ийн бодлого, урьдчилан сэргийлэх стратеги боловсруулахдаа хүйсийн ялгааг анхаарч үзэх нь зүйтэй.

Жендерийн мэдрэмжтэй хандлага нь эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын ялгааг хүлээн зөвшөөрч, ил тод болгох замаар ХАБЭМ-ийн эрсдэлийг оновчтой тодорхойлж, үр дүнтэй шийдэл нэвтрүүлэх боломж олгодог. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хийж буй ажил, нийгмийн үүрэг, хүлээлт, хариуцлага нь харилцан адилгүй байдгаас шалтгаалж ажлын байранд тулгарах бие махбодын болон нийгэм-сэтгэл зүйн эрсдэл нь ялгаатай байж болно. Иймд үүнд тохирсон хяналтын өөр өөр арга хэмжээ шаардлагатай болдог.

Түүнчлэн хүйсээс хамаарсан хөдөлмөрийн хуваарь, биологийн ялгаа, хөдөлмөр эрхлэлтийн хэв маяг, нийгмийн үүрэг, нийгмийн бүтэц зэрэг хүчин зүйлс нь ажлын байрны аюул, эрсдэлийн хүйсээс хамаарсан ялгарал бий болоход нөлөөлдөг гэдгийг уг хандлага хүлээн зөвшөөрдөг. Иймд энэхүү ялгарлыг харгалзан үзэж байж ХАБЭМ-ийн үр дүнтэй бодлого, урьдчилан сэргийлэх стратеги гарна.

АЖИЛТНУУДЫН ОРОЛЦОО БА ХАБЭМ-ИЙН АСУУДЛААРХ ХАМТАРСАН ХОРОО

Ажилтнуудын оролцоо нь ХАБЭМУТ-ны нэг чухал хэсэг байдаг. Ажил олгогч нь ажилтнууд болон тэдний ХАБЭМ-ийн асуудал хариуцсан төлөөлөгчидтэй ХАБЭМ-ийн бүхий л асуудал, тэр дундаа онцгой байдлын үеийн зохицуулалтын талаар зөвлөлдөж, тэднийг мэдээллээр хангах, сургах арга хэмжээ авна. ХАБЭМУТ-ны хүрээнд ажилтнууд зохион байгуулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах ажилд идэвхтэй оролцох цаг хугацаа, нөөцөөр хангагдсан байх ёстой.

Үүний тулд ажил олгогч ХАБЭМ-ийн хамтарсан хороо²⁷ байгуулж, үр дүнтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ёстой. Ингэхдээ үндэсний хууль тогтоомж, практикт нийцүүлэн ажилтны ХАБЭМ-ийн асуудал хариуцсан төлөөлөгчдийг хүлээн зөвшөөрнө. Ийм хороо нь удирдлага, ажилтны тэнцүү тооны төлөөлөгчдөөс бүрдсэн зөвлөх чиг үүрэгтэй бүтэц байх бөгөөд нийт ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах, дэмжих нийтлэг зорилготой.

Хуульд заасан, эсвэл боломжтой нөхцөлд эдгээр хороонд ХАБЭМ-ийн мэргэжилтнүүдийг оролцуулна. Хорооны гишүүд нь ихэвчлэн ажлын байрны аюул, эрсдэл, ХАБЭМ-ийн зарчим, дүрэм, журмын талаар өндөр мэдлэгтэй ажилтнууд, менежерүүд байдаг. Хороо нь аж ахуйн нэгжийн ХАБЭМ-ийн талаарх бодлого, шийдвэрт ажилтнууд идэвхтэй оролцох боломжийг олгодог. Хорооны хурлын тэмдэглэлийг хөтөлж, шийдвэрийг баримтжуулж байх ёстой. Хороо тогтмол

²⁷ ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцооны тухай ОУХБ-ын удирдамжид “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хороо”-г “үндэсний хууль тогтоомж, практикийн дагуу байгууллагын түвшинд байгуулагдан ажиллаж байгаа ажилтны ХАБЭМ-ийн асуудал хариуцсан төлөөлөгчид болон ажил олгогчдын төлөөлөгчдөөс бүрдсэн хороо” гэж тодорхойлжээ (Хуудас 19).

хугацаанд хуралдаж, ажлын байрны үзлэг шалгалт хийж байх ёстой. Хамтарсан хороо нь оролцоонд суурилсан механизм бөгөөд ХАБЭМ-ийн асуудалд тууштай хандаж буйн илрэл юм. Ийм хороо ажилладаг газарт үйлдвэрлэлийн ослын тохиолдол буурдаг. Судалгаагаар ажлын байранд оролцоонд суурилсан аргыг хэрэглэснээр ХАБЭМУТ-ны хүрээнд ХАБЭМ-ийн нөхцөл байдал (гүйцэтгэл) сайжирдаг нь тогтоогдсон бөгөөд үйлдвэрчний эвлэлтэй байгууллагуудад илүү үр дүнтэй байдаг аж. ХАБЭМ-ийн асуудлаар ОУХБ-аас гаргасан бүх хэм хэмжээнд ажилтнуудын бүрэн оролцоог хангахыг дэмждэг.²⁸

ХАБЭМ-ийн хамтарсан хороо болон (хамтын гэрээ, хэлэлцээр гэх мэт) бусад механизмын хүрээнд үр дүнтэй нийгмийн зөвшилцөл явагдахгүйгээр ХАБЭМУТ зохих ёсоор ажиллах боломжгүй. Ажилтнууд болон тэдний төлөөлөл аж ахуйн нэгжийн ХАБЭМ-ийн удирдлагад шууд оролцох болон зөвлөлдөх замаар бүрэн дүүрэн оролцох боломжтой байх ёстой. Оролцогч бүх тал тодорхой үүрэг хариуцлага хүлээхгүйгээр ХАБЭМУТ амжилттай хэрэгжих боломжгүй.

ХАБЭМ-ийн хамтарсан хороог үр дүнтэй ажиллуулахын тулд мэдээлэл, сургалтыг хангалттай зохион байгуулах, нийгмийн зөвшилцлийн болон харилцаа холбооны үр нөлөөтэй механизм бий болгох, ажилтнууд болон тэдний төлөөллийг ХАБЭМ-ийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцуулах нь чухал юм. Гадаад оролцогч талууд (жишээ нь, хууль, хяналтын байгууллагууд, туслан гүйцэтгэгчид, ойр орчмын иргэд, байгууллагууд, үйлчлүүлэгчид, хэрэглэгчид) ч мэдээлэл, харилцаа холбооны арга хэмжээний хэрэгжилтэд оролцох ёстой.

ХАБЭМ-ийн сургалтыг менежерээс эхлээд ажилтан хүртэлх бүх түвшинд зохион байгуулах нь ХАБЭМ-ийн хөтөлбөр үр дүнтэй хэрэгжих чухал хүчин зүйл болдог. ХАБЭМ-ийн тогтолцооны талаарх мэдлэгийг бататгахын тулд уг сургалтыг тогтмол зохион байгуулах нь зүйтэй. Сургалтын материалыг аж ахуйн нэгжид гарсан аливаа өөрчлөлтийг тусган тухай бүрд шинэчилж байх хэрэгтэй.

ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хариуцлага ба эгэх хариуцлага: Ажил олгогч нь ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах эцсийн хариуцлагыг хүлээж, ХАБЭМ-ийн үйл ажиллагаанд манлайлна. Түүнчлэн ХАБЭМ нь шугаман удирдлагын үүрэг хариуцлага болохыг бүх түвшинд ойлгуулж, хүлээн зөвшөөрүүлнэ.

Чадамж²⁹ ба сургалт: Ажил олгогч нь ХАБЭМ-ийн чадамжийн шаардлагуудыг тодорхойлно. Мөн холбогдох ажилтнууд аюулгүй байдал, эрүүл мэндийн чиглэлээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх чадамжтай байхад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Бичиг баримтжуулалт: Аж ахуйн нэгжийн хэмжээ, үйл ажиллагааны онцлогийг харгалзан ХАБЭМ-ийн шаардлагатай баримт бичгүүдийг бүрдүүлэх, хадгалах, хянан үзэх, шаардлагатай тохиолдолд шинэчлэх арга хэмжээг авах ёстой.

²⁸ Ялангуяа ОУХБ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай 155 дугаар конвенц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай 1981 оны 164 дүгээр зөвлөмж болон ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцооны тухай ОУХБ-ын удирдамж.

²⁹ ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцооны тухай ОУХБ-ын удирдамжид чадамж эзэмшсэн хүнийг “тодорхой ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах сургалтад хамрагдаж, хангалттай мэдлэг, туршлага, ур чадвар эзэмшсэн хүн” хэмээн тодорхойлжээ (Хуудас 19).

Эдгээр баримт бичгийг холбогдох бүх ажилтанд танилцуулах бөгөөд хэрэглэхэд нээлттэй байх ёстой. Дараах чиглэлийн баримт бичгүүд байж болно: ХАБЭМ-ийн бодлого болон чиг үүргийн хуваарилалт, ажлын байрны томоохон аюул, эрсдэл, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээ (эрсдэлийн үнэлгээ); ХАБЭМ-ийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны бүртгэл (ажлын байрны үзлэг шалгалт); ажил, хөдөлмөртэй холбоотой бэртэл гэмтэл, өвчин, бусад тохиолдол; ХАБЭМ-ийн үндэсний хууль тогтоомж; эрүүл мэндийн тандалт, судалгааны дүн; ажлын байрны орчны илрүүлэлт, хяналтын бүртгэл; техникийн болон захиргааны дүрэм, журам, зааварчилгаа, холбогдох бусад дотоод баримт бичиг.

Харилцаа холбоо: Аж ахуйн нэгж нь ХАБЭМ-тэй холбоотой асуудлаар дотооддоо, болон гадагш харилцах, харилцаа холбоог хүлээн авах, бүртгэх, зохих хариу өгөх журам, зохицуулалтыг бий болгоно. Мөн дотооддоо ажлын байрны холбогдох түвшин, нэгж хооронд ХАБЭМ-ийн асуудлаар харилцах, мэдээлэл солилцох, ажилтнууд болон тэдний ХАБЭМ-ийн асуудал хариуцсан төлөөлөгчдийн санал, санаачилга, хүсэлтийг хүлээн авах, судлах, шийдвэрлэх механизмыг бий болгох шаардлагатай.

ТӨЛӨВЛӨЛТ БА ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Эхний үнэлгээ: ХАБЭМУТ-ны удирдлага, зохион байгуулалтыг анхны үнэлгээгээр дүгнэж, тасралтгүй сайжирч буй эсэхийг харьцуулан хэмжих суурь мэдээллийг бүрдүүлэх шаардлагатай. Ийм тогтолцоо байхгүй тохиолдолд анхны үнэлгээ нь үүнийг бий болгох үндэс болно. Үнэлгээг зохих чадамжтай хүмүүс ажилтнууд болон/эсвэл тэдний төлөөлөгчидтэй зөвлөлдөх замаар гүйцэтгэнэ.

Тогтолцоог төлөвлөх, хөгжүүлэх, хэрэгжүүлэх: Төлөвлөлтийн зорилго нь дараах чиглэлүүдийг дэмжих ХАБЭМУТ-г бүрдүүлэхэд оршино.³⁰ Үүнд:

- ▶ үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;
- ▶ [аж ахуйн нэгжийн] ХАБЭМУТ-ны бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэх;
- ▶ ХАБЭМ-ийн нөхцөл байдлыг тасралтгүй сайжруулах.

ХАБЭМ-ийн төлөвлөлтийг зохистой бөгөөд шаардлага хангасан байдлаар зохион байгуулахын тулд анхны болон удаах үнэлгээнүүдийн дүн, бусад боломжит мэдээлэлд үндэслэнэ. Ийм төлөвлөлт хийх зохицуулалт нь ажлын байранд аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалахад чиглэж, ХАБЭМУТ-ны бүх бүрэлдэхүүн хэсгийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх ажиллагааг багтаасан байх ёстой.

ХАБЭМ-ийн зорилтууд: ХАБЭМ-ийн бодлого, эхний болон удаах үнэлгээнүүдийн үр дүнд тулгуурлан тухайн ажлын байрны онцлогт тохирсон хэмжигдэхүйц зорилт, шаардлагуудыг тодорхойлно. Эдгээр нь үндэсний хууль тогтоомжид нийцсэн, ажилтнуудын ХАБЭМ-ийн хамгаалалтыг тасралтгүй сайжруулах чиглэлтэй, бодитой, хүрч болохуйц байхын зэрэгцээ, бичгээр томъёолж холбогдох алба, түвшинд хүргэсэн, тогтмол үнэлж, шаардлагатай тохиолдолд шинэчилдэг байх ёстой.

³⁰ ОУХБ: *Guidelines on occupational safety and health management systems*, 3.8 дахь хэсэг: “Тогтолцоог төлөвлөх, хөгжүүлэх, хэрэгжүүлэх”.

Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндэд хохирол учруулж болох аюул, эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийн үнэлгээг тогтмол хийн, эрсдэлийг хянах шатлалын дагуу урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах шаардлагатай. Аюулаас урьдчилан сэргийлэх, хянах журам буюу зохицуулалт нь дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- ▶ тухайн аж ахуйн нэгжид буй аюул, эрсдэлд тохируулан боловсруулсан байх;
- ▶ тогтмол хугацаанд үнэлж, шаардлагатай тохиолдолд шинэчилдэг байх;
- ▶ үндэсний хууль тогтоомжид нийцсэн, сайн туршлагад тулгуурласан байх;
- ▶ одоо байгаа мэдлэг, мэдээлэл, түүний дотор хөдөлмөрийн хяналтын байгууллага, ХАБЭМ-ийн албад, холбогдох бусад байгууллагын тайлан, мэдээллээс тусгасан байх.

ҮНЭЛГЭЭ

ХАБЭМ-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлд тогтмол хяналт-шинжилгээ хийх, хэмжих, бүртгэх журам боловсруулж, хэрэгжүүлэх, мөн уг журмаа тогтмол хугацаанд хянан шинэчилж байх шаардлагатай. Удирдлагын бүтцийн бүх түвшинд хяналт-шинжилгээтэй холбоотой хариуцлага, эрх мэдлийг тодорхой хуваарилж, удирдлагыг үүрэгжүүлэх ёстой.

Ажил, хөдөлмөртэй холбоотой бэртэл гэмтэл, өвчин, бусад тохиолдол, тэдгээрийн ХАБЭМ-ийн нөхцөл байдалд үзүүлж буй нөлөөллийг судалж, ХАБЭМУТ-нд буй алдаа, дутагдлыг илрүүлж, баримтжуулах шаардлагатай. Ийм судалгааг ажилтнууд болон тэдний төлөөлөгчдийн оролцоотойгоор зохих чадамж эзэмшсэн хүн хийнэ. ХАБЭМ-ийн хамтарсан хороотой газарт хороо нь судалгааны үр дүнг хянан, зохих зөвлөмж гаргах үүрэгтэй. Судалгааны мэдээлэл, зөвлөмжийг холбогдох талуудад хүргүүлж, нөхцөл байдлыг засаж залруулах арга хэмжээ авахад ашиглана. Мөн тэдгээрийг удирдлагын үнэлгээнд тусган ХАБЭМ-ийн нөхцөл байдлыг тасралтгүй сайжруулахад анхаарах шаардлагатай.

АУДИТ

Аудит нь тухайн үйл явцад мэргэжлийн, хараат бус этгээд (хувь хүн, баг) хяналт-шинжилгээ хийхийг хэлнэ. Тогтмол аудит нь ХАБЭМУТ болон түүний бүрэлдэхүүн хэсгүүд бүрэн хэрэгжиж байгаа эсэх, мөн ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах, осол, бусад тохиолдлоос урьдчилан сэргийлэхэд хангалттай, үр нөлөөтэй байгаа эсэхийг тодорхойлоход тусалдаг. Аудит нь тогтолцооны гүйцэтгэлийг цаг хугацааны туршид хэмжих арга хэрэгсэл болж, засах арга хэмжээ санал болгох, цаашид сайжруулах шинэ зорилтуудыг тодорхойлох боломж олгодог.³¹

31 Америкийн Нэгдсэн Улсын Хөдөлмөрийн департаментын ХАБЭМ-ийн Удирдах газрын ашигладаг аудитын загварыг ("Safety and health program audit tool") дараах холбоосоор үзнэ үү: https://www.osha.gov/shpguidelines/docs/SHP_Audit_Tool.pdf

ХАБЭМУТ-ны бүрэлдэхүүн хэсэг бүрд тогтмол аудит хийх зохицуулалт бий болгож, тогтолцооны нийт гүйцэтгэл, үр нөлөөг үнэлэх шаардлагатай. Аудитын бодлого, хөтөлбөрийг боловсруулж, үүнд аудит хийх эрх бүхий этгээдийн мэдлэг, ур чадварын шаардлага, аудитын хамрах хүрээ, давтамж, аргачлал, тайлагнах журам зэргийг тусгах ёстой.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД³²

ХАБЭМ-ийн шалгуур үзүүлэлтүүд нь зөвхөн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо, ажлын байран дахь аюул, эрсдэлийн илрэл, удирдлагын байдал зэргээр хязгаарлагдахгүй.

Эдгээр шалгуур үзүүлэлтийн тусламжтайгаар ХАБЭМУТ-ны үр нөлөөг олон талаар хэмжих шаардлагатай. Тухайлбал, ХАБЭМ-ийн хамтарсан хороо, түүний үр дүн (хуралдсан тоо, гаргасан шийдвэрийн тоо гэх мэт), сургалтын материалын шинэчлэл, хууль тогтоомжийн зөрчлийг шийдвэрлэсэн байдал, эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрүүд, аюулгүй ажиллагааны сайн дурын стандартыг нэвтрүүлсэн байдал, ойлголт, мэдлэг нэмэгдүүлэх аян зэрэг байж болно. Удирдлагын хяналт, үнэлгээг тогтмол хийж, ХАБЭМУТ-ны ерөнхий стратегийг үнэлэн төлөвлөсөн гүйцэтгэлийн зорилтууд болон ажлын байрны хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг тодорхойлох шаардлагатай. Энэ хүрээнд үнэлгээнд хамрагдах хугацаанд хамаарах мэдээлэл, авсан арга хэмжээ, мөн гүйцэтгэлийг сайжруулах, тавьсан зорилтууддаа хүрэхийн тулд өөрчлөх шаардлагатай гэж үзсэн зүйлүүд, нэн тэргүүнд анхаарах асуудлуудыг авч үзэх ёстой.

► 4.3 ХАБЭМ-ИЙГ ТАСРАЛТГҮЙ САЙЖРУУЛАХ

Урьдчилан сэргийлэх болон засаж залруулах арга хэмжээ: ХЭМАБУТ-ны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, хэмжилт, аудит, үнэлгээний үр дүнд үндэслэн урьдчилан сэргийлэх болон засаж залруулах арга хэмжээ авах зохицуулалт бий болгож, тогтвортой хэрэгжүүлэх шаардлагатай. Хэрэв үнэлгээгээр урьдчилан сэргийлэх болон хамгаалах арга хэмжээ хангалтгүй байгаа нь тогтоогдвол тухайн ажил, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дахин үнэлж, (эрсдэлийг хянах шатлалын дагуу) засаж залруулах арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлж, баримтжуулах ёстой.

ХАБЭМУТ болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг тасралтгүй сайжруулах зохицуулалтыг тогтолцооны зорилт, мөн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн хүрээнд цуглуулсан мэдээлэл, өгөгдөлд үндэслэн боловсруулах ёстой. Үүнд үнэлгээ, гүйцэтгэлийн хэмжилт, судалгаа, удирдлагын хяналт, үнэлгээний үр дүн, аудитын зөвлөмж, үндэсний хууль тогтоомж болон хамтын гэрээнд орсон өөрчлөлт, шинэ мэдээлэл, ажлын байрны үйл ажиллагаанд гарсан техникийн болон захиргааны шинжтэй томоохон өөрчлөлт, эрүүл мэндийг хамгаалах, дэмжих хөтөлбөрийн үр дүн зэрэг орно. Мөн ХАБЭМ-ийн үйл явц, гүйцэтгэлийг аюулгүй байдал, эрүүл мэндийг сайжруулах чиглэлийн бусад хүчин чармайлттай харьцуулан үнэлэх шаардлагатай.

³² Өмнөх “Хяналтын арга хэмжээний үр дүнд хяналт-шинжилгээ хийх” хэсгийг үзнэ үү.

ХАБЭМУТ нь аж ахуйн нэгжийн түвшинд ХАБЭМ-ийн нөхцөл байдлыг тасралтгүй сайжруулахад чиглэсэн логик, үр дүнтэй хэрэгсэл юм. ХАБЭМУТ-г хуульчлахаас эхлээд сайн дураар нэвтрүүлэх хүртэл олон янзын аргаар дэмжиж байна. Уг тогтолцоог амжилттай хэрэгжүүлэх гол хүчин зүйлс нь удирдлагын итгэл үнэмшил, ажилтнуудын идэвхтэй оролцоо юм. Аж ахуйн нэгжид ХАБЭМ-ийг сайжруулах тогтвортой механизм бүрдүүлэх зорилгоор ХАБЭМ-ийн үндэсний хөтөлбөртөө уг удирдлагын тогтолцоог суулгаж буй улс орнуудын тоо нэмэгдсээр байна.

ХАБЭМ-ийг бүх түвшинд сайжруулах шаардлагатайг олон улсын түвшинд улам өргөн хүрээнд ойлгох болж, олон улсын нийлүүлэлтийн сүлжээгээр³³ тархаж байна. Үүний үр дүнд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин зайлшгүй тохиолддог гэсэн хуучин итгэл үнэмшлийг шинэ үзэл баримтлал сорьж эхэллээ. Vision Zero сан³⁴ нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаант нас баралт, хүнд гэмтэл, өвчний тоог тэг болгох зорилгоор ХАБЭМ-ийн арга барил, нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна.

► **Зураг 19. "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин зайлшгүй тохиолддог" гэсэн хуучин итгэл үнэмшил эвдэгдэж байна**



33 "Олон улсын нийлүүлэлтийн сүлжээ" гэдэг нь түүхий эдээс эхлээд хөгжүүлэлт, үйлдвэрлэл, хүргэлтийн янз бүрийн үе шатыг дамжин бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэх, хэрэглэгчдэд хүргэхэд шаардлагатай үйл ажиллагааг хил дамнан зохион байгуулахыг хэлнэ.

34 ОУХБ-ын Vision Zero сан нь "засгийн газрууд, ажил олгогчийн болон ажилтны төлөөллийн байгууллагууд, компаниуд болон бусад оролцогч талуудыг нэгтгэн, олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд ажил, хөдөлмөртэй холбоотой ноцтой болон амь насанд хүрэх осол, гэмтэл, өвчлөлийг тэг болгох алсын харааг хамтран хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг". (<https://www.ilo.org/global/about-the-ilo/how-the-ilo-works/departments-and-offices/governance/labadmin-osh/programmes/vzf/lang--en/index.htm>).

▶ САЙЖРУУЛАХ САНАЛЫН ЖАГСААЛТ

Эрсдэлийн үнэлгээ	
1.	
2.	
3.	
4.	
5.	

Ажлын байранд ХАБЭМУТ нэвтрүүлэх	
1.	
2.	
3.	
4.	
5.	

- ▶ Яаралтай, өндөр эрсдэлтэй үйл ажиллагааг тодорхойлох.
- ▶ Түргэн хэрэгжүүлж болох үр дүнтэй арга хэмжээг дараах асуултуудыг асуух замаар тодорхойлно:
 - ▶ Сайжрах магадлал хэр байгаа вэ?
 - ▶ Одоо шууд хэрэгжүүлж эхлэх боломжтой юу?
 - ▶ Их хэмжээний хөрөнгө оруулалтгүйгээр хэрэгжүүлэх боломжтой юу?
 - ▶ Сарын дотор эхний үр дүн гарах боломжтой юу?
- ▶ Санаа бүрийг дээрх асуултын дагуу 0, 1, 2 од*-оор урамшуулна.
- ▶ 6-10 сайжруулах санааг сонгоно.
- ▶ Багаараа эдгээр санааг ярилцаж, тохирно.
- ▶ "Богино хугацаанд амжилттай хэрэгжүүлэх" арга хэмжээг одоор үнэлсэн үнэлгээний дагуу хэлэлцэж сонгоно.
- ▶ Доор оруулсан аж ахуйн нэгжийг сайжруулах төлөвлөгөөний загварын дагуу нэн тэргүүнд хэрэгжүүлэх санаа, үйл ажиллагааг тэмдэглэнэ.

АЖ АХУЙН НЭГЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР

Examples						
Д/д	Төсөл, үйл ажиллагаа	Хариуцах хүн	Шалгуур үзүүлэлт	Эхлэх огноо	Хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн огноо	Хэрэгжүүлж дууссан огноо
ХАБЭМ-ийн хамтарсан хороо байгуулах						
1.1	ХАБЭМ-ийн хамтарсан хорооны бүрэлдэхүүнийг тогтох асуудлаар хэсгийн үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгчдийг гурван захиралтай уулзуулах	Хүний нөөцийн асуудал хариуцсан захирал	- Хоёр уулзалт хийгдэж, шийдвэрийг баримтжуулсан байна. - Уулзалт бүрийн ирц 90-ээс доошгүй хувь байна.	11/1/10	11/3/10	11/2/26
1.2	Хорооны ажилд зарцуулах төсөв, хугацааг тодорхойлох	Хүний нөөцийн асуудал хариуцсан захирал	Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгчид болон захирлуудын уулзалтад саналыг бичгээр танилцуулсан байна.	11/1/10	11/3/10	11/2/21
Эрсдэлийг үнэлэх						
2.1	Туршилтын журмаар эрсдэлийн үнэлгээнд үйлдвэрийн аль хэсгийг хамруулахыг тодорхойлох	Үйлдвэрлэлийн менежер/ХАБЭМ хариуцсан ахлагч	Хоёр уулзалт хийгдэж, шийдвэрийг баримтжуулсан байна.	11/1/10	11/1/12	11/2/14
					Тайланг захирлууд болон үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгчдийн дараагийн уулзалтад танилцуулна.	

► ХЭРЭГЦЭЭТ ХОЛБООС

Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ). 2014. Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх талаар ажил олгогч, ажилтан болон тэдгээрийн төлөөлөлд зориулсан 5 үе шаттай гарын авлага (Женев). Үүнд: https://www.ilo.org/global/topics/safety-and-health-at-work/resources-library/publications/WCMS_232886/lang--en/index.htm.

----. Үйл ажиллагааны хяналтын хуудас: Галын аюулгүй байдал (Женев). Үүнд: https://www.ilo.org/wcmsp5/groups/public/-ed_protect/---protrav/---safework/documents/publication/wcms_194782.pdf.

----. 2012. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн нэвтэрхий толь бичиг (Женев). <https://iloencyclopedia.org/> хаягаас авах боломжтой.

----. 2013. ЖДҮ-д зориулсан ажлын байрны эрсдэлийн үнэлгээ, менежментийн багц сургалтын багц (Женев). Үүнд: https://www.ilo.org/global/topics/safety-and-health-at-work/source-library/training/WCMS_215344/lang--en/index.htm.

----. 2016. Хувийн хамгаалах хэрэгсэл нь таныг аюулгүй, эрүүл байхад тусална (Женев). Үүнд: https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_dialogue/---lab_admin/documents/instructionalmaterial/wcms_537874.pdf.

----. 2017. Үр ашигтай үйл ажиллагааны хяналтын хуудас, in Global Manual for WISE: Work Improvements in Small (Женев), х. 8. https://www.ilo.org/wcmsp5/groups/public/-ed_protect/---protrav/---safework/document/instructionalmaterial/wcms_621054.pdf хаягаас авах боломжтой.

----. 2020. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд – Хөдөлмөрийн байцаагч болон бусад оролцогч талуудад зориулсан гарын авлага (Женев). Үүнд: <https://www.ilo.org/global/topics/labour-administration-inspection/resources-library/publications/guide-for-labour-inspectors/lang--en/index.htm>.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ). 2020. Эрүүл мэндийн сэдэв: Хөдөлмөрийн эрүүл мэнд (Женев). Үүнд: <https://www.who.int/health-topics/occupational-health>.

► ХАВСРАЛТ I:**АЖЛЫН БАЙРАНД БОЛСОН ТОХИОЛДЛЫГ МЭДЭЭЛЭХ МАЯГТЫН ЗАГВАР**

Заавар

Ажлын байранд тохиосон гэмтэл, өвчин, аюултай тохиолдол, осолд дөхсөн тохиолдлыг мэдээлэхэд энэ маягтыг бөглөнө. Бөглөсөн маягтыг дараах хаягаар илгээнэ үү:

Энэ маягтыг дараах тохиолдлуудыг бүртгэхэд ашиглагдана (хамаарах бүх зүйлийг тэмдэглэнэ үү):

- ☐ Үйлдвэрлэлийн осол
- ☐ Мэргэжлээс шалтгаалсан өвчин
- ☐ Аюултай тохиолдол
- ☐ Осолд дөхсөн бусад тохиолдол

Өртсөн хүний мэдээлэл - *Боломжтой бол гэмтсэн/оролцсон хүнээр бөглүүлнэ.*

Маягт бөглөсөн хүний нэр: _____

Хүйс: _____ Төрсөн огноо: _____ Ажилд орсон огноо: _____

Албан тушаал: _____ Нэгж: _____

Шууд удирдаж ажилладаг хүний нэр: _____

Тохиолдол болсон огноо, цаг: _____

Үйл явдал яг хаана тохиолдсон бэ? _____

Оролцсон/хамт байсан хүмүүс: _____

Тохиолдсон үйл явдлыг аль болох тодорхой бичнэ үү. Жишээ нь:

- холбогдох бодисын нэр;
- холбогдох машин техник, тээврийн хэрэгслийн нэр, төрөл;
- осолд хүргэсэн үйл явдлууд;
- оролцсон хүмүүсийн гүйцэтгэсэн үүрэг.

Хэрэв хүн гэмтсэн бол тухайн хүн юу хийж байсныг дэлгэрэнгүй бичнэ үү. Уг явдлаас хойш үүнэй төстэй тохиолдол гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан бичнэ үү. Шаардлагатай бол тусдаа цаасан дээр бичнэ үү.

Гэрчүүд: _____

Зөвхөн үйлдвэрлэлийн осол, эсвэл мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдолд бөглөнө.

Гэмтэл/өвчний төрөл: _____

Ажлаас түр чөлөөлөгдсөн, бэртэж гэмтсэн болон анхны тусламж авсан шалтгаан: _____

Эмнэлгийн тусламж шаардагдсан уу? Тийм бол эмнэлэг/эмчийн нэр: ☐Тийм ☐Үгүй

Ажилтны гарын үсэг: _____ Огноо: _____ Шууд

удирдаж ажилладаг хүний гарын үсэг: _____ Огноо: _____

▶ **Эрсдэлийн үнэлгээ:**

Ажлын байрны үйл ажиллагаа:..... Эрсдэлийн үнэлгээ хийсэн огноо:.....

Ямар аюул байна вэ?	Хэн, хэрхэн хохирч болох вэ?	Одоо хяналтын ямар арга хэмжээ авч байгаа вэ?	Арилаагүй үлдсэн эрсдэл юу байна вэ?	Энэ эрсдэлийг хянахын тулд нэмж хийх зүйл байгаа юу?	Хариуцаж хэрэгжүүлэх хүн	Хэрэгжүүлсэн байх хугацаа	Хэрэгжүүлсэн хугацаа

ОУХБ энэхүү загварыг Их Британийн ХАБЭМ-ийн албанаас нийтэлсэн мэдээлэлд үндэслэн боловсруулсан бөгөөд Их Британийн Засгийн газрын v1.0 лицензийн дагуу ашигласан болохыг мэдэгдэж байна.

Хэрэгжүүлсэн хугацаа				
Хэрэгжүүлсэн байх хугацаа				
Хариуцаж хэрэгжүүлэх хүн				
Энэ эрсдэлийг хянахын тулд нэмж хийх зүйл байгаа юу?				
Арилаагүй үлдсэн эрсдэл юу байна вэ?				
Одоо хяналтын ямар арга хэмжээ авч байгаа вэ?				
Хэн, хэрхэн хохирч болох вэ?				
Ямар аюул байна вэ?				


► ХАВСРАЛТ III:

Галын аюулгүй байдлыг хангах арга хэмжээний хяналтын хуудас https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_protect/---protrav/---safework/documents/publication/wcms_194782.pdf

► ХАВСРАЛТ IV:

WISE буюу Жижиг аж ахуйн нэгжид ХАБЭМ-ийг сайжруулах олон улсын сургалтын гарын авлага, Үйл ажиллагааны хяналтын хуудас, 8 дугаар хуудас: https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_protect/---protrav/---safework/documents/instructionalmaterial/wcms_621054.pdf

ОУХБ-ын донор байгууллагууд



Олон улсын хөдөлмөрийн байгууллага
НҮБ-ын байр, 604 тоот
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар -14201, Монгол Улс



+976- 11320624



ulaanbaatar@ilo.org



ilo.org/mongolia



Олон улсын хөдөлмөрийн байгууллага- International
Labour Organization



[@ilo_mongolia](https://twitter.com/ilo_mongolia)